

ХҮҮХДҮҮДДЭЭ БИЧСЭН ЗАХИДАЛ

Өнөөдөр амралтын өдөр. Аав нь эдүгээ Францад хүүхдүүдээсээ алс тэртээ, бараг 8000 кмт байна. Цагийн зөрүү их тул миний хүүхдүүд өдийд сайхан зүүд зүүдлэн нойрсоцгоож байгаа болов уу. Хорвоогийн наран Монгол нутагт минь мандах агшинд хүүхдүүд минь сэрцгээж, хичээл сургуульдаа явна. Харин өдөр гэртээ харьж ирээд аавынхаа бичсэн захиаг унших болно. Тэгээд аавтайгаа түр зуур ч болов уулзах шиг болох буй заа. Харийн нутагт та нарыгаа санаж байгаа болоод ч тэр үү, бага балчир насны чинь дурсамжуудаас сэтгэлд тодхон орж ирлээ. Аав нь бас эцэг эхээ, бага насаа эргэн санаж байна.

Би хүүхдийг Бурхан хүмүүс бидэнд илгээж буй бэлэг гэж үздэг. Иймд тэднийг тосон авч байгаа хүмүүн бид яах ёстой вэ гэж бодсоор их хайр элбэрэл дунд өсгөж торниулах ёстойг ойлгосон юм. Хүүхдүүд аливаа зүйлийн учрыг гүйцэд ухаарч амжаагүй балчир насандаа аз жаргал дүүрэн байх учиртай. Хүн бүрийн хүүхэд насны дурдамж сайхан байгаасай гэж аав нь дандаа хүсдэг. Миний мэргэн ардууд “хүүхдийг 5 нас хүртэл нь хаан мэт, 18 нас хүртэл нь цэрэг мэт харин 18 наснаас нь эхлэн найз нөхөр мэт харьцах учиртай” гэж сургасан тул та нарыг бор гэртээ богд байлгахын тулд аав нь ихэд хичээн чухамдаа та нарын тааллаар л байдаг байлаа. Гэхдээ миний хүүхдүүд буруу эрхэлбэл би сайн тайлбарлаж ойлгуулахаас бус та нарыг



Шувуу

зоддоггүй байсан. Хийжүүлсэн ундаа, чихэрлэг зүйл шүдэнд муу гэж сайн хэлж ойлгуулсан тул та нар маань кола, фанта зэрэг ундааг бараг уухгүй, чихэр их иддэггүй. Аав нь хүүхдүүдээ ерөөсөө загнаж аашлахгүй, дандаа магтан сайшааж, бурмаар

бус, урмаар тэтгэж ихэд хайрлан энхрийлж өсгөсөн дөө. Хүүхэд насанд

чинь тохирсон төрөл бүрийн тоглоомоор бид байнга тоглодог байсан сан. Хүүхдүүдээс маань зарим нь байлдаж тоглох дуртай байхад бас аавынхаа хүзүүн дээр суух дуртай хүүхэд ч бий.

Бид өөрсдөө тоглоом зохиож “хөб лаа”, “дүүжин даажин”, “шувуу” “морь” “цаг”, “сармагчин” гэж нэрлэнэ. Аав нь та нарыгаа эрхлүүлэн тоглуулахын тулд шалан дээр дээш харан хөл гараа өргөн хэвтдэг байсныг санаж байна уу? Намайг шалан дээр хэвтэж, хоёр хөлөө хоёр гартайгаа нэгэн зэрэг дээш өргөхөд та нар ээлжлэн гарч сууна, ингэхэд нь би нисгэх гэж байгаа юм шиг эргэлдүүлэн хөдөлгөхөд шувуу болж тоглолоо гэж учиргүй баярлацгаан инээлдэн баясдаг сан. Би та нарыг агаарт дээш



Сармагчин



Цаг

хөөргөх мэт өргөснөө доош нь яг л унагах гэж байгаа юм шиг болгоод барьжавахдаа “хөб лаа, хөб лаа” гэнэ. Үүнд бас их дуртай, байсхийгээд л аав аа хөб лаа гэж тоглоё гэцгээнэ. Аавыгаа морь болгож унахад нь би зөөлөн мөлхөх буюу заримдаа цогих мэт хөдөлгөөн хийнэ. Хүзүүн дээр минь ээлжлэн суухад нь би унагах гэж байгаа юм шиг хоёр тийш нь дайвалзуулахад унахгүй тогтож үлдэх гэж ихэд мэрийхдээ үснээс минь чангахан зуурч авдаг сан. Би та нарыг өөд өөдөөс нь харуулан хүзүүн дээрээ мордуулж ийш тийш хурдлан гүйхэд инээлдэх

гэж жигтэйхэн. Мөн хоёр гар, хоёр хөлнөөс нь зэрэг бариад эргэлдүүлэхийг



Морь унах

тоглоёо гэж гуйх бүрийд би дуртайяа тоглодог байлаа. Та нартай тоглохдоо би өчүүхэн ч цааргалдаггүй байж билээ. Аав нь гэрийнхээ шалан дээр мөн ч олон удаа дээш доош харж хэвтэж бас мөлхсөн дөө. Энэ нь та нарыгаа хаан мэт байлгах гэсэн санаа минь юм.

Би хүүхдүүдээ байнга л магтдаг. Миний хүүхэд хүмүүжүүлэх гол арга энэ юм. Би та нарт миний хүүхдүүд өхөөрдөм хөөрхөн, хамгийн сайн, хичээлдээ онц сурдаг, ийм хүүхдүүд өөр хаана ч байхгүй, аав



Дүүжин даажин

нь та нартаа их хайртай гэж хэлээд нэг бүрчлэн үнсэхэд бүгд л урам зориг дүүрэн болж ирдэг сэн. Ийм хөөрхөн хүүхдүүдтэй учраас аав нь хүнтэй дуугарахгүй ээ гэж намайг өхөөрдөн байж хэлээд дараа нь “аав нь яах билээ” гэж асуухад уралдан байж “хүнтэй дуугарахгүй” гэж хариулцгаадаг

байж билээ.

Герман ардын нэг сайхан үг байдаг юм л даа.

“Та хүүхдээ магтаж амжсан уу?”

гэсэн асуулт юм шиг, тэгсэн атлаа анхааруулга, сануулга мэт энэ үгийг дуулсан хэн бүхэн хүүхдээ магтахгүй байх аргагүй.

Америкийн алдарт зохиолч Марк Твэйн “Би ганц магтаалын үгэнд гурван сар амьдарч чадна” гэж хэлсэн нь хүнд магтаал сайшаал хичнээн их урам зориг өгдөг болохыг илтгэнэ. Хүүхдүүд минь зураг зурах авъяастай тул аав нь та нарынхаа зурсан олон хөөрхөн зургаар ажлын өрөөгөө чимдэг.

Бяцхан хүүхдүүдээ хараад миний ажлын ачаалал, дарамт бүрэн мартагдаж, бас ядаргаа арилдаг болохоор гэртээ орж ирэх бүртээ аав нь аз жаргалтай болдог.

Аав нь хүүхдэд их хайртайг та нар минь одоо юу юунаас илүү мэдэх болсон. Хүүхдийг гэх миний хайр ээж, аавын минь энэрэл хайраас

эхтэй. Аав нь энэ агшинд өөрийн эцэг эхээ эрхгүй санан дурсаж сууна.

Хүүхдүүд минь өвөө, эмээгийнхээ талаар сайн мэдэж байх учиртай. Энэ талаар дараачийн захидалд тодорхой бичье.

Одоо Франц улсын талаар багахан сонирхуулья. Франц бол сайхан орон. Франц улс дэлхийн аж үйлдвэр хөгжсөн тэргүүлэгч улс



юм. Төрийн үйл ажиллагаа тунгалаг байх зарчмыг улс төрийн амьдралдаа нэвтрүүлсэн иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой Хүний



ба Иргэний эрхийн тунхаглал болон Үндсэн хуулиараа иргэдийн хувийн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан улс орон гэдгээр нь бахархахаас өөр аргагүй. Нийслэл Парис хот дэлхийн оюуны соёлын томоохон төв юм. Франц үндэстнийг

хүн төрөлхтөний оюуны соёлын түүхэнд жинтэй хувь нэмэр оруулсан ард түмний нэгэнд зүй ёсоор тооцдог. Дэлхийд алдартай олон үзвэрийн газартай. Эндэхийн төдийгүй дэлхийн алдартай үзмэрүүдийн нэг нь Луврын музей билээ. Аав нь хэдэн жилийн өмнө үзэж байсан Луврын музейг дахин үзэхээр боллоо.

Аав нь “миний хүүхдүүд хамгийн хөөрхөн, хамгийн сайн, бүгдээрээ хичээлдээ онц сурдаг, ийм хүүхдүүд өөр хаана ч байхгүй. Энэ дэлхийн хамгийн хөөрхөн хацар, ам, хамар, нүд, толгой, хамгийн хөөрхөн хөл, гар миний хүүхдүүдэд л бий” гэж та нарыгаа бага байхад чинь үнсэн байж эрхлүүлэхдээ хэлдэг байсан үгээр захидлаа дуусгая.

Түр баяртай. Та нартаа маш их хайртай.

Франц



Аав нь Луврын музейг үзсэн талаараа сонирхуулъя. Лувр гэдэг нь “Чонын ой” (Luparia, Louyerie) гэсэн үг аж. Америкийн Ерөнхийлөгч асан Ж.Кеннеди Луврын музейг үзээд “Амьдралдаа ядаж нэг удаа Луврын музейг заавал үзэх хэрэгтэй юм байна. Үүнийг үзсэнээр л урлагийн бүтээл гэж ямар гайхамшигтай зүйл болохыг зүрх сэтгэлээрээ мэдэрч чадлаа. Харин энэ бүхэн хүний гараар бүтсэн гэхэд үнэхээр гайхамшигтай. Хүн хамгийн

хүчирхэг гэдэг нь эндээс харагдаж байна. Тэр тусмаа Франц улсын соёл иргэншлийн түүх өнө эртний баялаг юм” гэсэн байдаг. Миний хүүхдүүд Луврын музейг заавал үзээрэй. Музейн барилга нь хүртэл урлагийн гайхамшигт бүтээл агаад энд Францын хаадуудын шилтгээн байрладаг байжээ.

Францын ерөнхийлөгч Франсуа Миттераны шийдвэрээр Луврыг шинэчлэн засварлаж, музейн эртний хэсгийг сэргээж, Наполеоны ордны өмнө шинэ хуучин Луврыг холбосон алдарт шилэн пирамидийг барьжээ. Энэ пирамидыг зохиогч нь хятад гаралтай америк архитектор Йох Минг Пи аж.

Амалсан ёсоор өвөө эмээгийнх нь талаар та нарт тодорхой бичье. Аав нь аав, ээж хоёрыгоо дээдлэн хайрладаг байсан нь та нарт үлгэр жишээ болох учиртай. Эмээ, өвөө хоёр нь их сайн хүмүүс байсан, миний хүүхдүүд сайн хүн болох ёстой. Аав, ээж хоёр минь ажил хөдөлмөрийн мөр хөөн анх Хатгалд ирсэн үедээ танилцан, гэр бүл болсон гэдэг. Та нар өвөөгөө сайн мэдэх хэдий ч эмээгээ бол харж ч байгаагүй. Ээж минь сайхан монгол эмэгтэй байсан юм. Нэрийг нь Сүрэнхорлоо гэдэг. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутаг Алунгоо ээжийн төрсөн Ариг, Уйлган голоор нутагтай. Арван нэгэн хүүхэд төрүүлж, өсгөхийн зэрэгцээ улс, эх орондоо хөдөлмөрлөн бас аавыг минь хайрлан халамжлах зэргээр олон зүйлийг нэг дор амжуулан хийдэг байсныг нь бодоход миний ээж ёстой “аугаа” санагддаг. Тэр үеийн ээжүүд нэгэн ижил ингэж их ачаа үүрэхдээ ер түүртэж байсангүй. Ээжийн минь тухай олон сайхан дурсамжууд байх авч тэр бүрийг бичих боломжгүй юм. Ээж минь их уран хүн байсан болохоор ажлынхаа зав чөлөөгөөр ихэнхдээ дээл, хувцас шаглаж суудаг сан. Олон хүмүүс ээжээр маань дээл эсгүүлж оёулдаг байж билээ. Ээжийн минь энэрэл хайр духан дээр минь зөөлөн үнсэх үнсэлт, миний хүү чинь ухаантай хүү шүү гэж магтах магтаал үгээр илэрдэг байж билээ. Ээжийн тухай бодол, дурсамж бүхэн надад их хайр элбэрлийг мэдрүүлдэг юм.

Аав бол Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ, Улаан-Уулын их хөвч тайгаар нутагтай дархад хүн. Аавын аавыг Дүлзэн, харин ижийг нь Цэрэнпил гэдэг байсан.

Эцэг Дүлзэн нь Зөөлөнгийн хийдэд гавж байсан. 1932 оны хэрэг явдлын үеэр өвөөг маань “хувьсгалын эсэргүү” хэмээн баривчилснаас хойш аав овгоо өөрчилж, Цэрэнпил гэж ээжээрээ овоглох болсон нь “эсэргүү”-

ний хүүхдийн эцэс төгсгөлгүй зовлонг үзэхгүй гэсэн дээ юм. Аавын минь аав шашны номыг хичээнгүйлэн суралцаж гавж мяндаг хүртсэнээр шилдэг лам нарын тоонд аргагүй багтан орсон нь эцэстээ ийнхүү гайд гарахад хүргэв.

Монголчууд коментерний даалгавраар сор болсон “хөвгүүд”-ээ хэлмэгдүүлэн хохироосон нь түүхэнд арилшгүй хар мөр болон үлдсэн юм. Хэлмэгдүүлэлтийн сүүдэр монгол айл, гэр бүрийг нөмөрсөн хар дарсан зүүд мэт тэртээх аймшигт он жилүүдийг хэн л ер эргэн санагалзахыг хүсэх билээ дээ. Энэ явдлаас болж айдас хүйдэс хургасан хэн бүхний сэтгэлд “Ардчилал” гэдэг үг эрхэм нандин агаад үнэ цэнэтэй орших болсон билээ. Миний аав их ухаантай, зөөлөн сайхан сэтгэлтэй мундаг хүн байсан нь ааваасаа эхлэлтэй гэж би боддог. Сайн хүний үр сайн хүлгийн унага гэсэн нэг утга төгөлдөр үг байдаг даа.

Аав минь үр хүүхэд биднийгээ эрүүл саруул, мөр бүтэн, хүний дайтай өсгөн өндийлгөхийн тулд ёстой юугаа ч харамлаагүй. Аав хөдөөний хүн гэж огт хэлэмгүй цэмцгэрхэн хувцасладаг, цагаан цамц, костюм пиджак голдуу өмсөж явдаг байлаа. Аав минь амьдралын их ухаантай, бас одоогийнхоор бол бизнес сэтгэлгээ сайтай хүн байсан юм. Аав тухайн цаг үедээ тохирсон бага сага наймаа хийж, үр хүүхэд биднийгээ хооллож, хувцаслахад нэмэрлэнэ. Ажлаасаа тарж ирмэгцээ хувцсаа солин гараа угаагаад хоол хийх ажилд ханцуйгаа шамлан ордог байсныг нь тодхон санаж байна. Аавын хийсэн хоол амттай гэдэг нь аргагүй. Манайх их эвтэй найрсаг гэр бүл байж, аав, ээж хоёр маань бие биедээ халуун хайртай, өөр хоорондоо эвтэй найртайгаараа үлгэр жишээ үзүүлэн сайхан амьдарцгааж, үр хүүхэд биднийгээ төрүүлж, хайр энэрлээр дутаалгүй өсгөсөн нь бидний хувьд зөв хүмүүжлийн эхийг тавьж, гэр бүлийн доторх уур амьсгалыг зөөлөн дулаан болгож байсан билээ. Аав, ээж хоёр маань олонтойгоо эв найртай сайхан байж, эгэл даруухан амьдарцгааж байсан нь одоо эргээд бодоход их сайхан санагддаг юм. Нутгийнхан нь миний аав, ээж хоёрыг бусдад байнга тус дэм болж байдаг, өгөөмөр сэтгэлтэй их сайн хүмүүс гэгцгээдэг.

Аав нь эцэг, эхийн элбэрэл хайр дүүрэн, элэг бүтэн амьдрал дунд хүүхэд хичнээн их аз жаргалтай өсөн өндийдөг болохыг өөрийн гэр бүлээсээ олж мэдсэн юм. Хайранд өлгөйдүүлэн өссөн хүүхэд бусдыг мөн хайрладаг болохыг биеэрээ мэдэрсэн. Иймд аав нь та нарыгаа хайр энэрэл дүүрэн эрхэм сайн хүн болгохын төлөө ихэд хичээж ирсэн юм. Миний

аав, ээж хоёрын бидэнд харамгүй зориулсан хайр, элбэрэл намайг өдий зэрэгт хүргэсэн болохоор тэднийгээ дээдлэн ачийг нь байнга санаж явдаг. Энэ дашрамд эцэг эхчүүдэд хандан хэлэхэд: Хүүхдүүдийг аз жаргалтай байлгахад гэр бүлийн үүрэг нэн их. Гэр бүл нь хүний хамгийн нандин орчин тул гэр бүлийг жинхэнэ сайхнаар бүрдүүлэх ёстой. Гэр бүлийн орчинд хүүхэд бага балчир насандаа зан суртахуун, хүмүүжлийнхээ ноён нурууг босгож авдаг тул эцэг, эхчүүд тэдэнд цаг заваа харамгүй зарцуулан эрхлүүлэн тоглуулж, эелдэг зөөлнөөр харьцаж байх ёстой гэж би үздэг. Би гэр бүл, үр хүүхдүүддээ чин сэтгэлээсээ хандаж, бүхнийг тэднийхээ төлөө зориулдаг тул амьдрал ямагт сонирхолтой сайхан байдаг. Гэр бүлдээ хайхрамжгүй хандахыг би хэзээнээсээ тэвчдэггүй. Гэр бүлийн аз жаргал хамгийн сайхан нь байдаг.

Эргээд бодоход миний хүүхэд насны амьдрал аз жаргалаар дүүрэн өнгөрч дээ. Хүүхэд насанд хүргэж өгдөг галт тэрэг хэрвээ байдаг бол хүн бүхэн суух байх. Би бол бүр заавал сууж хүүхэд насандаа эргэж очих байсан юм шүү.

Ямар ч амьдралыг туулсан, ямар ч ажил мэргэжил эзэмшсэн миний хүүхдүүд эхлээд жинхэнэ хүн болсон, хууль журам дүрмээ мэддэг, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг хүн болж төлөвшсөн байх учиртай юм.

Захидлаа түр завсарлаж, дараагийн өдөр үргэлжлүүлье дээ.

Та нарт хайртай, аав чинь. Парис хот



Хүн эх орноосоо алс хол явахад элдэв юм их бодох юм. Энд байхдаа аав нь илүүтэй их эргэцүүлэн бодож байгаа зүйлийнхээ талаар та нартаа бичихгүй бол болохгүй нь.

Хүүхдүүд минь хүний энэхэн нас, эгэл заяанд олдох эрдэнэ бол эцэг эх хоёр юм. Иймд эцэг, эхээ дээдлэн хайрлаж, тэднийгээ баярлуулж ачийг нь хариулахыг хүн бүр хичээх ёстой. Тэд хүүхдүүдээсээ юу ч шаарддаггүй гэдэг нь үнэн. Хүүхэд та бүхний хувьд хичээлдээ шамдан онц сурч, гэрийнхээ ажилд туслан ном их уншиж, цагийг сайн ашиглан хүүхэд насанд сурч мэдэж болох бүхнийг хийж амжуулан гүйцэтгэвэл аав, ээж нар нь маш

их баярлаж, ачийг минь хариулж байна даа гэж боддог юм. Үүнийг би нийт хүүхэд, залуустаа зориулж бичиж байгаа юм.

Би бүр бага балчир наснаасаа аав, ээжийгээ олон удаа баярлуулж байсан. Би их ажилсаг хүүхэд байлаа. Ганц би ч биш тэр үеийн хүүхдүүд, ялангуяа хөдөөгийн хүүхдүүд ер нь их ажилсаг байсан юм.

Аав, ээж, ах, эгч нарынхаа эзгүйд гэртээ том ах нь болж үлддэг байсны хувьд ар талын бүхий л ажил миний толгой дээр буудаг байв. Томчуудыг явсны дараа миний ажлын өдөр эхэлнэ. Манайх олон хүүхэдтэй айл болохоор их том талх барих, том тогоогоор дүүрэн хоол хийх хэрэгтэй болдгоос их гурил тасалдаг байлаа. Талх гэхэд хагас метр урт талх барина. Нарийн хэмжээс хэлбэл өргөн нь 22 см, урт нь 50 см, 10-аад см зузаан маш том талх барина. Би талхны гурилаа зуурахын тулд томоо түмпэнд ихээхэн гурил хийж аваад ус буцалган халуун хүйтнийг нь тохируулан зуурч, талхныхаа хөрөнгөн дээр нэмээд том саван дотор хийн гараа цуцтал хутгана. Энэ бол жижигхэн хүүхдэд их хэцүү ажил л даа. Тэр үед би дөнгөж 7 настай байсан юм. Одоогийн 7 настангууд тийм их гурил зуурч бараг чадахгүй байх. Талхны арвин их гурилаа зуурч бэлтгэсний дараа галаа өрдөн асааж, савтай гурилаа пийшингийнхээ бөөрөнд тавьж эсгэнэ. Ингэх зуураа галынхаа үнсэнд төмс булж дээр нь цог тавин болгоод дүү нартаа идүүлнэ. Халсан ширэм дээр данхандаа ус хийн буцалгаж, хар цай чанаад хоёр дүүтэйгээ ууж цайлсны дараа би талх барих ажилдаа орно доо. Талх барьдаг төмөр саваа тосолж байгаад намиртал нь зуурсан гурилаа хийгээд халуун пийшиндээ тавина. Аман дээр нь тааруулж цогийг нь бөөгнүүлэн талхаа аятайхан байрлуулна. Барьсан талхны сайхан үнэр өрөө дүүрэн хамар цоргим ханхалхад талхаа гаргаж дороос нь хүчтэй цохин төмөр савнаас нь унаган ил тавьж хөргөнө. Ингээд хэн ч атугай амтархан идэх сайхан талх бэлэн болно. Харин барьсан талхныхаа дөрвөн талын хатуу захыг бид өөрсдөө идчихдэг тул томчуудад зөвхөн голын зөөлөн хэсэг үлддэг нь тиймхэн. Би одоо хэр талхны захыг идэх дуртай. Ийнхүү барьсан талхыг манайхан тэр өдөртөө л идэж дуусгана. Маргааш нь дахиад л тогтсон ёсоор талхаа барина... Том түмпэнд ихээхэн гурил хийж зуурна. Гурилаа нэлээд амрааж эвлүүлсний дараа сайхан элдэж, гал дээр хайраад жигдхэн хэрчинэ. Ингээд л оройн хоолны гурил бэлэн болно.

Найз Ц.Ганбат маань гурилаа зууран элдээд, пийшин дээрээ тавьж жигнэсний дараа авч гэрээсээ гүйж гараад агаарт өөд нь хэд хэд шидээд

барьж аваад, дахин дээш нь шидээд барьж авах зэргээр хөргөчихөж байхыг нь харлаа. Гадаа гарч надтай тоглох гэж яарч байгаа нь тэр. Халуун гурилыг ингэж хөргөх арга надад тун их таалагдсан тул би гэртээ хариад найз Ганбаагийнхаа аргаар гурилаа пийшин дээрээ хайраад, гадаа гаран хүйтэн агаарт шидэн хөргөж, түүнээ нарийхан нь аргагүй хэрчиж хоолонд хийхэд бэлэн болгов. Түүнээс хойш гурилаа агаарт өөд нь шидэж хөргөхдөө яг л “жонглёр” тоглож байгаа мэт хоёр гар хоорондоо ээлжлэн эргүүлж ихэд сурамгай шидэх болсон юм. Ажлынхаа завсарт хоёр дүүгээ харж асарна. Бага дүүгээ өмдөндөө бие засчихад нь угааж цэвэрлэх авч заримдаа залхуураад нохой дуудаж өмдийг нь долоолгодог байв. Манай гэрийн ойролцоо байдаг “шарик” гэдэг нохой намайг дуудмагц ирж, баастай өмдийг нь долоон надаас бараг илүү цэвэрлэхдэг байж билээ.

Энэ айл гэрийг ундны усаар тасалдуулахгүй байх үүргийг би мөн хүлээнэ. Хөдөөгийн хүүхэд бид хот суурин газрынхантай адил байшингийн хананаас бэлэн ус авна гэсэн ойлголт үгүй тул далай тийш усанд явна. Намар орой давалгаа өндөр гардаг үеэр жаахан хүүхэд ус авах нь хэцүүхэн ажил байдаг. Нуурын гүнээс нь ус авбал тунгалагхан байдаг ч хүчтэй давалгаатай үед аймаар. Давалгаа эрчээ гайхуулах гэсэн шиг эргээ хүчтэй цохидог байж билээ. Давалгаа буцах үеийг тааруулж хувингаараа ус хутгаж амжина. Усанд явахдаа хоёр гартаа арван литрийн бетон барьж яваад дүүрэн ус авч ирнэ. Далай манай гэрээс тэр үед их хол байх шиг санагддаг байсан ч хагас км гаруй зайтай байсан юм билээ. Усаа аваад гэрлүүгээ алхаж эхлэх үедээ мундаг аа, огт зогсохгүй явах юм шиг л жигтэйхэн хурдан хурдан алхдаг боловч нэлээд яваад алхаа гишгээ минь өөрийн эрхгүй сулрах авч арай ч зогсчихгүй. Тэгснээ л хөл урагш хөдлөхөө больж, хоёр гар минь аяндаа амрахыг шаардана даа. Замдаа их олон амарч байж усаа огт цалгиахгүй гэртээ хүрч ирэхдээ их л баяр хөөр болдог сон.

Түлээ түлш бэлтгэх ажил бас л надад оногддог байлаа. Хөвч тайгад ямар гал алдахын зовлон байх биш дээ. Гагцхүү түлээгээ сайн бэлтгэж авах хэрэгтэй болно. Эхлээд ойгоос түлшээ татна. Хагалах бэлэн мод байхгүй бол ганцаараа эсвэл хоёр дүүтэйгээ хамжиж хөрөөднө. Модоо хагалаад өрж наранд хатаана. Эдгээр ажлуудыг хийж гүйцээд харахад өдрийн нэг цаг дөхөж байдаг тул би хоёр дүүгээ гэтээ үлдээгээд сургуульдаа явна. Миний бие энэ мэтээр дээр дурьдсан ажлуудыг өдөр бүр хийж гүйцэтгэнэ. Аав, ээж хоёр маань ажлаасаа ирээд их сайхан амттай хоол хийж аягалаад намайг

дуудаж идүүлэх завсартаа өхөөрдөн байж эрхлүүлдэг сэн. Энэ зуураа миний хийсэн ажлуудыг нэг бүрчлэн тоочин магтаад, “миний хүү ёстой мундаг аа” гэж дандаа урмаар, заримдаа бүр бурмаар мялаана. Мундагаа дуудуулж магтуулсан миний хувьд маргааш нь их л урам зоригтойгоор ажлаа эхэлж, талх барих, гурил зуурах, ус авах, түлээ түлш бэлтгэх, гэрээ цэвэрлэх зэрэг бүхий л зүйлийг хийж амжуулаад зав зай гарган хичээл номоо давтан гэрийн даалгавраа заавал хийнэ. Би хичээлээ хийхдээ их дуртай хүүхэд байсан юм.

Аав, ах нар маань загас барьдаггүй байсан болохоор энэ чухал ажлыг би сурах ёстой болсон юм. Би загас барьж сурах гэж оролдож, их хичээл зүтгэл гаргасан даа. Тэр үед загасны утас, уурга, дэгээ “нүдний гэм” байсан тул загас барьдаг хүмүүс үйсэн бөглөөгөөр хөвүүр, зүүгээр дэгээ хийдэг байв. Нэг удаа би насаар олон ах Бат-Эрдэнэ гэдэг хүүхдээс хамгийн хайртай орос ремень бүсээрээ сольж загасны хэрэгсэл авсан юм. Би тэгсхийгээд нэг их ядралгүй сайн загасчин болж орхилоо. Зуны цагт ихэнх цагаараа загас барихаас гадна өвөл ч мөс цоолон загас барьдаг байв. Ууланд гарч, ой модон дотор гал түлээд загасаа шарж болгоод найзуудаа дайлна. Заримыг нь гэртээ авч ирэн хуушуур хийж, эсвэл чанаж их сайхан шөл гарган дүү нартаа өгнө. Мөн аав, ээжтэйгээ ойд зугаалж, жимс, мөөг түүнэ. Түүсэн жимсээрээ өвөлдөө идэх амттай нь аргагүй жимсний чанамал бэлтгэнэ. Би бас зурам, жирх агнаж сурсан юм. Яагаад үүнийг сурах болсон бэ гэвэл биднийг хүүхэд байхад сургуулийн зуны амралтаар зурам, жирх агнаж арьсыг нь авч ирж тушаахыг даалгадаг байснаас тэр. Манайх сургуулийн насны олон хүүхэдтэй айл тул би эгч, дүү нарынхаа зуны даалгаварт өгсөн зурам, жирхийг тоо ёсоор нь агнан арьсыг нь бэлтгэх ажлыг хийчихдэг байсан билээ. Хүүхдүүдээр амьтан агнуулах үүрэг даалгавар өгдөг тийм муу сургалтын систем Монголд байсан юм.

Би аавтайгаа хамт ууланд мод цагаалж, өвлийн түлшээ бэлтгэж явах үедээ нэг оготно ад модонд хүзүүгээ хийгээд боож үхсэн байхыг олж харсан юм. Түүнийг гайхаж, энэ хөдөө хээр нутагт ийм юм болсон байдаг сонин юм шүү, оготно үнэхээр өөрөө өөрийгөө ингэсэн хэрэг үү, арай хүн ингээд хийчихмээргүй юм гэж бодоод ааваасаа асуухад

- Тийм ээ, оготно өөрийгөө боож үхдэг юм гэнэ лээ. Хүний буруу ажиллагаанаас мэхээр зэрэг идэш тэжээлээ булаалган алдсанаас болж, “өлсөж үхэх байхдаа, өвлийг яаж давах вэ” гэж харамсан өөрийгөө ийнхүү

егүүтгэсэн хэрэг гэж аав минь хэллээ. Оготно ингэж зовж байхаар дуусъя гэж шийдсэн нь энэ ажээ. Оготно оюун ухаангүй, жижигхэн амьтан гэхэд ийм их зориг, тэвчээр гаргаж чадна гэдэг бас их сонирхолтой санагдаж билээ.

Хар багаасаа ус, түлээ татах ажилд нухлагдсан болохоор мөр минь шувтан, хуруу минь мойног болсон авч ажил хөдөлмөр хүнийг ямагт дээш нь татаж байдгийг мэдэх болсон юм. Би ингэж тасралтгүй хөдөлмөрлөж байсныхаа хэрээр улам эрүүл чийрэг, цовоо сэргэлэн байж, амьдралаас суралцан ухааныхаа цар хүрээг тэлж байлаа. Нас бие бага ч гэсэн заримдаа өөртөө ахадсан ачаа үүрэлцэн аав, ээжийгээ баярлуулсаар ирсэн хэдий ч ачийг нь хариулах сан гэсэн нэгэн үзүүрт бодол надаас огт салдаггүй байсан билээ ... Би ийм л хүүхэд байлаа.

Цаг нэгэнтээ шөнө дунд болсон тул цахилгаан гэрлийг эс тооцвол Парис хотыг бүхэлд нь түнэр харанхуй нөмөрчээ.

Захидлаа үүгээр завсарлаж, аав нь унтаж амаръя даа. Зүүдэндээ та нартайгаа уулзана гэж найдъя.

Франц



Монгол хүн Их эзэн хааныхаа байлдан дагуулсан дэлхийг тойрон аялах учиртай гэсэн өөрийн бодлоо бичиж захидлаа эхэлье. Аав нь энэхүү захидалдаа хоёр зүйлийг чухалчлан хэлэхийг хүсэж байна. Аавын бийд хүнтэй танилцаж, агтны бийд газар үз гэсэн ардын минь мэргэн сургаал бий. Үүнээс үзвэл юм үзэж нүд тайлах нь их чухал болох нь тодорхой байна. Хоёр дахь гол зүйл бол ном тэр дотроо хүн төрөлтхтөний бүтээсэн сонгодог зохиол унших явдал юм.

Аав нь Германд 1988 онд Чехийн Братислав хотод герман оюутнуудтайгаа хамт дадлага хийхээр очсон юм. Тэндээсээ дараа нь Унгарт очлоо. Энэ мэтээр аялан явсаар Европын социалист орнуудын ихэнхэд нь, мөн 1989 онд Францын Парист, 1990 онд Испанид, 1991 онд Англи Голланд улсад очсон юм. 1996 он гэхэд баруун Европын бүхий л орнуудаар явсан байлаа. Харин 1997 онд АНУ-ын цөөнгүй хотуудаар аялан Америк оронтой танилцсан юм. БНСУ, Сингапур, Гонконг, Макао, Индонез, Малайз, Филиппин, Арабын Эмират, Египет, Этиоп, Казакстан,

Киргизстан, Узбекистан, БНХАУ зэрэг орнуудад олон удаа очиж байв. АНУ, Япон, БНСУ-д олон удаа, Францад дөрвөн удаа, Англид бол бүр хориод удаа очсон. Скандиновын хойгийн орнууд ардчилсан Солонгос, Тайваньд очиж байв. Эдгээр улс орнуудад хэдхэн хоногоор бус, тэдний хөгжил, хүн ардынх нь аж амьдрал, соёл зан заншилтай танилцан найз нөхөдтэй болох хүртлээ явсан. Давхардсан тоогоор аав нь 300-аад удаа гадаадын орнуудаар ажил төрлийн шугамаар болон аялан явсан нь юм үзэж, нүд тайлсан хэрэг болсон юм. Харин улсын зардлаар ердөө гурван удаа л явсан юм шүү. Дэлхийг тойрон явахад англи, герман, орос хэлийг сурсан минь их хэрэг болж байв.

Миний хүүхдүүд дэлхийг тойрон аялж чадахгүй байлаа ч хүнд заавал үзэх ёстой газар нутаг гэж байдаг юм гэдгийг хэлье.

Францын нийслэл Парис хот. Эртний энэ хот эрхэмсэг оршигчдын өлгий нутаг гэж өөрийн эрхгүй бодогддог.

Энд аав нь хүүхэд байхдаа уншиж байсан Монте Кристо гүн романы үйл явдлаас өөрийн эрхгүй санадаг юм. Миний унших дуртай номуудын нэг нь “Монте Кристо гүн” байсан бөгөөд тэр номын үйл явдал сэтгэлийг минь үнэхээр эзэмдэж чадсан билээ. Би 11 настайдаа А.Дюмагийн “Монте Кристо гүн”, “Шадар гурван цэрэг” зэрэг сонгодог романуудыг уншсан нь надад хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн юм.

Монте Кристо гүн зохиолд: Парист залуу хүнийг хэрхэн үнэлдэг талаар

Аятайхан хувцаслагчид

Юухан хээхнийг ярьж чаддаг

Зоригтойхон тоглоод алтаар төлбөрөө төлчихдөг байх ёстой гэсэн байдаг юм.

Аятайхан хувцаслана гэдэг нь залуу хүмүүс үнэхээр гоё сайхан байх ёстой гэсэн үг. Өөртөө зохимжтой хувцаслах нь үнэхээр чухал. Ингэх нь хүний соёлтой холбоотой. Гэхдээ манай зарим залуустай адил түрийвчтэйгээсээ давж гангарах гэсэн үг биш.

Юухан хээхнийг ярьчихдаг бай гэдэг нь их юм үзэж, нүд тайл, ном их унш, гадаад хэл сайн сур, хорвоо дэлхийн сонин сайхнаас сонсож мэд, ер нь их хөдөлмөрлө гэсэн утгатай.

Зоригтойхон тоглоод алтаар төлчихдөг бай гэдэг нь хамгийн товчоор мөнгөтэй бай л гэсэн үг. Байгаа хэдээрээ тогложихоод юу ч үгүй тавиад

туучихыг хэлж байгаа юм биш. Цаана нь бас нэлээд юмтай үлдэх хэрэгтэй гэсэн үг. Тэгэхээр тийм хэмжээний мөнгө цуглуул хөрөнгө босго гэсэн үг л дээ.

Аав нь одоо хөгжилтэй нэгэн явдлын талаар өгүүлье. Би гуравдугаар ангиа төгсөх жил математикийн шалгалт өгч байхдаа бодлогоо бодчихоод “Шадар гурван цэрэг” номоо цүнхнээсээ гарган уншиж суутал Мааньгүмбэн багш над руу хүрч ирээд:

- Чи бодлогоо бодсон уу гэв.
- Тийм ээ гэж намайг хариулахад багш номыг маань авч үзээд:
- Чи үүнийг уншиж байгаа юм уу? гэхэд нь би мөн л
- Тийм гэж хариуллаа. Багш
- Том хүний л ном байна даа гэж хэлсэн боловч миний ном уншиж буйд дургүйцээгүй, харин ч дэмжсэн аястай өөр үг хэлэлгүй надаас холдон явсан юм.

Би бүр шөнө дөл болтол ном уншин суудаг байв.

“Шадар гурван цэрэг”-ийн Де Артинян гэдэг залуугийн дүр өнөөдрийг хүртэл миний сэтгэлд тов тодхон үлдсэн юм. Эрэлхэг зоригтой, шударга, авхаалж самбаатай, амьдралдаа зорилготой, амжилтанд хүрэхийг чухалчилдаг залуу хөдөө тосгоноос Парист хүрэлцэн ирж, үнэнч шударга зангаараа торгон цэрэг болж чаддаг.

Эдгээрийг Францын алдарт зохиолч Александр Дюма бичсэн юм. 20 жилийн дотор 400 роман, 35 жүжиг бичсэн тэрбээр “ийм зохиол, бүтээл туурвисан энэ гар бол ажилчин хүний гар юм шүү” гэж бардамхан хэлдэг байжээ. Манай гаригийн хамгийн бөглүү хязгаарт ч хүрч чадсан “Монте Кристо гүн”, “Шадар гурван цэрэг” хэмээх хоёр роман нь 1844 онд нэгэн зэрэг гарчээ. Зарим хүмүүс түүнийг “Романы үйлдвэр” гэж нэрлэн “А. Дюмагийн романууд биеийн болоод сэтгэлийн ядаргааг арилгахад ямар ч эмнээс илүү хүчтэй” гэж бичиж байжээ.

Би гэртээ эгч Уранчимэгтэйгээ ном булаацалдан уншихдаа зарим маш сонирхолтой хэсэг дээр нь хүлээх тэсвэр алдагдахад эгчийнхээ ард сандал тавьж дээр нь гарч зогсоод, мөрөн дээгүүр нь давуулан харж уншина. Ийнхүү номын хорхойтон болсоор эхлээд сургуулийнхаа, дараа нь Хатгалынхаа номын сангийн номнуудаас авч уншсаар нэг ч ном үлдээлгүй бүгдийг уншиж дуусгасан юм. Би гэр болон сургууль ангидаа ном уншихаас гадна их хорхой хүрсэн үед хичээл тараад гэртээ харих замдаа гудамжинд

явж байхдаа ч номоо гаргаж ирээд уншдаг байсан тул нэг удаа номын адал явдалд хөтлөгдөн замын хажуу талын шонгийн модыг хүчтэй мөргөсөн удаатай. Энэ явдал санаанаас минь ердөө гардаггүй юм. Бас Жюль Верн, М.Шолохов, Майн Ридийн зохиолуудыг маш шимтэн уншдаг байв. Мөн Майн Ридийн “Зоригт анчин бүсгүй”, “Цагаан бээлий”, “Морь унасан толгойгүй хүн”, Г.Д.Мопассаны “Хонгор найз”, Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” зэрэг адал явдал, хайр дурлалын сэдэвт романуудыг уншдаг байсан нь би мөрөөдөмтгий, дурламтгай, бас уян, зөөлөн сэтгэлтэй болоход нөлөөлсөн юм болов уу гэж боддог.

Мөн Т.Драйзерын “Америкийн эмгэнэлт явдал” В.Гюгогийн “Парисын Дарь эхийн сүм”, М.Шолоховын “Дөлгөөн Дон”, “Хүний хувь заяа” зэргийг уншихдаа сэтгэл минь ихэд хөдөлдгөөс хамрын самсаа шархиран тэр бүрт би сэтгэлээ барьж дийлэхгүй уйлдаг байснаас нулимс дусаж хатаад, дараа нь номын хуудсууд нээгдэхгүй болдог байв. Ийнхүү би сонгодог зохиол, бүтээл хүнд хэрхэн нөлөөлдөг болохыг биеэрээ мэдэрсэн юм. Ном унших хүсэл минь оргилсоор долдугаар ангиа төгсгөсөн жилээ наймдугаар ангид үзэх бүх сурах бичгүүдийг уншиж судалсан байсан юм. Сүүлдээ унших ном олдохгүйд хүрч “ЗХУ-ын Коммунист Намын түүх”-ийг уншсан юмдаг.

Франц гүрэн сонгодог зохиол бүтээлээрээ дэлхийд алдартай. Парис хотын иргэн байхад ч сонгодог болгоныг мэддэг ойлгодог байх шаардлагатай бөгөөд тэд сонгодог ном зохиолоо уншиж, сонгодог уран зургуудыг бараг нэг бүрчлэн мэдэж байх ёстой байдаг. Иймд Монгол хүүхдүүд дэлхийн энтэй амьдрахын тулд ном их уншсан байх хэрэгтэй. Ном унших бол хүүхэд бүрийн зайлшгүй хийх ёстой ажлын нэг юм шүү.

Парисын үнэлгээгээр монгол залуус үнэлэгдэх ёстой юм шүү.

Та нарын маань билэг оюун улам нээгдэх болтугай.

Амжилт хүсье.



Хүний амьдрал зогсолтгүй урагшилсаар. Саяхан л би жаалхан хүүхэд, аав ээж минь идэр залуухан байлаа. Гэтэл эдүгээ би аав ээжийнхээ насан дээр ирж, харин хүүхдүүд минь цаг хугацаатай уралдан ургах мэт өсөн өндийж байна.

Энэрээ, хүү минь чи одоо эрийн цээнд хүрчээ. Хүү минь улам ухаалаг болж буйд аав нь баяртай байна. Энэрээ чи бол миний анхны хүү. Аав нь хүүгээ төрөхөд хичнээн их хөл хөөрцөг болон баярласан гэж санана. Хүү минь эрүүл чийрэг төрсөн юм. Энэрээ минь балчирхан, дөнгөж дөрөвхөн настайдаа ааваасаа баргийн хүүхэд асууж чадахааргүй утга учир сайтай асуулт асуудаг байж билээ. Хүү маань бүр багаасаа л ухаалаг, сэргэлэн цовоо, ээжийгээ дуурайсан “толгой сайтай” .

Миний ууган хүү Энэрээ одоо нэгэнтээ оюутан болжээ. Миний хүү Английн Лондонгийн төвд байдаг Импераал коллежид элсэн орсон юм. Энэ бол дэлхийд 5-р байрт ордог нэр төртэй сургууль юм. Ийм сургуульд тэнцэж ороод амжилттай суралцаж байгаа хүүгээрээ аав нь бахархахаас өөр яах билээ. Хүү минь хойшид ч хичээн суралцаарай.

Энэрээ, хүү минь мартагдашгүй нэгэн дурсамжийг санаж байгаа биз дээ? Аав нь огт мартдаггүй юм. Би 11 настайдаа уншсан “Шадар гурван цэрэг”, “Монте Кристо гүн” романыг чиний 11 насны төрсөн өдрөөр бэлэглэхэд миний хүү тэр номнуудыг уншиж, учрыг нь сайтар тунгааж олсон байсныг би хожим нь хэдэн асуулт асууж шалгаад, хариулт нь зөв байснаар мэдсэн юм. Тухайлбал: Монте Кристо гүн номонд Парист залуу хүнийг хэрхэн үнэлдэг талаар 4 дэхь захианд бичсэн зүйлийг би чамаас асуугаагүй юу. Хариулж бараг чадахгүй биз дээ гэж бодсоноос би Парист залуу хүнийг хэрхэн үнэлдэг вэ? гэж тоомжиргүйхэн асууж билээ. Гэтэл чи

- Аятайхан хувцаслачихдаг
- Юухан хээхнийг ярьж чаддаг
- Зоригтойхон тоглоод алтаар төлбөрөө төлчихдөг гэж хариулахад

нь би цочих шиг болсон юм. Хариулт аргагүй зөв байлаа.

Би учиргүй баярлаад “Шадар гурван цэрэг” романд Де Артиняныг анх Парис явахад нь аав нь юу юу өгснийг мэдэж байна уу гэж нэмж асуулаа.

Аав нь түүнд алаг морь, захидал, сэлэм, бас хэдхээн төгрөгөөс өөр зүйл өгөлгүй харин сайхан сургаал айлдсан байдаг юм. Де Артинян нь амьдралаа өөрөө бий болгож, амжилтанд хүрдэг юм. Энэ бүхнийг ч хүү минь чи яг л хариулж билээ. Би хожим энэ тухай чамаас асууна аа гэж хэлсэн биш дээ, жаахан хүүхэд уншсан номныхоо хамгийн голын ийнхүү бүгдийг мэдэж тогтоосон байсанд хүүгээрээ бахархах сэтгэл эрхгүй төрсөн

юм. Миний хүү ном гайгүй уншиж, уншсанаа ухаж ойлгодог хүүхэд болох нь ээ гэж харж байсан минь андуу болсонгүй ээ. Хүү минь чи түүнээс хойш олон олон роман, түүн дотроо сонгодог зохиол их уншсан. Чи Лондонгийн сургуульд суралцаад дөрвөн жилийн дотор тэргүүний сурагчаар шалгарсан тул сургууль дээр чинь чиний зургийг хүндэтгэлтэйгээр байрлуулсан байхад аав нь дэргэд нь зургаа авахуулахдаа хүүгээрээ их бахархсан юм. Хүү минь чи нэг удаа хүүхдүүд зодолдохоор өдсөн тухай надад яриад: - Би зодолдсонгүй ээ. Тэд нартай зодолдож, доошоо орохыг хүссэнгүй гэж билээ. Би тэгэхэд нь - Миний хүү зөв шийджээ. Зодооноор шийддэг асуудал одоо байхаа больсон. Зодолдсоноороо аль аль нь хохирдог муу талтай гэж хэлсэн юм. Ийнхүү хүү маань маш ухаалаг хөвгүүн болж буйд аавынх нь сэтгэл нэн хангалуун явдаг. Аав нь хүүдээ “Загалмайлсан эцэг” киноны ДВД-г худалдан авч өгөхөд - Ааваа би кино үзэхгүй ээ, номыг нь уншчихсан гээд надад дөрвөн боть харуулсан юм. Яагаад гэж намайг асуухад тэр ном уншихад илүү сайхан байдаг юм аа. Номоо гүйцэж хийсэн кино гэж бараг байдаггүй. Ихэнх чухал санааг нь кино хальсанд буулгалгүй орхигдуулсан байдаг юм билээ. Тэгэхээр аливаа ном зохиолыг унших нь л илүү гэж миний хүү 13 настайдаа том хүн шиг ярихад нь би “бүр овоо доо” гэж дотроо ихэд үнэлсэн.

Аав нь сүүлд хүүтэйгээ уулзахдаа Монгол орон байгалийн баялгаар арвин юм даа, одоо манайд Оюутолгой, Тавантолгойн тухай л яриа болоод байгаа талаар багахан сонин дуулгахад:

- Аав аа эх орныхоо баялгийг гадныханд л бүү цөлмүүлчихээсэй дээ гэж барагтай улс төрчийн ч амнаас гардаггүй үгийг тэр хэллээ.

Хэлнэ гэж огт бодоогүй байсан зүйлийг миний хүү ийнхүү хэлсэн нь намайг цочоосон юм.

Хүүхэд, залуучууд та бүхэн хүн төрөлхтний гайхамшигт бүтээл болох сонгодог зохиолуудыг уншиж, чухал санаануудыг нь тогтоож авбал амьдралын зорилгоо тодорхойлоход чинь хэрэг болно гэдгийг хэлье. Эцэг, эхчүүд ч хүүхдийнхээ төрсөн өдрөөр ном бэлэглэж байгаарай гэж энэ дашрамд захия.

Аав нь хүүхдүүдээрээ бахархдаг шүү.

Бас та нартаа маш их хайртай.



Хүүхдүүд минь аав нь өмнөх захидалд эцэг эхээ баярлуулж, ач тусыг нь хариулах учиртай талаар бичсэн билээ. Энэ бол хүүхэд та бүхний хувьд их чухал.

Аав нь аав ээжээ их баярлуулж байсан ч дотроо аав, ээжийнхээ ачийг хариулах шиг хариулна даа гэсэн хүүхэд насны гэнэн бодлыг байнга тээж явдаг байсан юм. Харамсалтай нь тийм их ачлал, хайрыг хэн яахин хариулж чадах билээ.

Аавынх нь хувьд ээжийнхээ ачийг хариулах хүслээ гүйцэлдүүлж амжаагүй явтал ээж минь тэнгэрт хальсан тул амжсангүй дээ гэсэн бодол толгойг минь гудайлгаж, харуусал, гуниг тээлгэсээр байв.

Билүүтэй уулынхаа овоонд чулуу ганцыг нэмлүү дээ

Биеэ хувааж төрүүлсэн ижийнхээ ачийг яалаа даа...

Алтан ганжиртай талдаа ойрдоо нэг очлуу даа

Амиа хувааж төрүүлсэн ээжийнхээ ачийг яалаа даа гэсэн яруу найрагч Б.Лхагвасүрэн гуайн шүлгийн мөрүүд надаас асууж байх шиг санагдан шаналгадаг байлаа. Нэгэнт ээжийгээ алдаж, аав минь ганцаар үлдсэн болохоор би аавынхаа ачийг хариулах сан гэж мэрийх болсон юм.

Ээжийн бие муу байх бүхий л хугацаанд аав минь ёстой нүд салгалгүй харж, гар хумхилгүй асран сувилж, улам илүүтэйгээр хайрлан халамжилж байлаа. Энэ үед ээж маань элэгний хүнд өвчин туссан байсан юм. Ээжээс хойш аав ганцаар үлдсэн ч эхийн хайраар биднийг дутаахгүй гэсэндээ ихэд мэрийдэг байлаа. Аав амьдралын бүхий л ачааг нуруундаа үүрэн, халуунд халж, хүйтэнд хөрж зовох цагтаа зовж, бидний төлөө зүтгэсэн юм. Ээж минь хэдийгээр тэнгэрт хальсан ч харин аавд минь шингэж үлдсэн мэт бодогдож, би аавыгаа “амин хайртай аав минь” хэмээн илүү ихээр хайрлах болов. Аавынхаа ачийг хариулах сан гэсээр би аавыгаа Герман улсад 11 удаа урьж аваачсан юм. Тиймээс нутгийнхан маань аавыг “герман” Ламжав гэгцгээх болсон. Герман орныг үзүүлж, танилцуулахад аав ихэд баярлаж байлаа. Би аавыгаа сайн эмнэлэгт үзүүлсэн юм. Аавын үүдэн шүднүүд суларч, зарим нь унасан байв. Германд шүд их сайн хийдэг тул сайхан цагаан шүдтэй болгож өгөхөд аавын сэтгэл ихэд хөдөлж, “аав нь муу хүүгийнхээ буянаар сайхан шүдтэй боллоо. Одоо ч 75 насыг зооглоно оо” гэж надад баярласан сэтгэлээ илэрхийлж билээ. Тэр үед аав 62 настай байсан юм. Аав амалсандаа хүрч 75, тэр ч байтугай түүнээсээ илүү өндөр насалж, 86 насыг зооглосон юм. Тэр болтол бие нь эрүүл чийрэг, ухаан нь саруул, гар хөл нь чанга,

хүчтэй хэвээр, хөвч тайгынхаа их уулсын оргил мэт дүнхийн, үр хүүхэд бидэндээ нөмөр нөөлөг болсоор байсан юм. Аав минь эх нутагтаа үндэслэн салаалсан ургаа мод мэт санагддаг байж билээ. Би аавыг Улаанбаатарт ирэх үед зориуд мөнгө төгрөг өгч, өөрөөр нь бага сага наймаа хийлгэдэг байлаа. Багахан ч хамаагүй мөнгө унаган өөрийгөө хөөрхөн баясгаж байг хэмээсэн нь энэ.

Ер нь юу хүснэ, биелүүлэхийг хичээж, тааваар нь байлгахыг эрмэлздэг байсан нь аавыгаа эрхлүүлэх гэх үү дээ, аль болох хөгжилтэй, хөдөлгөөнтэй байлгавал эрүүл, саруул байж, улам урт удаан наслах болов уу гэснээс юм. Аавынхаа ачийг хариулах миний сэтгэл энэ юм даа.

Хүүхэд залуус минь аав, ээжээ баярлуулж,
ачийг нь хариулж яваарай.



Хүүхэд, залуучууд ер нь нийт хүмүүст хандаж миний хэлэх дуртай үг бол

**“Амжилт бол хамгийн эротик зүйл,
зөвхөн идэвх зүтгэл аваргыг төрүүлдэг”**

хэмээх Герман ардын үг юм. Үүнийг би аль болох олон хүнд хүргэж хэлэхийг хүсдэг. Энэ нь амжилт бол хамгийн сайхан зүйл гэсэн үг. Иймд хэн боловч амжилттай байх хэрэгтэй бөгөөд амжилттай хүнийг хайрлахгүй, амжилтын төлөө хичээхгүй, амжилт ололтонд дурлахгүй хэн байх билээ. Амжилт гаргасан хүн л илүү эрх чөлөөг эдэлдэг гэдэгтэй би санал нийлдэг.

Амжилт эротик учраас аав нь эротик харагддаг байж л дээ. Аав нь Тариалангийн охинд болон хотын ганган охидуудад тэр ч байтугай Герман охидод таалагдаж явсан талаараа бичиж амжилттай хүн хүний хайрыг булаадаг гэдгийг хэлэх гэсэн юм. Энэрээ миний хүүд энэ захиа илүү сонирхолтой байж магад.

Есдүгээр ангид орсон жилээ би сургуулиасаа шалгарч, Мөрөн хотод болсон аймгийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор очоод Тариалан сумаас ирсэн нэг эрэгтэй хүүхэдтэй танилцаж дотносов. Түүнтэй хамт явдаг байсан бор царайтай, шөнтгөр хамартай, хөөрхөн охин намайг

хараад л инээмсэглэдэг байлаа. Хүүхдүүд юм хойно дороо танилцаж нөхөрлөсөн юм. Би Хатгалдаа буцаж ирээд ангидаа байж байтал нэг өдөр ангийн охидууд шуудангаас захидлууд аваад орж ирэхэд нь би санамсаргүй гараа сунган - Миний захиаг өгчих дөө гэхэд: - Май үүнийгээ ав гээд нээрэн нэг захиа миний гар дээр тавьчихад нь гайхсан гэдэг яах вэ. Аваад үзтэл “Хатгалын 10 жил Гүндалайд” гэж хаягласан байв. Энэ бол амьдралдаа миний авсан анхны захиа байлаа. Задалж үзэхэд “Тариалангийн охин”-оос ирсэн байсныг уншихад “Чи надад их таалагдсан. Би чамтай үерхмээр байна. Хоёулаа үерхэе, тэгэх үү” гэсэн байлаа. Би уншаад хариу бичилгүй орхичихов. Гэтэл түүнээс хойш сарын дараа надад утсаар ярих урилга ирж, намайг сумын холбоон дээр дуудлаа. Би гайхсаар явж очиход холбооны залгагч эмэгтэй:

- “Гүндалай ирэв үү, кабинд ор” гэлээ. Би тэгэхэд анх удаа утсаар ярьж үзэж байсан нь тэр тул харилцуурыг дөнгөж аваад- Хэн бэ? гэж аяархан дуугарахад Тариалангийн охин байх нь тэр. Тэр надаас хичээл сургууль чинь сайн уу, захидал авсан уу, энэ тэрийг асуухад би яахаа мэдэхгүй дэмий л баахан сандарч, “за, тийм” гэх төдийгөөр хариулахчаа аядаж байтал холбооны залгагчийн дуу хадаж, “эрэгтэй нь дуугараач ээ, яриач ээ” гэх ньтэр. Би улам бүр сандарч, залгагч сонсож байдаг юм байна шүү дээ гэж бодоод огт дуугарч чадахаа болив. Би хожим нь Тариалангийн охины захидлын хариуг бичиж явуулсан юм. Гэвч бид хоёр хүүхэд насны үерхлээр үерхэж, бие биедээ захидал бичдэг байснаас хэтэрсэнгүй, нэг мэдэхэд л сураг тасарсан билээ.

МУИС-ийн Герман хэлний бэлтгэл ангид орсноор би хотын ганган охидуудтай танилцаж билээ. Манай ангид гол төлөв хотын уугуул, жигтэйхэн ганган, хээнцэр охидууд байх агаад тэд хөдөөний хүүхдүүдийг бараг нүднийхээ булангаар ч тоож хардаггүй байлаа. Тэр үед хот хөдөөгийн ялгаа их байсантай холбоотой байх. Миний хувьд сурлага сайтай болохоор тэр байх, тэдгээр охидууд надтай дотносон нөхөрлөхийг хүсэж, “Гүндалай чи хөдөөний хүүхэд гэхээргүй юм аа. Яг л хотын хүүхэд шиг” гэцгээдэг байсан юм. Би нимгэн цагаан шар царайтай байсны дээр миний ах намайг ганган хувцаслаж явуулсан болохоор тэр биз ээ. Хамгийн гол нь миний “Амжилт” байлаа. Хотын ганган охидууд надад үнэхээр талтай байцгаасан юм шүү. Герман охидууд надад сайн байсны дотор манай ангийн цэнхэр нүдэт, шархан үст Катрин охин бусдаас илүү сайн байв. Биднийг танилцуулах

уулзалт болж оюутнууд нэрээ дуудахаар нэг нэгээрээ босож өөрийгөө танилцуулахад тэр намайг харсан байжээ. Тэр оройдоо би дэлгүүрт хүнсээ цуглуулахаар явж байтал нэгэн герман охин дайралдаж, намайг Катрин гэдэг хоёулаа танилцъя гэхэд нь би - Гүндалай гэж нэрээ хэлээд танилцав. Чи бид хоёр нэг группэд хуваарилагдсан гэж тэр охин хэлэв. Би мэдээгүй байсан болохоор “тийм үү” гэлээ. Маргааш нь хичээлдээ очиход би үнэхээр нөгөө охинтой нэг группт орсон байлаа. Катрин надад үнэндээ сэтгэл алдарсан гэдгийг. Гэвч би жирийн л үерхлээр түүнтэй үерхдэг байв. Тэр намайг байсхийгээд л гэртээ урьж аваачихад нь би аавтай нь хууч хөөрч суудаг байлаа. Катрин надтай нэг өрөөнд хонуулсангүй гэж аавдаа гомдсон ч удаа бий. Миний амьдралын туршид хүмүүс ер нь сайн ханддаг байсан нь надад итгэдэгээс тэр. Германууд ч мөн ялгаагүй. Хүмүүс надад итгэл үзүүлэн, сайн байдагт нь би баярлаж, бурхан надад сайхан хувь заяа хайрлажээ гэж боддог байсан юм. Катринаас гадна өөр олон охид, хүүхнүүд надад сайн байснаас “үерхэж нөхөрлөө, гэр бүл больё” гэсэн бүсгүйчүүд ч тааралдаж байлаа. Иймд би өөрийгөө “бүсгүйн тэнгэртэй” залууд тооцоход хүрсэн билээ.

Хүүхдүүд минь хичээл зүтгэлтэй байж
амжилтанд заавал хүрээрэй.

Залуу насыг чинь амжилт чимнэ шүү гэдгийг хэлж
захидлаа түр завсарлая.



Парис хот дахь өдрүүд зугаатай сайхан өнгөрч байна. Аав нь урьд үзэж байсан Эйфелийн цамхагийг өнөөдөр үзнэ. Эндэхийн нэгэн гайхамшиг бол Эйфелийн цамхаг юм. Эйфелийн цамхаг (Францаар Tour Eiffel) буюу Төмөр Хатагтай нь өнөөгийн Парисын хамгийн том доминант бөгөөд түүнийг зохиогч Александр Густав Эйфелийн нэрээр нэрийджээ. Уг цамхаг Сена мөрний зүүн эрэгт Марсын талбайд телевизийн антены хамт сүндэрлэнэ. Цамхаг нийт 10000 тонн жинтэй, Парис хотын хамгийн өндөр байгууламжуудын нэг юм.

Монгол минь удахгүй хөгжиж сайн сайхан болно гэсэн гэгээн бодол итгэл сэтгэлд минь явдаг. Аав нь хүүхдийг хайран дунд умбуулж өсгөх

ёстой гэж үздэг ч хүүхэд багачууд дандаа тоглож наадсаар цаг хугацааг дэмий өнгөрүүлэхийг огтоос таашаадаггүй. Ингэх нь хожмоо харамсахад хүргэдэг. Манайд хүүхдүүд компьютер тоглоомоор тоглон, гадуур хэсэж, шороон дотор сагс тоглон өдрийг өнгөрүүлэх дүр зураг харагдаж байдаг. Дандаа ингэж болохгүй л дээ. Иймд аав нь та нарыгаа эрхлүүлэхийн зэрэгцээ сайн боловсролтой болгохыг чухалчилж ирсэн. Хүүхдийн бага насыг дэмий өнгөрүүлэхгүй гэсэн шаардлагад нийцэх гэж хамгийн ихээр хичээж байгаа хүүхэд бол миний охин Энэрзаяа.

ААВ


*Би таныг төрсөн цагаасаа эхлэн
эргэн санахад таны том хүрэн нүд,
сайхан инээмсэглэл, бас таны хайр
халамжтай боловч бас хатуудаа
хатуу, эрс шулуун зан чанар санаанд
минь илхэн байна.*

*Та заримдаа намайг хашираах гээд
байгаа мэт санагдах үе байсан.*

*Харин та надад хайртай учраас,
миний төлөө л тэгж ханддаг
байсныг би одоо ойлгосон.*

*Та бол үргэлжид миний аав . Бид
өнгөрсөн (үхсэн ч) ч гэсэн. Та миний
зүрхэнд надтай үргэлж хамт байна.*

Би танд хайртай шүү. Аваа



Энэрзаяа миний охин одоогоор хэдий бага балчир ч гэсэн аав нь чамаараа бахархдаг. Охин маань хичээлийн бус цагаараа шатрын, төгөлдөр хуурын, бүжгийн, теннисний зэрэг дугуйлангуудад явж, сургуулиас зохиосон бүхий л ажилд идэвхтэй оролцсоор орой 18 цагаас өмнө гэртээ ирэх гэж бараг үгүй. Энза маань бидэнтэй хамт явсаар байгаад усанд сэлж сурсан. Бас өөрөө хичээсээр монголоор уншдаг болчихсон. Охин маань дөрвөн настай байхдаа гэнэт уйлдаг юм байна. Гайхан сандарч учрыг нь асуухад:

- Би том болмооргүй байна гэдэг байгаа. Яагаад ингэх болов? гэхэд
- Би том болохоор аав, ээж хоёр минь хөгшин болчихно шүү дээ

гэв. Хүүхэд яаж ингэж бодов оо, бас энэ мэт юм бодон санааширч байдаг
Хамтдаа байхыг маш их хүсэн гуйж байна.

Please, Please Stay

I know that sometimes life is hard,
But I know
You sometimes cry on my pillow,
And so full of joy
You two are made for each other,
Like a piece of a puzzle
Without you
The picture isn't complete
Your hand are intertwined together
Please, please stay
I can't make it without either of you
I know, it might be hard
And you might be frustrated
But please, please
Do it for me
And I will always love you.



10/24 2010-11 month

*Амьдрал заримдаа хатуу, бас шударга
бус гэдгийг би мэднэ. Иймд хүн бүр л зовдог.
Гэвч амьдрал аз жаргалаар дүүрэн байдаг.
Аав ээж хоёр минь бие биедээ зориулагдсан
мэт санагддаг. Яг нэг гэрийн хоёр багана
шиг. Аль нэг нь үгүй бол айл гэр үгүй. Та
хоёрын хувь заяа нэгэн шугам дээр давхцсан
мэт холбоотой. Тиймээс та хоёрыг хамтдаа
байхыг маш их хүсэн гуйж байна. Би та
хоёрын хэн нэггүйгээр байж чадахгүй. Би
аливаа зүйл хэцүү гэдгийг мэднэ. Иймд Та
бэрхшээсэн ч байж болно. Гэхдээ л хамтдаа
байхыг маш их хүсэн гуйж байна. Миний
төлөө үүнийг хий.*

Би таныг үргэлж хайрлах болно.

Енза 2010 он 10 сар

байх нь ээ хэмээн би охиноо ихэд хайрласан юм. Охины маань янз бүрийн
авъяас тодорсоор байгаа. Нэг удаа хүүхдийн кино үзэж байгаад морины
тухай цоглог аяз явахад шууд төгөлдөр хууран дээрээ дагаж тоглон, аав

Remember me? I remember U

Remember the day we met?
I remember it
as clear as yesterday
We were so young then,
so inexperienced
But look at us now,
we're preteens!
11 birthdays have passed
(Can you believe that?)
Every one of your birthdays
remind me of
how grateful I am
to have met you
You light up my days
You're a real treasure

BFF'S

by Енза
10/24 2010-11 month

Найз Б. Эрдэнэдарьдаа

*Намайг эргэн санаж байна уу? Би
чамайг санаж байна.... Бидний анх
уулзаж байсан өдрийг санаж байна
уу.? Би санаж байна, надад яг л
өчигдөр мэт санагдана. Тэгэхэд
бид ямар жижигхэн байсан юм бэ.
Бас ямар ч туршлагагүй. Харин
одоо биднийг хараач. Бид чинь
аравтын эхнийх нь. (11 настай
болжээ) Арван нэгэн төрсөн өдөр
өнгөрчээ. Чи үүнд итгэх үү. Чиний
төрсөн өдөр бүр намайг чамтай
уулзсандаа баярлаж байдгийг минь
санагдуулдаг.*

Чи миний өдрүүдийг гэрэлтүүлдэг.

Чи бол жинхэнэ эрдэнэс.

Үүрд сайн найзууд байна.

ээжий хоёрыгоо ёстой алмайруулж орхисон. Би хүүхдүүдээ жижигхэн зүйл сурсан байхад нь ч ихэд урамшуулан алга ташин үзэж суудаг.

Аавын охин Энэрзаяа бол уян зөөлөн сэтгэлтэй, ухаалаг охин юм. Энэрзаяа охин минь 8 настайдаа Монте Кристо гүн романыг англи хэл дээр уншсан.

Миний охин хоёр дүүгийнхээ хамт Олон улсын дунд сургуульд сурдаг.



Хайрт Энэргүнж минь

Дөнгөж сая болсон зүйлд би маш их уучлал хүсье. Миний хэлсэн болгон миний хүссэн юм биш шүү. Чи намайг үзэн ядаж байгааг би мэдэж байна. Бас үүнийг чинь бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байна. Би чамд үргэлж хайртай байсан. Одоо ч хайртай хэвээрээ шүү. Хэдийгээр чи өсөж том болсон, ухаалаг болсон ч гэсэн чи миний үргэлж хайрладаг жижиг дүү хэвээрээ байх болно. Би өөрийгөө чиний маш сайн эгч байж чадаагүй гэдгээ мэдэж байна. Үүндээ би их ичиж байна. Хэрвээ би амьдралаа ахиж шинээр эхэлбэл би илүү сайн эгч байх болно. Чиний урмыг

олон хугалсандаа би хүлцэл өчье. Би тэр үедээ зөв юм хийж байна гэж боддог байсан. Харин би одоо миний бодол буруу байжээ гэдгийг ойлголоо. Би ийм зүйл хийсэндээ харамсаж байна.

Зүрхний хэлбэр бүхий шилэн савыг хараарай, тэгээд бас миний тухай бодоорой. Хэдийгээр чи намайг хүлээн зөвшөөрөхгүй, бас үзэн ядаж байсан ч би одоо чиний сайн эгч байхын төлөө маш их хичээх болно. Би чамд хайртай. Чи ч миний хайрыг хүртэх гавьяатай дүү. Бидний төлөө хийсэн бүхэнд чинь маш их баярлалаа. Би чамд хайртай. Би чамд хайртай.

Энэрзаяа 2011.5.15

Аав нь хүүхдүүдээ энэ сургуулийг сонгож оруулсан нь учиртай. Та нарын сурдаг сургууль надад таалагддаг. Яагаад гэвэл сургуулийн захиргаа, багш нар шаардлага өндөртэй. Бүх хичээл англи хэл дээр явагддаг. Сургуулийн дотоод дүрэм журмыг ягштал мөрдөхийг сурагчдаасаа шаарддаг. Ингэснээр хүүхдэд зөв хүмүүжил олгодог. Хичээлийн завсарлагаар сургууль дээр

чанга хашгирах, чимээ шуугиан үүсгэх, ийш тийш хөөцөлдөн гүйлдэх, хэн нэгнийхээ эд зүйлсийг булаан авах, эрэгтэй сурагчид эмэгтэйгээ шоглох, үс гэзэгнээс нь татах, чирч гулдрах зэрэг явдал ерөөсөө байдаггүй. Бүх зүйл эмх цэгцтэй. Танай сургуулийн сурагчид хэзээд хүнтэй зөв боловсон харьцаж, хүндэтгэлтэй хандаж чадна. Миний хүүхдүүдийн сургууль хүүхдийн минь хүмүүжилд ихээхэн хувь нэмэр оруулдагт нь би баярладаг.

Сурагчдад төлөвшүүлбэл зохих чадвар дадлын талаар танай сургууль баримталдаг зарчим таалагддаг юм. Манай сургуулиудад нэвтрүүлэх туршлага болохуйц энэ зүйлийн талаар боловсролын байгууллагууд нийт багш нар, ялангуяа яам нь анхаараасай гэсэндээ энэ талаар зориудаар захиандаа оруулж байна. Дараахь зарчим, чанаруудыг хүүхдүүд мөрдлөг болгон эзэмшсэн байх ёстой. Үүнд:

ЭРЭЛХИЙЛЭГЧ /Inquirers/ - Хүүхэд төрөлхийн сониуч зангаараа сэтгэн бодох чадвараа хөгжүүлж байдаг. Тэд аливаа зүйлст суралцах явцдаа бие даах чадвараа харуулж, мөн бусад чадварыг ч олж авдаг. Хүүхэд аливааг суралцах чин хүсэл эрмэлзлэлээр дүүрэн байдаг бөгөөд энэ хүсэл нь тэдэнд насан туршид нь хадгалагддаг.

СЭТГЭГЧ /Thinkers/ - Хүүхэд, залуус сэтгэн бодох чадвараа байнга хөгжүүлж, шинжлэх ухаан, онолын болон амьдралын ээдрээ түвэгтэй асуудлуудад нарийн шалгуур, бүтээлч сэтгэлгээгээр хандаж, зөв зохистой, ёс зүйтэй шийдвэр гаргадаг байх ёстой.

ҮЗЭЛ БОДЛОО ЗӨВ, ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭГЧ /Communicators/ - Аливаа мэдээлэл, олон ургальч үзэл санааг төвөггүйхэн ойлгохын зэрэгцээ үзэл бодлоо нэгээс илүү хэлээр, харилцааны соёлтойгоор өөртөө итгэлтэйгээр чөлөөтэй илэрхийлдэг байж, бусадтай үр дүнтэй хамтран ажиллах буюу багаар ажиллах чадварыг эзэмшсэн байх учиртай.

ӨРГӨН МЭДЛЭГТЭЙ /Knowledgeable/ - Улс орны төдийгүй дэлхий нийтийн асуудал, үзэл санаа, концепцийг судалж, энэ явцдаа шинжлэх ухааны өргөн ойлголт, гүн гүнзгий мэдлэгийг олж авдаг байх

ЁС ЖУРАМТАЙ /Principled/ - Хүүхэд, залуус шударга ёс, үнэнч байдлыг эрхэмлэн хувь хүн, бүлэг хүмүүс, хамт олон болон тэдгээрийн нэр төрийг хүндэтгэдэг, өөрсдийн хийсэн үйлдэл, түүнээс гарах үр дагаврын хариуцлагыг хүлээдэг байх.

ХАЛАМЖТАЙ /Caring/ - Бусдын сэтгэл санаа, эрэлт хэрэгцээг ямагт ойлгон хүндэтгэж, өрөвч нинжин сэтгэлээр ханддаг. Үүнийхээ хэрээр

орчин тойрныхоо хүмүүст эерэг нөлөө үзүүлж, бусдын төлөө гэсэн чин сэтгэлтэй байх

БУСДЫН ҮЗЭЛ БОДОЛД ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДАГЧ /Open-minded/

- Өөрсдийн түүх, соёлыг сайтар судлан мэдэж, нандигнахын зэрэгцээ бусдын эрхэмлэдэг зүйлс, зан заншилд хүндэтгэлтэй ханддаг. Олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрч, цаашид бүхий л талаар өсөж дэвжих хүсэл эрмэлзэл дүүрэн байх.

ӨВ ТЭГШ /Balanced/ - Хүүхэд, залуус өв тэгш хүмүүжлийг эрхэмлэн өөрсдийн болон бусдын сайн сайхны тусын тулд оюун ухаан, бие махбодь, сэтгэл санааны өв тэгш байдал чухал гэдгийг ойлгож ухамсарладаг байх.

ДҮГНЭН ЦЭГНЭГЧ /Reflective/ - Сурах үйл явц, олж авсан туршлагаа дүгнэн, хөгжүүлэхийн төлөө анхаарч, өөрийн давуу болон сул талыг мэддэг, үнэлгээ өгөх чадвартай байх.

ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ, ЗОРИГТОЙ /Risk-Takers/ - Хүүхэд урьд өмнө таньж мэдээгүй шинэ тутам нөхцөл байдалтай учирсан ч зоригтой хандаж, түргэн шуурхай сэтгэн бодож, түүнд тохирсон стратеги, үзэл санааг боловсруулах сэтгэлгээ, чадвартай байж, өөрсдийн итгэл, үнэмшлээ илэрхийлж, түүнээ хамгаалах зоригтой байх.

Манай монгол сургуулийн багш нар энэ жишгээр хүүхдийн хүмүүжилд анхаарч, тэднийг сайн иргэн болж төлөвшихөд сургууль багш нарын үүрэг, хувь нэмэр нэн их гэдэгтэй санал нийлэх биз ээ.

Миний хүүхдүүд бол миний бахархал.

Аав нь та нартаа маш их хайртай шүү.



Парис хотод өглөө болсон ч нэг л ёозгүй бүүдгэр, эндэхийн саарал өнгөт тэнгэр юу юугүй дээрээс нөмрөн авах нь уу гэмээр харагдана. Ширүүн аадар бороо асгах нь уу гэлтэй үүлс бөөгнөрч, хэдэн өдрөөр бороо цутгахаар шинжтэй болоод ирэх чинь. Усан бороо уйлагнан орвол яалтай. Алтан нар миний Монголын хөх тэнгэрт хурц шаргал туяагаа тусган ихэмсэгхэн мэлтийж байдаг ч энд бол огтоос харагдах ч үгүй байна. Ийм өдөр аавд нь уйтгартай санагддаг. Аав нь та нарыгаа маш их санаж байна.

Аав нь хүүхдүүдээ, зөвхөн та хэдийг ч биш л дээ, Монголын бүх хүүхэд, залуусыг их амжилтанд хүрээсэй гэж хүсэж явдаг. Сурч боловсрох, хийж бүтээх амьдралын жинхэнэ алтан үе байдаг тул хүний хүүхэд, бага залуу нас амьдралын оршил болж өнгөрөх ёсгүй.

Хүн ямар нэг байдлаар амжилт гаргах хэрэгтэй. Амжилттай байх юм бол байгаагаасаа илүү “эротик” харагддаг. Хүүхэд, залуучууд та бүхнийг амжилттай-эротик байгаасай гэж би хүсэж байна. Эротик байхын тулд амжилттай, амжилттай байхын тулд маш их хөдөлмөрлөх хэрэгтэй болдог. Миний хүүхдүүд энэ үгийг санан “хард вокинг” хийн гүрийж, амжилтанд хүрэх ёстой юм шүү.

Амжилттай хүний ойрын жишээ бол аав нь байна. Би их амжилттай явж ирсэн. Намайг ямагт дээш нь татаж байсан зүйл бол амжилт. Амжилтын зам миний хувьд ямагт дардан байсан гэж би хэлэх дуртай. Сурагч ахуй, оюутан цаг, бизнес хийж байсан үе бүгд амжилтаар дүүрэн байсан юм. Аав нь хүүхэд байхаасаа хичээл номоо хичээнгүйлэн давтаж, би үүнийг яагаад ойлгохгүй байна, учрыг нь ухаж заавал олж мэдэх, ойлгох ёстой, би үүнийг хийх ёстой, зайлшгүй сурах, мэдэх ёстой, бүтээж бий болгох ёстой гэж өөртөө “ёстой” гэдэг үгээр ташуур өгч ирсэн. Гэтэл Германд очсон хойно тэнд дандаа л “ёстой” гэдэг үгээр хүүхдийг хүмүүжүүлдэг болохыг би олж мэдсэн юм. Германчууд хүүхдүүддээ багаас нь “ёстой” гэдэг үгийг хэлж ойлгуулдаг. Чи хичээл номоо сайн хийх, хууль дүрмийг ягштал дагаж биелүүлэх ёстой, тэгэх ингэх ёстой...гэх мэт. Хүүхдүүд нь энэ үгийг амьдралдаа хатуу мөрдлөг болгодог нь амжилтанд хүрэхийн нэг үндэс болдог.

Аав нь аварга сурагч байсан юм. Миний амьдрал тэр дотроо бага нас, сурагч ахуй болон оюутан цаг минь үнэхээр азтай, одтой гялалзаж өнгөрсөн юм. Математик, хими, физик, орос хэл, шатрын гээд бүх төрлийн олимпиадад оролцон аварга болохын зэрэгцээ сургуулийнхаа жил жилийн аваргаар шалгарч, урдаа барьдаг сурагч нь байв. Ер нь шулуухан хэлэхэд сургууль дээр Гүндалайгүй юм байдаггүй байлаа. Ялангуяа тооны хичээлд толгой өвддөггүй байсан юм. Хөдөөд тэр үед физикийн багш байгаагүй ч би ном, сурах бичгийг нь олж авч судалсаар физикийн олимпиадад оролцон түрүүлсэн юм. Мөн орос хэлний багш, ном сурах бичиг дутагдалтай байсан ч “орос хэл бие даан сурах бичиг”-ийг нухсаар, дүрэм таблицыг нь тангад ном мэт цээжилж, орос хэлийг олимпиадад түрүүлэх хэмжээнд сурсан юм.

Энэ мэтчилэн би хүссэн бүгдийгээ сурдаг, хичээл бүртээ онц дүн авдаг, тэр үеийн хүүхдүүдэд ямар л шаардлага тавигддаг байсан биелүүлэх гэж хичээдэг, юунаас ч болов хоцорч, доголдох дургүй хүүхэд байсны хэрэг одоо ч гарсаар байдаг. Шатар бол миний хүүхэд насандаа зайлшгүй сурах ёстой зүйлийн нэг яах аргагүй мөн тул шатарт өдрөөс өдөрт улам шимтэн хорхойсож зарим үед нойр хоолоо ч мартахад хүрдэг байв. Шатар тоглож сурсан бяцхан түүх минь сонирхолтой бас хөөрхөн санагддаг тул товч өгүүлье.

Аав маань намайг бага байхад л шатар тоглож сур гэдэг байсан нь алсын бодолтой захиас байсан юм билээ. Зургаадугаар ангид байхдаа нэг өдөр би Шагдар гуайнд явж ороход хүү Сэр-Одтойгоо шатар тоглож суулаа. Тэдний тоглохыг харж зогсох нээ шатар гэдэг тоглоом ер нь их сонирхолтой санагдсан тул би Сэр-Одоос шатар зааж өгөхийг хүслээ. Тэр ч зөвшөөрч надад шатар зааж өгөх нэрийдлээр намайг өдөрт бараг 20 удаа хождог байв. Манайх шатаргүй тул нэг өдөр би гэртээ лаан дээр шатрын дүрс сийлэн даамны хөлгөн дээр суурилуулснаар хялбархаан шатартай болж орхив. Лаа угаас цагаавтар өнгөтэй, дан цагаан шатар байж таарахгүйд эсрэг талынхад нь лааны тосноос дусаан хар өнгөтэй болголоо. Түүгээрээ тоглож байтал аав минь танилаасаа нэг хуучин шатар худалдан авч өгч баярлуулсан юм. Би шатар гайгүй тоглодог болсноор манайд орж ирсэн хүн бүрийг “шатар тоглоё” гэж шалж гуйгаад амар заяаг нь үзүүлэхээ болив. Сүүлдээ ерөөсөө хэн нэг хүнийг гуйхгүй, дандаа тоглож байхад амар гэж дүү Дэгээдээ шатар зааж өгөөд хоёулаа тоглодог болсноор муу дүүгээ ёстой 20 удаа хождог байсан даа хөөрхий. Шатар тоглож сураад сургуулийнхаа аварга болж, Хатгалын шатрын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж, улмаар Хөвсгөл аймгийн сурагчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцон 8-р байр эзлэв. Немцовичийн шатрын сурах бичгийг харж, их мастеруудын өрөг, гарааг судалж өдөржин шатрын хөлөг дээр ганцаараа дасгал хийж суудаг болов. Хожмоо би ХБНГУ-ын шатрын II зэрэгтэй болсон юм.

Аав нь хичээл зүтгэл, амжилт ололтоо хэрхэн үнэлүүлж байсан талаараа гуравхан жишээ дурдъя. Намайг гуравдугаар ангид байхад манай ангийн багш Мааньгүмбэн маань “Чи анги дэвшин суралцаж болно шүү дээ” гэж хэлсэн нь анги алгасан сурахыг л хэлж байсан юм билээ. Ээжийн найз Должин эгч ээжтэй минь хуучлан суухдаа намайг “танай энэ хүүхэд ном их уншина, эсвэл шатар тоглоод л сууж байх юм. Энэ хүү нэг юм

дуулгана аа” гэж хэлэхийг нь би сонсоод “нэг юм дуулгана аа” гэсэн үгийн учрыг тэр үед гүйцэд ухаараагүй ч магад сайн хэлж, магтаж байгаа байх гээд баярлаж билээ.

Германд байхад математикийн багш Броер маань намайг дандаа магтдаг байсан юм. Математикийн хичээл орж бодлого бодох болохоор манай ангийнхан бүгдээрээ Гүндалай чи самбарт гарч бод, бушуул гэж яаруулсаар намайг бодлогоо бодоогүй байхад заримдаа яаж бодох аргаа ч олж амжаагүй байхад гараач ээ, гараач ээ гэсээр байгаад самбарын өмнө гаргачихдаг байлаа. Би яаран сандран самбарын өмнө гарч, гарсан хойноо учрыг нь тайлаад ямар ч бодлогыг бодчихдог байсан юм. Багш маань ингэхийг анзаарсан бололтой надад “ГКА” гэдэг нэр өгсөн нь

GUNDALAI KANN ALLES –
ГҮНДАЛАЙ БҮХНИЙГ ЧАДНА

гэсэн үг байв. Оюутнууд намайг ГКА гэж дуудна. Би энэ талаар мартчихсан явж байтал хамт суралцаж байсан Р.Байгаль маань сүүлд Германд онгоцны буудал дээр таараад намайг “ГКА” гэдэг юм байна. Намайг гайхан зогсоход “Чи мартчихсан юм уу даа” гээд инээсэн юм. Би юу билээ, мартчихсан байна шүү дээ гэхэд “Gundalai kann alles” шүү дээ гэлээ. Тэгснээ яагаав чамайг математикийн багш Броер ингэж нэрлээгүй юу гэж сануулж, бид оюутан цагаа дурсан нэг сайн хөхрөлдөцгөөж билээ.

Эргээд бодоход энэ бүхэн маань аав, ээжийнхээ ачийг хариулах хариулал, хүүхэд залуу насны минь хичээл зүтгэл байж дээ.

Аав нь маргааш эх орондоо буцна.

Халуу дүүгсэн гэртээ харьж, хамгаас хайртай хүүхдүүдтэйгээ уулзах цаг ойртох тутам сэтгэл минь улам яарах юм.

Цовоо жаахан үрсээ санасаар

Цомцойж бөмбийсөн гэртээ ирлээ... гэсэн дууны мөрүүд санаанд орлоо. Аав нь энэ дууг бүрэн гүйцэд сурч дуулна. Энэ дуунд клип хийлгэнэ гэж бодож байна. Алс холд гэрээ санасан үед сэтгэлд их ойр байдаг дуу.

Баяр хөөртэй уулзацгаая.

Хүүхдүүд минь хичээгээрэй гэж захия.

Түр баяртай. Парис хот



Аав нь та нараасаа холдон алс тэртээ Америкт ирээд байна. Улс төрчийнхөө хувьд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль хэрхэн явагдахыг үзэх завшаан тохиолдсонд баяртай байна. Гэхдээ аав нь Америкт өөрийнхөө зардлаар ирсэн юм шүү. Амьдрал нь ядуу зүдүү байхад ард олныхоо татварын мөнгөөр хаа нэгтээ зорчин зугаалах сэтгэл огтоос байдаггүй. Ингэж ерөөс зүрхэлдэггүй болохоо аав нь та нарт ойлгуулах ёстой. Урьд өмнө Ерөнхийлөгчийн сонгуулийг сонирхож болох байсан хэдий ч энэ удаа нэр дэвшигч Барак Обамагийн тухайд илүү сонирхолтой санагдсан юм. Анхны өнгөт арьст нэр дэвшигч гэдэг талаасаа, түүнээсээ ч илүү Обама Сенатын гишүүн байхдаа хэлсэн үг, түүний байр суурь содон санагддаг байснаас тэр. Сонгуулийн сурталчилгаа тун сайн явагдаж байна. Ялангуяа Барак Обамагийн үг сэтгэл их хөдөлгөлөө.

Б.Обама: Миний эх орон төгс төгөлдөр биш гэдгийг би мэднэ. Үеийн үед бид ард түмэндээ амалсан тэгш байдал, эрх чөлөөний амлалтаа биелүүлэхээр тэмцээр ирсэн. Бид алдаа гаргаж, бидний явуулсан үйл ажиллагаа дэлхий дахинд бидний санаж байсанд хүрэхгүй байх үе байсан. Гэхдээ би Америк оронд хичнээн хайртайгаа бас мэднэ. Хоёр зууны хугацаанд бид их үнээр бусад улс орнуудын хамтаар илүү найдвартай дэлхийг бий болгохоор тэмцсэн. Дэлхийн хүмүүсээ, энэ бол бидний цаг үе. Дэлхийн ард түмээн, бидний тавьсан зорилгын цар хүрээ өргөн, өмнөх зам маань урт. Гэхдээ би та бүхний өмнө бид бол эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн угсаа залгамжлагчид гэдгийг хэлэхээр ирсэн юм. Энэ дэлхий ертөнцийг дахин шинээр бүтээе. Баярлалаа, Бурхан та бүгдийг ивээг. Баярлалаа, баярлалаа гэж тэр хэлсэн юм.

Ардчиллын өлгий энэ улс орноос аав нь улс төр, ардчиллын талаар нэлээд зүйл бичье гэж бодлоо. Аав нь улс төрд анх хэрхэн орсон талаараа дурсан санаж байна.

Миний бас нэгэн амжилт бол бие даан нэр дэвшиж, УИХ-д сонгогдсон явдал мөн. Миний хувьд бизнесээс өөр бодох зүйлгүй, өөр хийх ажилгүй нэг хэсэгтээ л таваргалаа. Гэтэл Монголдоо ирээд дөрвөн жил болчихсон 2000 оны хавартай золгосон байлаа. Хаврын уртад хувьдаа нэлээд зүйл амжуулан хийхээр төлөвлөөд байтал Хатгалаас нэг ангийн найз Лхагвацогт маань надад захидал ирүүлдэг юм байна. Захидалдаа:

- Би “Эрэл”-ийн намын үүрийн дарга болсон. Чи ирж нутгаасаа сонгуульд нэр дэвшихгүй юу? гэсэн байлаа. Би тоосонгүй, хариу ч

явуулсангүй. Гэтэл манай хамаатан Батдэлгэр Лхагвацогтын бичсэнтэй утга ижил захидлыг Ренчинлхүмбээс илгээсэн байв. Тун удалгүй нутгаас хүмүүс ирцгээж 45 дугаар тойрогт нэр дэвших хүн алга. Та аль нэг намын нэр дээр, эсвэл бие дааж нэр дэвшихгүй юу гэв.

Тэр цагаас би Төрийн эрх барилцаж буй улс төрийн намуудын үйл ажиллагаанд алдаатай, буруу ташаа зүйл их байгааг анзаарч мэдрэх болов. Ард олны аж амьдрал “нэг алхам урагш, хоёр алхам хойш” болоод байгааг ойлгож мэдэв. Ийм үед амин хувиа хичээн зөвхөн өөрийнхөө төлөө л зүтгэх нь утгагүй санагдан сэтгэл минь ихэд зовох болсон тул би аргагүй байдалд оров. Ард олны маань амьдралын зовлон намайг улс төрд түлхэн оруулсан юм гэж товчхондоо хэлж болно. Хөвсгөлөөс ирүүлсэн удаа дараагийн урилгыг санан би ер нь нэг нутаг очиж ирье гэж бодоод явж очлоо. Гэтэл нутгийнхан маань намайг хэрхэн угтаж авсан гээч. Тэд намайг “сурлага сайтай сайн хүүхэд байсан, одоо УИХ-д нэрээ дэвшүүлж, нутаг усандаа юм хийх цаг чинь болсон, бид дэмжинэ” гэцгээдэг юм байна. Ингээд аав нь сонгуульд бие дааж нэр дэвшихээр боллоо. Би сонгогдохын тулд тэднийг зусардах, хуурч мэхлэх, худал амлах зэргийг эхнээсээ л цээрлэж байсан билээ.

Аав нь урьд нь улс төрд бус, бизнест хүчээ сорьж явсан болохоор туршлага дутаж байсан ч ерөөсөө ухарч шантарсангүй, өөрийн төрөлх зангаараа гагцхүү урагшилсаар байлаа. Ардчилсан намынхны алдааг ард түмэн аяндаа мэдэж, аргагүй тооцоо хийх цаг нь болсон байсан юм байлгүй тэр жил Хувьсгалт намын 72 “депутат”- ыг сонгосон юм. Харин нутгийнхны маань намайг сонгов. Энэ нь надад үзүүлсэн их итгэл найдвар болохыг би гүнээ ухамсарлаж байлаа. Нутгийн зон олон маань намайг сонгосонд тэдний төлөө ажиллая гэсэн чинхүү хүсэл эрмэлзлэл маань улам нэмэгдэв. Анх удаа бие даагч УИХ-д сонгогдсон нь би агаад бие дааж нэр дэвшээд ер амжилт олохгүй гэсэн ойлголтыг эвдэж чадсан юм. Аав нь олон жил гадаадад амьдарч байгаад эх нутагтаа ирсэн үедээ ийнхүү Их Хурлын гишүүн болсон билээ. Энэ бол амар хялбар зүйл бус санасандаа хүрдэг, сарвайснаа авдаг аавын хүүгийн л ажил байсан юм шүү.

Түр баяртай АНУ. Вашингтон хот



АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн компанит ажил ид явагдаж байгааг дэргэдээс нь харж байна. Б.Обамагийн:

Эх орноо агуу гэдгийг дахин нотлохдоо бид агуу зүйлийг хэзээ ч хэн нэгэн өгдөггүй гэдгийг ухамсарлаж байна. Үүнийг өөрсдөө л бий болгож бүтээнэ. 21 дүгээр зууны эдийн засгийг сэргээн хөгжүүлэх хэцүү ачаа хариуцлагыг бидэнд ногдуулсан цаг үе иржээ. Ийм учраас бибүх америкчуудыг, ардчилсан намынхан, бүгд найрамдах намынхан, бие даагчдыг үеэ өнгөрөөсөн үзэл суртлыг таягдан хаяхын тулд шинэ санаа гаргаж ирэхийг, намчирхахын оронд нийтийн эрх ашгийг дээдлэхийг уриалж байна. “Миний хувьд аль нь дээр вэ” гэж асуухаасаа өмнө “Миний хүүхдүүдэд өвлөгдөх манай эх орны хувьд аль нь дээр вэ” гэж асуухыг сануулж байна. Эдийн засгийн жинлүүр дээр хувийн сонирхлоо гаргаж тавихыг цаашид зөвшөөрмөөргүй байна. Зээлдүүлэх, зээл авахдаа тооцоогүй хандаж, хөөсрөлт, хагаралтын сүйрэл дагуулсан мөчлөгт өртөх явдлыг цаашид гаргамааргүй байна гэж хэлсэн нь улс төрчдөд тун чухал үг санагдав. Аав нь Обамагийн зурагтай подволк, ном зэргийг худалдан авч түүнийг жинхэнээсээ дэмжигч болов. Энэ бүхэнд сэтгэл минь ихэд хөдөлсөн тул эрх чөлөөний хөшөөг зорьж Нью-Йорк оров.

АНУ-д ирсэн гадныхан зорин очиж үздэг зүйлийн нэг бол Эрх чөлөөний хөшөө юм. Хөшөөний талаар хэдэн зүйл бичье.

Эрх чөлөөний хөшөө (The Statute of Liberty) нь Франц улсаас АНУ-д бэлэг болгон өгсөн Нью-Йорк хотын Либерти аралд байрлах хөшөө юм. Хорвоогийн хамгийн аугаа бүсгүй хэмээн алдаршсан эрх чөлөөний хөшөө Нью-Йорк хотод ирж байгаа хүн бүрийг мэндчилэн угтана. Баруун гартаа эрх чөлөөний алтан бамбар барьжээ. Зүүн гартаа АНУ-ын тусгаар тогтнолын тунхаглал батлагдсан 1776 оны 7-р сарын 4, бастилийн цайзыг эзэлсэн 1739 оны 7-р сарын 14-ний өдөр гэсэн эрх чөлөөг бэлгэдсэн хоёр он сар өдрийг сийлсэн ном барьжээ. Тэр бүсгүйн гартаа барьсан бамбар нь эрх чөлөө, шударга ёсны бэлгэдэл билээ. Дарлал мөлжлөгийн гав гинжийг хөл дороо дэвсэн тасалсан эмэгтэйн титмийн долоон шовх шүд нь 7 тив, тэнгист түгэн дэлгэрч байгаа эрх чөлөөг билэгджээ. Уг хөшөөг 1885 оны 6-р сарын 17-нд Францын хөлөг онгоцоор тус хотод авч иржээ. Францын барималч Огюст Бартольдийн бүтээсэн хөшөөг 1876 онд АНУ-ын тусгаар тогтнолын 100 жилийн ойгоор бэлэглэх санаатай байсан ч амжихгүй байсаар 10 жилийн дараа л бэлэг болгосон гэдэг. Асар том хөшөөг сүндэрлүүлэхийн

тулд Бартольдид мэргэжлийн инженер хэрэгтэй байв. Тэрээр Эйфелийн цамхгийг үндэслэгч нутаг нэгт Гюстав Эйфельд хандсанаар санасандаа хүрчээ. Эрх чөлөөний бэлэг тэмдэг болсон энэ агуу бүтээл нь Европоос АНУ руу цагаачлан ирж байсан хүмүүст шинэ ертөнцийн шинэ амьдралын утга санааг илэрхийлж байсан байна.

“ Надад чөлөөтэй амьсгалахын төлөө тэмүүлж байгаа зүдэрсэн боолчлогдсон ядуу олон түмнээ өг” гэж хөшөөн дээр бичсэн ажээ.

Ардчиллын бэлэгдэл болсон агуу энэ хөшөөн дээр бичсэн эрхэм үгийг санан аав нь УИХ-ын гишүүн болоод хүн зонххоо төлөө ажиллаж, улс орноо болон ардчиллыг хөгжүүлнэ гэсэн ирмүүн хүсэл бодол тээж, урам зориг дүүрэн Парламентад орсон юм. Гэтэл ёстой санасны гарз болж, бүх зүйл “будаа” болохыг урьдчилан тооцоолж чадаагүй явжээ. Эрх баригчид ардчиллаас ухарч, коммунист байр суурь баримталж байх шиг надад санагдаж эхлэв. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үнэн бодит мэдээлэл цацахаа бараг больж, бүх зүйл сайхан болж, бүтэж байгаа мэтээр үзүүлэхийг хичээж, ард олны “тархийг угаах” хорт ажиллагаа явуулах болов. Парламент дарангуйлах аппарат мэт санагдсанд би Парламентыг “Дарлаамент” гэж нэрлэхэд хүрэв. Ард түмнээ басамжилж, улс орныг мугуйд аргаар удирдаж, социалист нийгмийг дахин байгуулж болохгүй” гэсэн бодол тэгэхэд төрж байлаа.

Ардчилал гэж ил тод байдал, шударга үнэнийг эрхэмлэсэн нээлттэй бас хяналттай төрийг хэлнэ гэдгийг ард түмэн аль хэдийн ойлгосон байлаа. Алдаж онодог ч ардчиллын төлөө байдгаар нь “хамтарч зүтгэе” гэж бодоод аав нь Ардчилсан Намд гишүүнээр элсэн орохоор шийдсэн юм. Ардчилсан Намын даргаар Д.Дорлигжав ажиллаж байсан 2000 оны 12 дугаар сард юм сан. Нэг өдөр би түүний өрөөнд давхиж ороод “Танай намд гишүүнээр элсэе” гээд өргөдлөө өгч билээ. Ийнхүү намайг гэнэт орж очиход Дорлигжав дарга:

- Хөөе юу болж байна аа, бүхэл бүтэн УИХ-ын гишүүн хүн манай намд элсэх гээд өөрөө ороод ирдэг, сонгуульд ялагдаж булайгаа дэлгэн зовж зүдэрч байхад ингэдэг хүн бас байдаг аа. Аль вэ, телевиз, хэвлэл мэдээллийнхнийг дуудаач, сүү хадаг аваад ирээч гээд тал тал тийш хүн гүйлгэлээ. Ингэж л аав нь Ардчилсан намд гишүүнээр элсэж, тэдэнтэй ардчиллын төлөөх дуу хоолойгоо нэгтгэн, хамтдаа тэмцэхээр сэтгэл шулуудсан юм. Ардчилсан намд гишүүнээр элсээд удаагүй би дэд дарга нь

боллоо. Ардчиллын төлөө хамтран зүтгэгчид, анд нөхдүүдтэй ч болсон юм. Ардчилсан намд элсэж орсноос хойш нам гэж юу байдаг болох, ямар үйл ажиллагаа явуулдаг, ямар сайн болон муу талтайг мэдэж авлаа. Би өөрийгөө Ардчилсан нам, Монголын ардчиллын үйл хэрэгт гавьяа байгуулсан хүн гэж бодож, хамтран зүтгэгч анд нөхдөө сайн, сайхнаар дурсаж явдаг.

Захидлаа түр завсарлая.
Хүүхдүүддээ их хайртай шүү аав нь.

АНУ. Нью-Йорк хот



Монголын улс төрийн амьдрал ээдрээ төвөгтэй байлаа. Энэ байдал аавынх нь хувьд хүндээр тусав. Ачааны хүндийг аргагүй үүрэх хувь ногдов. Улс төрийн зам маань бэрхшээл саад ихтэй байв. Тийм учраас тэмцэх хэрэгтэй болж ирлээ.

“Хүний эрх, эрх чөлөө тэр тусмаа үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө бүхий л Үндсэн хуулийн үндэс суурь болдог нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт. Түүнийг үгүй хийчихвэл бүх байгууламж нурна. Үндсэн хууль асар их алдаатай, хор хөнөөлтэйгээр бүтсэн байж ч болно. Түүн доторх хамгийн үнэ цэнэтэй зүйл бол суурь нь. Нэгэнт суурь эвдэгдсэн тохиолдолд бусдыг нь хамгаалах шаардлагагүй” хэмээн эрхэм Фукс хэлсэн нь санамсаргүй зүйл огтоос биш болох нь улам бүр ойлгогдох болов.

“Тааламжгүй үнэнийг түгээхээс айхдаа үгийн эрх чөлөөг хязгаарладаг төр засаг бол эгээ л өөрөө харагдахгүй байя гэхдээ нүдээ аньчихдаг бяцхан хүүхэдтэй адил” хэмээсэн нь яг л тухайн үеийн төр засагт тохирсон байлаа.

Чуулганы нээлт дээр цөөнхийн төлөөлөл үг хэлж болох эсэх талаар хуулийн зохицуулалт байгаагүй ч УНН-ын дарга О.Дашбалбар агсан үг хэлдэг байсан юм.

Би 2001 оны УИХ-ын чуулганы нээлтэд үг хэлэхийг хүссэн боловч надад хариу өгөөгүй юм. Харин эрх баригчид 2002 онд “УИХ-ын тухай” хуулинд өөрчлөлт оруулж, зөвхөн бүлэгт үг хэлэх эрх олгосон билээ. Энэ нь бүлэггүй цөөнхийг харсаар байж эрх мэдлээ ашиглан өөрсдөдөө

зориулан хийсэн, ардчилсан бус хэтэрхий бүдүүлэг зүйл байв. Хуулийг ийнхүү өөрчлөхийг би бүр эхнээс нь эсэргүүцэн өөрсдөдөө зориулж хууль зохиож болохгүй ээ гэдгийг хэлсээр байсан ч тус болсонгүй. Би янз бүрийн аргаар оролдож үзсэн ч чуулганы нээлт дээр үгээ хэлж чаддаггүй байсан юм. Парламент ийм ардчилалгүй байх нь сонгогчдын маань эрх ашгийг хохироож байна гэж үзэж байлаа. Тэгээд яг тухайн цаг үе, орон зай, нөхцөл байдалд тохирсон тэмцэл явуулах нь зүйтэй хэмээн бодох болов. Хоосон сайхан үгээр ард олны тархийг угаах ажиллагаа тасралтгүй явагдаж байв. Энэ бүхнийг мэдсээр харсаар байж тэвчихэд нэн бэрх боллоо. Олонх харин ийм үйл ажиллагаа явуулахдаа гаршин мэргэшсэн байсныг би тэгэхэд олж мэдээд гайхаж билээ. Ардчилал хөгжсөн оронд олон жил амьдарсан хүний хувьд би ардчиллыг “загас усаар дутагдах” мэт үгүйлэх цаг ирэх вий хэмээн сэрэмжлэх болов. 2002 онд УИХ-ын чуулганы нээлт дээр “үг хэлье” гэсэн хүсэлтээ би албан ёсоор бичгээр гаргалаа. Эрх баригчид тэгэхэд өөрсдийн зохиосон хуулийн заалтаас иш татан “танд хуульд зааснаар үг хэлэх эрх байхгүй” гэсэн хариу өгсөн юм. Ард түмний амьдрал айхавтар доройтсон үед сайхан хувцасласан хэдэн хүмүүс хуралдан, уралдан байж худал ярьж, ичих нэрэлхэхээ умартан “ам цуурч” байгаагаа чуулганы нээлт, төрийн ёслол хүндэтгэлийн ажиллагаа гэж үздэг байв. Надад үнэний тухай ярих, хэлэх шаардлага үнэхээр байсан юм. Би тухайн үед чухамдаа ийм л үүрэг хүлээж байлаа. Гэтэл намайг бүх болж бүтэхгүйг өнгө будаггүй дэлгэн тавьж, тэдний хуурамч нэр төрийг унагана гэдгээс ухаан алдталаа айдаг байлаа. Би тэдний хуурамч багийг нь хуу татан хаяж, үнэн дүр төрхийг нь уудлан илчлэх юм сан гэж боддог байсан юм.

Өмнөх хоёр, гурван удаагийн чуулганы нээлт дээр надаар үг хэлүүлээгүй, 2002 оны намрын чуулган дээр үг хэлэх боломж өгөхгүйг нь мэдэж байсан тул хэлэх үг, үзэл бодол, байр сууриа илэрхийлсэн, мөн эрх баригчдын хэрхэн дураараа авирлаж улс орноо хэрхэн коммунист аргаар удирдахыг эрмэлзэж байгаа талаар үзүүлсэн 10 гаруй плакат бэлтгэн УИХ-ын чуулганы нээлтийн үеэр барьж ард түмэндэ үзүүлсэн юм.

УИХ-ын чуулганы нээлт бол ард түмний амьдралыг чөлөөтэй хэлэлцэх индэр тул аав нь энэ индрийг ашиглах ёстой байсан юм.

Аав нь ганц дайчин ганцаардахгүй гэдэгчлэн гав ганцаараа УИХ-ын чуулганы гурван удаагийн нээлтийг тасалдуулан “будaa” болгосон юм. Энэ бол үг хэлэх үндсэн эрх, ардчилал ил тод байдлын төлөөх миний иргэний

эр зориг гарган хийсэн тэмцэл байлаа.

Миний хүүхдүүд шаардлагатай үед эр зоригтой байх ёстой юм шүү.

Та нарын минь, Монголын нийт хүүхдүүдийн ирээдүй гэрэл гэгээтэй байгаасай гэсэндээ хийсэн эрсдэлтэй тэмцэл түүх болон үлдсэн юм.

Та нартаа их хайртай болохоо дахин илэрхийлье. Аав чинь.

АНУ. Нью-Йорк хот



Хүүхдүүд минь ямар ч ажил алба хашсан хүнд хэрэгтэй зүйл заавал хийх ёстой гэдгийг санаж явахыг захиж захиагаа эхлэе.

Аав нь хүмүүст хэрэгтэй зүйл хийхийг л эрмэлзэж байлаа. Хүүхэд бүрт 10000 төгрөг олгох саналыг би анхлан гаргасан юм. Хүүхэд бүрт олгох 10000 төгрөг хүний амьдралд үнэхээр хэрэгтэй байсан юм шүү. 2004 он юм байна. “Эх орон Ардчилал эвсэл” байгуулагдаад сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө хийцгээж байлаа. Тэр үед Ардчилсан Намын дарга М.Энхсайхан байсан. Би тус намын дэд даргын сонгуультай байв. Би нэг удаа жаахан завтай болоод намынхаа байраар ороход Энхсайхан дарга, Цагаан, Цолмон нарын 7-8 хүн суучихсан мөрийн хөтөлбөр хийж байлаа. Намайг ормогц Гүндалай бидний боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрийг үз дээ гээд надад үзүүлэв. Хөдөөд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хээл хахууль, авилгатай тэмцэх гээд ...л зөндөө зүйл тусгагдсан байлаа. Тэгэхэд нь би шуудхан наадах чинь хүнд хүрэхгүй юм байна. Хүүхэд бүрт сар бүрт 10000 төгрөг өгье гээд биччих гэсэнд тэд биччихлээ. Дэлгэц дээр гарч харагдав.

Хүүхдийн мөнгө гэдэг чинь ямар сонин санаа вэ гээд бид энэ талаар ярилцан 10-аад минут санал бодлоо солилцов. Тэгснээ бүгд хүлээн зөвшөөрцгөөлөө. М.Энхсайхан дарга ямар сайхан санаа вэ гээд хүлээж авч байсан. Хүүхдээр дамжуулж мөнгө өгнө гэдэг шударга юм. Хичнээн олон хүүхэд, гэр бүл үүнийг хүлээж байгаа бол. Ажилгүй, орлогогүй хүмүүс маш олон байна. Ямар ч буруугүй цэцэг цэврүү шиг хөөрхөн амьтад томчуудын буруугаас болж хохирох учиргүй. Тэдний амьдралыг аз жаргалтай болгохын тулд тэдэнд мөнгө хөрөнгө зарцуулах ёстой, иймд үүнийг зайлшгүй хийх ёстой гэж би үзсэн юм. Ингэх нь тухайн үедээ

нийгмийн шаардлага, захиалга байсан юм шүү.

Ингээд хүүхдийн мөнгө “итгэлийн мөнгө” нэртэй мөрийн хөтөлбөрт орох нь тэр. Олон гэр бүл үүний үр шимийг хүртэж байгаад нь би баяртай явдаг. Энэ санаагаа алдахгүйн тулд маргааш нь Төв шуудангийн урд талд “Хүүхдийн мөнгө -10000 төгрөг Эх орон-Ардчилал эвсэл” гэсэн том плакат хадсан юм. Дараа нь Энхсайхан дарга над руу утасдаж, сайхан санаа санаж, алтан толгойтой байсанд чинь баярлалаа гээд дахин баяр хүргэж билээ. Монголын мянга мянган үрс хүүхдийн мөнгө авч байсан нь тэдэнд их тустай зүйл болсон юм. Мөрийн хөтөлбөрийн энэхүү заалт сонгогч олны анхаарлыг ихэд татаж, Улсын Их Хуралд надтай нийлээд дөнгөж хоёрхон суудалтай байсан Ардчилсан нам 2004 онд 30 суудалтай болсон билээ. Ийнхүү ардчиллыг аврах миний тэмцэл үр дүнтэй болж, хүсэл мөрөөдөл биелсэнд сэтгэл минь нэн хангалуун болж ирсэн юм.

Амжилт -хамгийн эротик болох талаар сануулж захиагаа түр завсарлая.

Амжилт гаргаж явахыг л хүсье



Миний хөөрхөн охин Энэржин аав нь чамдаа их итгэл өгч, чамаараа бахархаж яваа шүү. Охин минь 1996 онд Герман улсад төрж, тэндээ цэцэрлэг, сургуулиар дамжсан юм. Чи Англид шилжин суурьшсанаасаа хойш сургуулийнхаа “математикийн аварга” сурагч болсонд аав нь их баярласан. Миний охин Англид очоод хагас жилийн дотор л англи хэлийг маш сайн сурсан байлаа.

Аав нь охиноо миний охин шиг хамгийн хөөрхөн, хамгийн сайн бас хичээлдээ онц сурдаг охин өөр хаана ч байхгүй. Аав нь охиндоо их хайртай гэж хэлээд үнсэхэд-Хн гээд бумбагар хацраа хонхойлгон байж инээгээд “баярлалаа” гэж хэлээд дэргэдээс минь гүйгээд явчихдаг ч дотроо их л дуртай байгаа нь андашгүй байдаг сан. Миний охин зарим талаараа тухайлбал сэтгэн бодох чадвар, тооны хичээлд сайн зэргээрээ эрэгтэй хүүхдүүдээс ч илүү. Охин минь чи унаган герман, англи хэлтэйдээ сэтгэл ханахгүй япон, хятад хэлийг сурах ёстой юм шүү.

Хэлтэй бол хөлтэй гэдэг аргагүй үнэн. Аав нь англи хэл сураагүй бол АНУ-д Ерөнхийлөгчийн сонгууль хэрхэн явагдаж байгааг тухайлбал

Обамагийн яриаг хэрхэн яаж ойлгох байснаа төсөөлөхөд ч бэрх байна. Хэл сурсны ачаар л шууд нэвтрэлцэн ойлголцож байгаа тул амар хялбар юм. Хэл сурах явдал зайлшгүй гэдгийг нийт хүүхэд багачууддаа сануулан хэлэхийг хүслээ.

Хүүхдэд багаас нь хэл сургахад эцэг, эхийн зүгээс анхаарах хэрэгтэй. Англи хэлтэй хүн дэлхийн аль ч өнцөг буланд хүрч очсон газардах гэж үгүй. Хэлтэй хүн хоромхон зуурт дэлхий дахинаар тойрон аялж чаддаг. Аав нь англи хэл хэрхэн сурсан талаараа бичье. Англи хэл сураагүй байж өөрийгөө боловсролтой гэж хэлэхээс ичдэг байх хэрэгтэй гэсэн шаардлагыг би өөртөө хатуу тавилаа. Би 1989 онд нэг жилийн дамжаанд хичээллэн, англи хэл сурах эхлэлээ тавьснаас хойш англи хэлийг бие даан сурах ажиллагаа үргэлжлэв. Бизнесийн англи хэл сурч, чөлөөтэй ярьдаг болов.

Харин 2000 онд Монгол төрийн түшээ болсон үедээ түмэн олны төлөө зүтгэж, улс орноо өөд нь татахад англи хэлийг илүү сайн сурах нь зайлшгүй чухал юм гэдгийг улам бүр ойлголоо. Англи хэлний мэдлэгийн түвшингээ ихэд голж, ном сэтгүүл уншаад бүрэн ойлгох, ямар ч сэдвээр чөлөөтэй ярьж, илтгэл тавьдаг болохыг зорилгоо болгосон юм. Англиар өөрийгөө чөлөөтэй илэрхийлж ойлгуулах, бусдыг бүрэн ойлгох, олон улсын хуралд илтгэл тавьж, асуултанд хариулах, хурал удирдах зэрэгт бэлтгэгдэхийг хүсэж байлаа.

Би улс төрийн талаарх онол, алдартай хүмүүсийн илтгэл, улс орны хөгжлийн тухай ном, сэтгүүлийг толь бичгийн тусламжтайгаар уншихыг оролдож эхлэв. Эхний саруудад маш хэцүү, бараг үг болгоныг орчуулах хэрэг гарч байв. Хоёр дахь номноос толь бичиг хэрэглэх нь харьцангуй багаслаа. Англи хэлний дүрмийг мөн уншиж судлав. “Би Би Си”, “Си Эн Эн”-ийн нэвтрүүлгийг өдөр болгон үзэж, ойлгохыг хичээж машиндаа “Америкийн дуу хоолой” болон “Би Би Си”-г байнга сонсож байсан нь нэг сумаар хоёр туулай буудахын адил хэлний мэдлэгээ улам сайжруулахад тус нэмэр, мэдээлэл хүлээн авах гол суваг болов.

Хэл сурахад зөвхөн хувь хүний хичээл зүтгэл л хэрэгтэй. Оюутан залуус хэл сурахын төлөө хичээн зүтгэцгээх нь зүйтэй. Залуучууд их, дээд сургууль янз бүрийн мэргэжлээр төгсөж, хөдөлмөрийн зах дээр өрсөлдөх болсон өдгөө цагт хоёр эдийн засагч, хоёр хуульч мэргэжилтэй залуу байлаа гэхэд англи хэл мэддэг нь л ажилд орох магадлал илүү байх болно. Аялал жуулчлал хөгжиж, гадныхан хөрөнгө оруулалт хийж Монголд олноор ирэх

болсон өнөө үед залуучууд англи хэлийг зайлшгүй сурах, нэмээд япон, хятад, солонгос хэл сураасай гэж хүсдэг. Дор хаяж гурван хэл сурсан байхад энэ цаг үед өөрөө өөрийгөө аваад явчих боломж бүрдэнэ.

Хэл сурах эзэн хичээвэл заяа хичээдэг юм шүү.

Та нартаа чармайн суралцахыг захия.



Аав нь хүний нутаг, гүний хошуунд явахдаа ялангуяа жижигхэн хүүхдүүдээ их санах юм. Энэргүнж бол аавын охин. Ах, эгч нарынхаа нэрийн “Энэр” дээр аавынхаа “Гүн”-ийг залгаж дээр нь ганц “Ж” үсэг нэмэн түүний нэр бүтсэн түүхтэй. Үүгээрээ ч аавын амины охин болох нь амархан танигдана. Аавыгаа дүүтэйгээ булаацалдан бяцхан тэмцэл байнга явуулдаг байж билээ. Дүүтэй болсон болохоор урьдын адил аав, ээждээ тааваар эрхэлж тоглох аргагүй болсонд ихэд бухимдан сандарч байсан юм. Болж л өгвөл нүд хариулж байгаад дүүгээ шоглочих гээд байдаг байлаа. Одоо бол охин маань ухаажсан. Охин өөрийн гэсэн үзэл бодолтой бас бяцхан толгойдоо багагүй ухаантай. Нэг өглөө аав, ээж хоёрыгоо ажилдаа явахаар гарахад та хоёр явчихвал хэн намайг харж хамгаалах юм бэ гээд дагаж уйлаад үлдсэн нь санаанаас ер гардаггүй юм. Том хүнээс дутахааргүй юм ярьж биднийг бас л гайхшруулсан. Миний охин Энза эгчтэйгээ адил англи сургалттай сургуульд суралцан англи хэлийг чамгүй сурч байгаа. Охиноо бодсон нь багын минь явдал санаанд орж ирэв.

Аав нь энэ захидалд хэд хэдэн хөгжилтэй зүйлийн талаар бичье. Намайг жаалхан хүүхэд байхад манайх хоёр өрөө дүнзэн байшинд амьдардаг байсан юм. Унтлагын өрөөнөөс нааш шууд л гал тогоо залгадаг. Ах, эгч нар маань өглөө эртлэн хичээлдээ явцгаана. Харин би хоёр дүүгийнхээ хамт гурвуулаа гэртээ үлддэг байлаа. Миний хоёр дүүгийн бага нь хоёр настай, дараагийнх нь таван настай, би өөрөө долоон настай байв. Гурвуулхнаа гэрээ сахиж үлдсэн үедээ унтлагын том өрөөгөө цэвэрлэх гэж орохдоо “мангас”-аас их айдаг байлаа. “Мангас ирлээ” гэж биднийг хүүхэд байхад томцуул айлгадаг байснаас тэр. Би нэлээд айж байснаа зориг гарган “Мангас аа чамаас айхгүй ээ” гэж хаалттай хаалганы цаанаас хэлээд бага дүүгийнхээ баасыг хусаж арилгадаг байсан иргүй шахам болсон хутгыг

хуучин муу модон сандлынхаа хамт авч хоёр дүүтэйгээ том өрөөндөө ордог сон. Өрөөний голд нөгөө сандлаа тавьчихаад дээр нь хутгаа бас тавьчихна. Зориглон байж нэгэнт орсон болохоор шалыг нь шүүрдэж, сайхан цэвэрлээд буцаж гарахдаа хаалгыг нь сайтар хааж, нөгөө модон сандлаараа даруулж орхидог сон. Ингэвэл “мангас” биднийг яаж ч чадахгүй гэж боддог байснаас тэр юм.

Би хичээлдээ явах цаг дөхөхөд гэрээсээ гарч, ангийнхаа Баярхүүгийн ирж, бид хамтдаа сургуульдаа явдаг байлаа. Түүний аавыг Ёндонсамбуу гэдэг бөгөөд миний ойлгосноор “дарга” хүн байсан шиг санадаг юм. Ёндонсамбуу гуай Хатгалд тухайн үедээ фото аппаратаар зураг сайн авдаг цөөхөн хүмүүсийн нэг байж билээ. Гэтэл тэр намайг хараад л “энэ их үймүүлдэг, зодооч хүүхэд байгаа юм, зургийг нь авч тавих хэрэгтэй” гэдэг байв. Нэг өдөр би найзуудтайгаа Ёндонсамбуу гуайн ажлынх нь газрын гадаах хашааны дэргэдүүр явж байтал бөөн ус тогтсон байхыг олж харлаа. Тэр ус руу чулуу авч шидэхэд “пал, пал” гэж дуугаран аятайхан санагдсан тул дахин дахин шидэж, инээлдэж байтал мань хүн гарч ирээд - Яах гэж бохир усанд чулуу шидэж хамаг юм заваан муухай болгоод байгаа юм бэ? Бүх цонх халтартуулчихлаа. Энэ ер нь аягүй их үймүүлдэг, зодооч хүүхэд байгаа юм гэсэн үгээ дахин давтан хэлж намайг загнасан юм. Хүүхэд л болсон хойно би мартаад дараагийн өдөр нь Баярхүүтэйгээ хамт явахаар тэднийд очиход Ёндонсамбуу гуай гэнэтхэн миний гарын тохойноос бариад авдаг байгаа. Тэгээд хүүдээ хандан - Баярхүү чи гэрээс зургийн аппарат аваад ир. Үүний зургийг аваад... гэхэд нь Баярхүү маань гэрийн зүг ухасхийн хурдаллаа. Би түүний араас: - Баярхүү чи хэрвээ зургийн аппарат авч ирвэл маргааш яахыг мэдэж байгаа биз дээ гэж хэлэв. Намайг ийнхүү хэлж бараг дуусаагүй байхад ангийнхаа “атаман”-аас айсан юм байлгүй Баярхүүгийн хөл нь аяндаа суларч, алхаа гишгээ нь удааширлаа. Энэ зуурт би Ёндонсамбуу гуайн гарыг хазаж, хар хурдаараа зугатсан юм. Би Ёндонсамбуу гуайнд дахин огт ороогүй дээ.

Би зургаадугаар ангид байхдаа нэг өдөр хичээлдээ хоёр өөр оймс өмсөөд очсон юм. Тэр үед хүүхдийн оймс ховор байснаас нэг хөлдөө хар, нөгөө хөлдөө улаан оймс өмсөөд явтал гайтай юм шиг хичээл цонхолсноос болж оронд нь биеийн тамирын хичээл орох боллоо. Тийм юм болно гэж санаагүй тул би ихэд сандарч билээ. Бүх хүүхдүүд хичээлдээ орчихоод байхад би ганцаараа гутлаа тайлахгүй зогссоор байв. Биеийн тамирын

багш Цулаа маань “чи яасан бэ? гутлаа тайлаад хичээлдээ ороорой” гэхэд нь “багш аа миний гутал нэг тайлбал эргүүлж өмсөж болдоггүй юм” гээд хэлчихсэн чинь тэр надад дөхөж ирээд “тийм юм гэж байхгүй ээ” гээд намайг шалан дээр хэвтүүлэн гутлыг маань татаж тайлах гэж оролдоход нь би хоёр хөлөө ээлжлэн ээтийлгээд гутлаа тайлахгүй гэж үзэлцлээ. Гэтэл багш мэргэн арга олов бололтой, бөгс рүү минь өшиглөхөд миний хөл сулраад явчихлаа. Багш намайг дийлж, энэ зуурт хоёр гутлыг минь тайлж хаяхад хар, улаан хоёр өөр өнгийн оймс гарч ирдэг юм байна. Тэгтэл тэр надад “гүйгээд” гэдэг команд өгөхөд нь би ижил буруу оймстойгоо заал тойрон баахан гүйсэн дээ. Ангийнхаа охидуудаас их ичиж билээ. Хичээл тармагц л би сургуулиас гарч, ганцаар гэрийн зүг хар хурдаараа гүйсэн юм.

Сурагч байхад маань тохиолдсон бас нэгэн сонин хөгтэй явдал санаанаас огт гардаггүй юм. Онц сурдаг хүүхэд охидуудтай үерхэх ёсгүй гэж ойлгодог байсан юм болов уу даа, ямар ч байсан би охидуудтай ер үерхдэггүй байлаа. Харин манай ангийн хөвгүүд охидуудад “дурлалын шувуухай” нисгэдэг боллоо. Ийм моод дэлгэрч байсан үе юм. Хөвгүүд бүгдээрээ захидал бичиж суудаг сан. Түүндээ нэгэн ижил зүйлс хуулж бичээд дор нь өөр өөрсдийн нэрийг бичнэ. Захидлууд хоорондоо ялгагдах юм нь гэвэл гагцхүү бичсэн хүний гарын үсэг, хүлээн авах эздүүд нь өөр байснаас бусдаар ялгахын аргагүй ижилхэн байдаг байв.

Дурлалын захидлаа дугаарлан бичихийг нь яана.

Нуур байгаагүй бол нугас хаана шумбах билээ

Чи минь байгаагүй бол захидал хэндээ бичих билээ

Дурлаж бичсэн захидлын дугаар № 1.

Дурлаж бичсэн захидлын дугаар № 2 гээд л бичдэг байлаа шүү дээ.

Би нэг өдөр найз нарынхаа бичсэн захидлуудыг уншиж үзээд би ч бас яаж зүгээр байх вэ, захиа бичье гэж шийдлээ. Гэтэл манай ангийн хөвгүүдийн нэг нь бэлэн, их гоё үгтэй “дурлал”-ын захиа нөгөө ангийнхнаас олж ирснийг нь би яаран хуулж бичээд, дор нь нэрээ тавьж, хэнд явуулдаг юм билээ гэж бодож байснаа зэргэлдээ ангийн Цэцэгдэлгэр гэдэг охинд илгээлээ. Удахгүй толгой холбон бөөн шүлэг, найраг болсон захиа бас нөгөө нөхдүүдээс олж аваад хуулж анхны захидлынхаа араас явуулж орхив. Энэ мэтээр би дурлалын захиа дөрвөөс таван удаа бичсэн юм. Дурлаагүй атлаа дурлалын захиа бичсэн нь, бичих ч гэж дээ бусад хүүхдийн бичсэнээс

хуулж, хэнд ч хамаагүй явуулсан нь энэ юм.

Өвлийн нэгэн хүйтэн орой хамт сурдаг, надад их талтай байсан том даргын ганган охин намайг гэртээ хүргэж өгөхийг хүслээ. Тэр их хөөрхөн охин байсан юм. Би тэгэхэд малгайгүй явснаа ч анзааралгүй, түүнийг хүргэж өгөхөөр боллоо. Хамт явах зууртаа толгой нүцгэн байгааг минь хараад тэр охин надад хандан:

- Чи малгайгүй юм уу? Толгой, чих чинь даарахгүй байна уу? гэж их л эелдэгхэнээр асууж явсан юм. Би тэгэхэд нь нэрэлхүү зангаар

- Зүгээр ээ, миний чих ер даардаггүй юм гэж хариулж дуусаагүй байхад л шахам чих маань “час” гээд явчихдаг юм байна. Нэрэлхээд чихээ гараараа барих ч үгүй “гүрийсээр” нөгөө охиныг гэрт нь хүргэж өгөөд буцахдаа би гараараа хоёр чихээ өөрийн эрхгүй барьж авсан юм. Хэдийгээр ээлжлэн ээлжлэн барьж явсан боловч нэмэр болсонгүй. Маргааш өглөө нь хоёулаа битүү ус гүйн дэлдийж хүрэхүйеэ бэрх, өвчтэй болсон байлаа. Эндээс би нэрэлхүү зан хэнд ч хэрэггүй юм даа гэдгийг ойлгосноос хойш амьдралдаа дахин нэрэлхэхээ больсон билээ.

Аав нь баахан сургамж айлдаж залхаахгүйн тулд өөрт тохиолдсон хөгтэй явдлуудаас бичлээ.

Дараа баяртай уулзацгаая.
Аав нь та нартаа маш их хайртай.



Аав нь захиандаа амжилтынхаа талаар бичээд байгааг анзаарч буй биз дээ хүүхдүүд минь.

Аав, ээж хоёрын минь цуцашгүй хөдөлмөрлөдөг зан чанар үр хүүхэд бидэнд өвлөгдсөн юм. Би бүхий л зүйлийг гагцхүү хөдөлмөрлөж байж бүтээдэг гэдгийг ойлгон энэ зарчмыг баримталдаг болсон билээ. Сурагч байхаасаа л “би өөрөө өөрийгөө бий болгож чадсан” талаараа одоо бахархал дүүрэн боддог. Эргэн санахад надад харамсах зүйл огтхон ч байдаггүй, харин ч сэтгэл минь хангалуун явдаг билээ. Миний гол түшиг тулгуур бол аав, ээж хоёр минь байсан хэдий ч тэд маань жирийн л ажилчин хүмүүс тул миний өөрийн идэвх, зүтгэл л ирээдүйг минь тодорхойлох ёстойг би их эрт ухаарч ойлгосон байлаа.

Аав нь 1982 оны хавар Хатгалын арван жилийн дунд сургуулийг “онц” дүнтэй төгссөн юм. Аравдугаар ангиа төгсөөд аймгийн төв Мөрөн хотод конкурсын шалгалт өгч, хамгийн өндөр оноо авсан тул эхний байранд орж, МУИС-ийн герман хэлний бэлтгэл ангийг сонгож авлаа. Тэгэхэд хотоос шалгалтаар ирсэн нэг багш “хөдөөний хүүхдүүд энэ хүнд ангид сурч дийлдэггүй юм. Хүү минь чи наад ангиа солиод өөр хуваарь авахгүй юу” гэж гэнэт надад санал болгов. Би “зүгээр ээ, миний эгч яг энэ хуваарийг авч яваад дийлж, сайн сурсан юм даа” гэж хариулсанд тэр багш таг дуугүй болж билээ. Одоо бол миний сонгосон хуваарийг Улаанбаатар хотод авч очиж, дарга нарын хүүхдэд өгөх даалгавартай явсан биз гэж боддог юм. Тухайн үед миний эгч гэж би Халзвай гуайн охиныг хэлсэн юм. Халзвай гуайн охин гэж хэн бэ?

Хөдөө талын үзэсгэлэн болсон нэгэн хөөрхөн охиныг би анх Ханхад харж билээ. Ханх суманд очсон зун миний хувьд хонь хариулах, мал тууварлах ажил оногдсон юм. Намайг хонио хариулж явахад надаас насаар эгчмэд нэгэн охин морь уначихсан үхэр, хонь хариулж явдаг байлаа. Тэр охин зэгзгэр турьхан биетэй, хасын цагаан царайтай, тунгалаг хархан нүдтэй, нүд нь гэрэлтэн гялалзаж харагдах нь үнэхээрийн үзэсгэлэн төгөлдөр. Нэгэн сайхан “ялгуун саарал” морь унан явахад нь хүн бүхний харц түүн дээр аргагүй тусна. Хүний нүд татахуйц гоё ганган хувцаслах нь цаанаа л нэг донжтой. Түүний аав Халзвай нь мал баазын дарга хүн байв. Халзвай гуайн Германд сурдаг охин амралтаараа нутагтаа ирээд байгаа нь энэ ажээ.

Нөгөө хөөрхөн охин маань зунжингаа малаа хариулан, аав, ээждээ тусалсаар намар нүүдлийн шувууд буцах цагаар сургуульдаа яваад өгсөн байлаа.

Би хожим нь сургуулиа төгсөөд тэр охины адилаар Германд суралцах болж, Өвгөнхүү ахын найз Дрезден хотод байдаг Өлзий ахынд уригдан очсон үедээ тэдний байрны цахилгаан шатан дотор нөгөө гоё охинтой санаандгүй тааралдсан билээ... Ингэж бид хоёр хоёулаа Германд суралцаж, сургуулиа амжилттай төгссөн юм.

Аав нь зовлон үзэж зорилгоо тодорхойлсон тухайгаа та нарт бичих ёстой. Хүний амьдрал дандаа дардан шулуун замаар явдаггүй. Оюутан цагийн маань анхны жил аавын олон хүүхдүүдийн дунд, үе тэнгийнхэнтэйгээ хөгжилдэн бужигнаж, эрдэм номд шамдан суралцаж

сайхан байсан хэдий ч харин хувийн амьдрал минь жаахан хүндхэн байлаа. Би хүргэн ах Б.Өвгөнхүүгийнхэндээ амьдарч байв. Тэднийх Нисэхэд байр түрээслэсэн байсан юм. Ах, эгч хоёр маань хоёулаа оюутан болохоор мөнгө, төгрөгийн гачаал тэднийг бас тойрохгүй, дайрдаг байлаа. Тэгээд ч эгч дөнгөж төрсөн, нялх хүүхэдтэй тул би зав чөлөөгөөрөө хүүхдийг нь харж өгөх, бас мөнгө олж хувь нэмэрлэх гээд хүлээх үүрэг багагүй байв. Зарим үед огт мөнгөгүйгээс бид идэх хоолгүй болж, ус буцалгаж уугаад би тэднийхээ МУИС хүртэл алхан явж хичээлдээ ирэхэд яг тавин таван минут л зарцуулдаг сан. Автобусны мөнгө ч байхгүй болж, ийнхүү өөрийн хоёр хөлөөр жирийлгэх үе олон тохиолдож байлаа. Ийм байдлаар амьдарч, аж төрөн суутал 1982 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ээж минь “тэнгэрт хальсан тухай” аймшигт мэдээ ирж, бид нутаг явах боллоо. Энэ цагаас эхлэн би сэтгэл санаагаар ихэд унан, ижийгээ байнга санан дурсах болсноор хичээл номондоо шамдахаа түр больсон байсан юм. Тэгэхэд миний амин урсгал тасрах шиг болж, амьдрал минь уйтгар гунигаар дүүрэв. Ээжийгээ бүрмөсөн алдсан энэ хүнд үед би эрхэм зорилгоо зөвхөн их зүйлийг суралцах, тэгэхдээ “маш сайн” гэж тодорхойлсон билээ. Оюутан цагийн анд Лхамсүрэн маань тэр үед надад нэгэн бичиг өгдөг юм байна. Түүндээ “Чи амьдрал руугаа гар буугаар буудвал амьдрал чам руу их буугаар буудна” гэж бичсэн байв. Амьдрал бол агуу, бас их хорлонтой тул түүгээр тоглож хэрхэвч болохгүй, алдаа гаргавал хайрлахгүй гэсэн утга бүхий бичгийг найз маань өгсөн нь надад санаа зовнохыг байв.

Миний хүүхдүүд зовлонд хэзээ ч үл нугаларч, харин зорилгоо л улам тодорхой болгох ёстой юм шүү.

“Амьдралынхаа зорилгыг тодорхойл” гэсэн алдартай хүний үгээр захиагаа төгсгөө.

Та нартаа хайртай. Аав чинь

АНУ. Вашингтон хот



Аав нь захиандаа нэгэн болсон явдлын талаар бичье.

АНУ-ын ерөнхийлөгч Ж.Д. Буш 2006 оны зун Монголд анх удаа айлчилсан юм. Айлчлалынхаа үеэр тэр Парламентийн гишүүд, төр засгийн удирдлага, төрийн зарим байгууллагын төлөөлөгчидтэй уулзаж үг хэллээ. “Америк, Монгол хоёр ах дүүгийн барилдлагатай орон” гэж түүнийг хэлэх сацуу миний бие баяр хүргэмээр санагдаад суудлаасаа босон учир зүтгүй алга ташив. Гэтэл эх хэлнээс нь ойлгоогүй юм уу эсвэл их зантай хүмүүс таарсан уу, хэн нь ч над шиг суудлаасаа боссонгүй, алга ч ташсангүй. Би алга ташиж, бас хоёр гараа зэрэг хөдөлгөн тэднийг өөр шигээ босохыг уриалж жаахан зогсож байгаад ганцаардан арга буюу буцаж суудалдаа суух зууртаа эвгүй байдалд орчихов уу гэж бодсон ч “яагаад ингэж болохгүй гэж, сэтгэлийн хөдөлгөөнтэй л хүн байгаа биз, хүний хэлсэн үгийг дэмжиж урам зориг нэмээ л биз, өөрийнхөөрөө л байлаа тэгээд яах ёстой байсан юм” гэж өөрийгөө өмөөрөн бодсон юм. Эрхэм Буш үгээ хэлж дуусаад урд эгнээний хүмүүстэй гар барьж эхэллээ. Тэгснээ тэр ард долоодугаар эгнээнд байсан над руу хуруугаа хөдөлгөн дууддаг юм байна. Тэгэхэд нь би түүнд ойртон очиход Буш ч гараа сунгалаа. Би ч гарыг нь халуун дотноор атган барив. Нэг минут хиртэй гар гараа атгалцан зогслоо. Энэ үеэр би түүнд хэлэх юмсан гэж бодож явсан нандин үгээ - Эрхэм Ерөнхийлөгч өө монголчуудад жинхэнэ тус хүргэе гэвэл тэднийг АНУ-д визгүй зорчдог болгох хэрэгтэй юм даа гэж би англиар хэллээ.

Ж. Буш хариуд нь энэ тал дээр би ажиллая гэсэн юм.

АНУ-ын 3 дахь Ерөнхийлөгч Томас Жефферсон улс орныхоо түүхэнд үнэхээр гавъяатай санагддаг.

Манай Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд Жефферсоны жишгээр эх орондоо хэрэгтэй зүйл хийж бүтээл, нэр хоёроо зэрэг дуурсгавал нэн сайн сан. Тэрбээр АНУ-ын тусгаар тогтнолын тунхаглалыг зохиож, хүний эрх, эрх чөлөөний талаарх үзэл баримтлалын үндсийг тавьсан билээ. Ард түмэн эрхээ мэдэхгүй байж болно. Үүнийг нь улс төрчид далимдуулж болохгүй гэсэн утга бүхий эрхэм үгийг ч Жефферсон хэлсэн байдаг.

Жефферсоны бүх насаараа эрмэлзэж ирсэн эрх чөлөө тусгаар тогтнол ба тэгш эрхийн асуудал ажил хэрэг болсон төдийгүй АНУ-ын Конгрессын номын сан Виржиниягийн Их сургуулийг үндэслэн байгуулсан зэрэг үнэлж баршгүй гавьяа нь АНУ-ын 2 долларын дэвсгэрт, тавтын мөнгөн дээр түүний зургийг байрлуулахад хүргэсэн юм.

Та нартаа хайртай. Аав чинь

АНУ. Вашингтон хот



Аав нь ажил төрөлтэй холбоотой зарим зүйлийг бичихээс өөр аргагүй байна. Аав нь АНУ-д байхдаа Лас вегасын казинод орж сонирхлоо. 1000 ам. доллараас хэтрүүлэхгүйгээр тоглож ч үзэв. Казино гэхээр аймшигт мангас мэт үзэж, айх айдсыг монголчуудад маань бий болгожээ. Уг нь казино тийм аймаар зүйл биш юм. Ихэнх улс оронд казино байдаг. Аав нь Малайзын “Гэнтинхайланд”, Макаогийн “Лисбао”, Солонгосын “Волкер хилл”, Ардчилсан Солонгос, ОХУ, Герман, болон баруун европын орнуудын казиног сонирхож явахдаа казино бол зөвхөн мөрийтэй тоглоомын л газар, тэнд өөр юу ч байдаггүй, хэдэн талаас нь хэдэн зуун камер суурилуулан бичлэг хийн тасралтгүй хянаж байдаг, архидах, хар тамхи татах, биеэ үнэлэх, хүн худалдаалах болон бусад гэмт хэргүүд нүүрлэх боломжгүй газар болохыг мэдэж авсан юм. Казино ажиллуулан ашиг олж байгаа улс орон зөндөө байна. Германд л гэхэд казино, лотто, морин уралдаан, бинго зэрэг бүхий л мөрийтэй тоглоомын газрууд төрийн болон орон нутгийн монопольт эрхэнд байж, тэндээс олсон ашгийг нь хүн ардынхаа боловсрол, эрүүл мэндэд зориулж байдаг. Монголд казино хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Тийм ч учраас би казино байгуулахаар хуулийн төсөл санаачлан УИХ-д өргөн бариад байна. Энэ хуулийн төслөөр бол ажлын байрыг шинээр бий болгох, ашиг орлого сайтай ажиллах, тавигдах шаардлага нь тодорхой тухайлбал казино байгуулахдаа нэг сая ам. долларын хураамж төлөх, жил болгон нэг сая ам. долларын тусгай татвар нэмж төлөх, мөн бусад татвараа хуулийн дагуу төлөх шаардлагыг тавьсан юм. Мөн дээрх шаардлагыг хангавал элдэв тендер, лиценз, зөвшөөрөл шаардлагагүй, гадны ганц нэг компанийн эрх ашгийг урьтал болгоогүй, харин Монгол улсын эрх ашгийг дээдэлснээрээ монополь ноёрхол тогтоох бус чөлөөт өрсөлдөөний зарчмаар ажиллан ашгаа өгч байх казиног бий болгоход чиглэсэн юм.

Монгол улс түргэн шуурхай хөгжих хэрэгтэй байна. Казино байгуулан түүнээс олох ашгийг эрүүл мэнд боловсролын салбарт зориулах зэргээр ер нь бүхий л нөөц бололцоогоо шавхаад үзэх ёстой. Хийх ажил

мөн ч их байна даа. Хөгжсөн орнуудаар яваад үзэхэд хөөрхий монгол минь гэх харуусал аяндаа төрөх юм.

Б.Обамагийн ялалт амжилтыг нүдээр үзээд сэтгэгдэл өндөр гэртээ харих нь.

Хөөр баяраар дүүрэн уулзан учирцгаая. Хүүхдүүд минь

Баяртай

АНУ. Вашингтон хот



Аав нь Германд өөрийн төгссөн сургууль дээрээ ирээд байна. Сэтгэл их хөдөлж байна. Оюутан цагийн минь дурсамжуудаас ээлж дараалан санаанд орж ирээд ... Сайхан байна шүү.

Оюутан цагаа дурсахуйд сэтгэл минь өөрийн эрхгүй хөдөлдөг юм. Хэн хүний хувьд давтагдашгүй сайхан үе байдаг. Энэ цаг үед сурах шиг сурч ихээхэн зүйлийг мэдэж авах ёстой юм.

Аав нь 1983 оны намар бэлтгэл ангиа төгсгөөд Германы Нордхаузен хотод очсон юм. Одоогийнх шиг хил хязгаар нээлттэй, хэн мөнгөтэй нь хүүхдээ хүссэн газартаа, хүссэн сургуульд нь явуулж сургана гэсэн ойлголт тэр үед байсангүй. Маш сайн сурлагатай хүүхдийг яаж ч болохгүй тул явуулахаас өөр аргагүй байв. Би анх удаа салхийг нь хагалж, алс холын Герман оронд суралцан, Европын хөгжил, дэвшилтэй танилцсан нь дүү нарт минь үлгэр жишээ болсон юм. Их Герман гүрэн тэдний сэтгэлийг татан миний араас Дэлгэрдалай ах, Энхтуяа эгч нар чинь очиж суралцах болсон билээ. Нэг айлын гурван хүүхэд Герман улсын их, дээд сургуулиудад тэр тусмаа хөдөөнөөс очиж суралцана гэдэг тухайн үедээ ховорхон тохиолдол байсан юм. Дэгээ ах чинь Германы Йенад инженер, харин Энхээ эгч чинь миний байсан Галлед хөдөө аж ахуйн эдийн засагчийн мэргэжлээр төгсгөсөн юм. Ингэж гурвуулаа барууны боловсрол эзэмшиж, Европын соёл, иргэншлээс суралцах аз тохиосныг би аав, ээжийн минь буян, нутгийн маань уул ус түшсэнийх гэж одоо ч залбирч явдаг. Би Герман оронд улсын зардлаар эх орныхоо нэрээр суралцаж буйгаа ухамсарлан ихээхэн хичээж мэрийх ёстойг ойлгож байв. Хичээл хүнд гэдэг яггүй. Маш их уншиж,

бүтээлч байх шаардлагатай болсон юм. Би эх нутагтаа байснаас хамаагүй илүү мэрийн шамдаж байлаа. Ихэнх цагаа хичээлдээ зарцуулна. Надтай цуг суралцагчдаас олон оюутан хичээлээ дийлэхгүй сургуулиасаа хасагдан уйлаад нутгийн зүг буцацгааж байсан нь харамсалтай. Бид анх олуулаа очсон ч сүүлд тал нь л үлдсэн. Маш их шамдсаны хүчээр би зорин очиж сурсан сургуулиа амжилттай төгсгөж, дипломоо онц дүнтэй хамгаалсан юм. Германд анагаахын сургууль хамгийн хүнд нь тул үнэхээр онцсайн оюутнууд суралцдаг. Манайхны ярьдаг “арын хаалга” гэсэн ойлголт тэнд байдаггүй. Багш нартаа бэлэг, хадаг өгөөд аргална, дүн гуйж тавиулна, шалгалтаа өгсөн нэр зүүж, сургуулиа төгсгөсөн болно гэсэн ойлголт ёстой байхгүй шүү дээ. Ер нь өөрөө өөрийгөө мэхлэх боломж олгодоггүй л гэсэн үг. Ийнхүү би эх орныхоо хайр хишгээр “герман” боловсрол эзэмшсэнээрээ бахархдаг. Миний оюутан ахуй цаг хичээл номдоо шамдан, биеийн тамир, спортоор хичээллэн бас бизнес эрхэлж хөгжилтэй сайхан өнгөрсөн. Залуус минь

“Дэлхий ертөнц танд амьдралыг чинь өгөх ёстой гэж бүү бод, дэлхий ертөнц танд юу ч өгөх ёсгүй. Чамаас ч өмнө дэлхий оршин тогтнож л байсан” гэдэг үгийг санаж явах ёстой.

Английн Ерөнхий сайд асан Тони Блэйр:

Би 4 зүйлийг л хамгаас чухал гэж үздэг. Үүнд:

1.Боловсрол 2.Боловсрол 3.Боловсрол 4.Боловсрол гэсэн байдгийм. Үүнээс үзэхэд боловсрол хүнд хичнээн чухал болох нь ойлгомжтой байна.

Эрдэм номд чин сэтгэлээсээ ихэд хичээнгүйлэн суралцаарай.

Миний хүүхдүүд боловсролыг чухалчлах ёстой юм шүү.

Түр баяртай

Аав чинь



Аав нь төгссөн сургууль дээрээ ирсэн болохоороо бараг захиа бичих ч завгүй болоод байна. Германд анх ирж байсан үеэ өөрийн эрхгүй дурсан саналаа. Герман оронд анх төрсөн сэтгэгдэл тун сайхан байж билээ. Дулаан, тохилог дотуур байранд биднийг оруулсан бөгөөд үзэж харах зүйл зөндөө их. Анх тэнд очихдоо би бараг л өмссөн хувцаснаасаа өөр зүйлгүй байсан гэхэд хилсдэхгүй. 320 маркийн стипендтэй. Би түүгээрээ гадуур өмсөх пальто, гутал аваад дууссан тул өөр хувцас авах ямар ч боломжгүй байв.

Хамт явсан хүүхдүүд маань хэд хэдэн ээлжийн хувцастай, бас зарах борлуулах багагүй зүйлтэй, солих мөнгөтэй, ёншгойт гэдэг цэвэр мөнгийг хүртэл аваад оччихсон байж билээ. Би өмсөж явсан цамцаа оройдоо угаагаад, өглөө нь эртлэн босож индүүдэж өмсөөд л хичээлдээ явна. Хамт явсан хүүхдүүдийн маань гэрээс удахгүй илгээмж ирж, мөнгө, төгрөг бас зарах зүйл хүртэл ирдэг юм байна. Манайхаас харин юу ч ирдэггүй байлаа. Би урьдын адил цамц, өмдөө угааж, индүүдэн өмссөөр 11 дүгээр сартай золголоо. 11 дүгээр сарын 2-нд миний төрсөн өдөр болсон юм. Оюутнууд тэр үед бие биедээ их тусалдаг сайхан цаг байв. Нэг өрөөнд хамт байсан Уламбаяр, Батнасан, Дашням нар маань болон ангийн охидууд намайг ажиглаад мэдчихсэн байжээ, тэгээд өрөвдсөн юм байлгүй надад нэг, нэг цамц бэлэглэн би гурван ээлжийн цамцтай болж маш их баярлаж билээ. Тэр цагийн оюутнууд МХЗЭ-ийн гишүүд тул хамтран ажиллах, харилцан туслалцах гэрээтэй шахам байлаа. Би хэдийгээр өмсөх хувцас хунар, мөнгө төгрөгөөр дулимаг байсан ч харин хэнээс нь дутуугүй сурч, тун чиг амжилттай оюутны тоонд орж байсан билээ. Гэвч надад суралцахаас гадна бас нэгэн үүрэг оногдсон нь өөрийгөө хүний зэрэгтэй бүрэн хувцаслах, мөнгө төгрөгийн дутагдал гачигдлаас гарах явдал байв. Ингэж чадах эсэх нь миний овсгоо самбаанаас шалтгаалахаас гадна хэр амьжиргаатай эр болохыг харуулах бас л чухал шалгуур болох байлаа.

Германд их эрт, маш сайхан хавар болдог байлаа. Нэгэн өдөр хамт суралцдаг хэдэн хүүхэд “Бид нар Лейпциг хот руу явж, тэндээс цаг авч ирээд энд зарах гэж байгаа, Гүндалай чи бидэнтэй хамт явах уу?” гэхэд нь би дуртайяа зөвшөөрсөн юм. Тэр үед Лейпциг хүртэл таван цаг явдаг байв. Би оюутны стипендээ авсан байсан болохоор тэдэнтэй хамт очоод Арабчуудаас бугуйн электрон цаг гурвыг худалдаж авлаа. Авч ирсэн цагнуудаа маргааш нь худалдахаар авч яваад бүгдийг нь их амархан борлуулснаа санаж байна. Яг л бурхан надад замчлан заагаад гараас минь хөтлөн авч яваад байх шиг

санагдаж билээ. Орой байрандаа ирээд найзууддаа хэлэхэд тэднээс хэн нь ч цагаа худалдах оролдлого хийгээгүй байв. Магадгүй тухайн үед тэдэнд тийм шаардлага тулгараагүй ч байж мэдэх авч мань нөхдүүд жаахан залхуурсан л болов уу даа.

Миний хувьд анх удаа арилжаа, наймаа хийж буй нь тэр байлаа. Авч ирсэн цагаа ийнхүү бүгдийг төвөггүйхэн зарсан явдал надад “наймаа хийж болох юм байна” гэсэн сэтгэгдэл төрүүлж, урам нэмснээс хойш би нэлээд шамдах болсон билээ. Би найзууддаа дахиад хамтдаа цаг авахаар явцгаая гэхэд тэд ганц нэгээс илүүг зараагүй байсан болохоор хүсээгүй юм. Би ганцаар явж, зургаан ширхэг цаг авч ирж тэр дор нь борлууллаа. Түүнээс хойш дахин дахин явж, мөн ч олон цаг авч ирж худалдсан даа. Олсон мөнгөө цуглуулсаар зөндөө их мөнгөтэй боллоо. Хэлний курсээ төгсөх баяр дээр би бүх хувцсаа сольж, барууны маягаар хувцасласан байсанд оюутнууд тэр ч байтугай багш нар маань бүгдээрээ нүдээ бүлтийлгэн намайг дээрээс минь доош, дороос минь дээш гайхан харцгааж билээ. Яагаад гэвэл яг тийм хувцас өмссөн хүн оюутнуудын дотор, бас багш нарт байсангүй. Бүтэн жилийн туршид пөөдийж явсан Гүндалай нэг л өдөр бүх хувцсаа баруун Германыхаар сольж өмсөөд, мөн багагүй мөнгөтэй оюутан болж чадсанд л хамаг учир нь оршиж байлаа. Ер нь юм хийж, хөдөлж л байгаа хүн амжилтанд хүрдэг болохыг манайхан “явсан нохой яс зууна” гэдэг дээ. Энэ үнэн үг шүү. Үүнийг би тухайн үед амьдрал дээр нотлон харуулсныг хамт сурч байсан оюутнууд бүгд мэднэ. Тэр үед надтай хамт нэг хотод 40-өөд монгол оюутан суралцаж байсны хэн нь ч миний үлгэр дууриаллыг аваагүйд би их харамсдаг юм. Хэлний бэлтгэлээ дуусгаад би Галле хотын Мартин Лютерийн нэрэмжит Их сургуулийн анагаахын ангид суралцах болсон билээ. Аав нь ийнхүү амжилт бүтээлээр дүүрэн гялалзаж явсан юм.

Захидлаа түр завсарлая даа. Та нартаа сайн сайхныг хүсье.

Берлин хот



“Амьдрал бол таны хүссэнээ идэж болох зоогийн газар”

хэмээсэн үгээр захидлаа эхэлье. Оюутан байхдаа би наймаа хийдэг байсан талаараа түрүүчийн захиандаа бичсэн. Анх цаг худалдаж эхэлснээс хойш электрон бараануудыг ихээр худалдах болсон юм. Тэр үед Германд Оросын цэргийн ангиуд олноороо байсанд би тэнд очиж наймаа хийж эхлэв. Бизнесийн бүхэл бүтэн сүлжээ үүсгэсэн байсан тул надаас юм худалдан аваад цааш нь наймаалж, хэд гурван төгрөг унагадаг хүмүүс ч бий боллоо. Би энэ үеэр орос, герман олон хүнтэй танилцсан юм. Зөвлөлтийн цэргийн хурандаа нар ч надтай хамтран наймаа арилжаа хийдэг болсоор би Зөвлөлтийн цэргийн ангиудаар чөлөөтэй орж гарч байв.

Берлинд байдаг дипломатуудаас компьютер олноор нь худалдан авч германчуудад зардаг байв. Баруун германы бараа болохоор зүүн германыхан их сонирхон авдаг байсан үе. Хэдийгээр баруунаас нууцаар оруулж ирдгийг мэддэг ч аргагүй хэрэгцээ байсан болохоор авдаг байв. Ингэсээр би хоёр гуравхан сарын дотор асар их мөнгөтэй болсон юм. Яг мафитай кинонд гардаг шиг дипломат цүнхээр дүүрэн мөнгө цуглуулсан байлаа. Миний мөнгө 1988 онд зүүн Германы таван зуун мянган марк болсон байв. Тэр үед нэг марк манай гурван төгрөг хорин мөнгөтэй тэнцэж байсан тул нэг сая зургаан зуугаад мянган төгрөг болж байлаа. Зүүн Германы зуутын мөнгөн дэвсгэртүүд байсан юм. Миний мөнгө ийм хэмжээтэй болсон тухай аавдаа хэлэхэд аав минь цочирдон надад хариу хэлээгүй, хар цагаан үггүй, таг дуугүй өнгөрч билээ. Аав эртнээс нааш бидний хувийн асуудалд оролцдоггүй хүн байсан юм.

Тухайн үед миний хувьд мөнгө цуглуулахаасаа хадгалах нь бөөн асуудал үүсгэлээ. Хаана хадгалах нь тодорхойгүй болж, биедээ байнга аваад яваад байж болохгүй, банкинд хадгалуулах боломжгүй бэрхшээлтэй байсан үе. Би өөрөөсөө нэг курсын дор сурдаг дотны итгэлт нөхөр Бадарчийн Билэгтдээ цүнхтэй мөнгөө хадгалуулахаар шийдээд түүнд хандан: - Би чамд нэг цүнх хадгалуулъя гэхэд Билэгт маань шуудхан “За тэгээ” гэхэд нь би түүнд өгч хадгалуулсан юм. Цүнх цоожтой, тусгай кодтой. Билэгт бид хоёр найз тул нэг өдөр тэр надаас - Гүндалай цүнхэнд чинь юу байгаа юм бэ? гэхэд нь - Мөнгө гэхэд тэр тэгвэл үзье гэдэг юм байна. Би цүнхийг

нээж түүнд харууллаа. Пиг дүүрэн чихчихсэн зуутын дэвсгэртүүд байхыг харсан Билэгтэд би зүүн Германы таван зуун мянган марк буюу нэг сая зургаан зуун мянган төгрөг гэж мөнгөнийхээ тоог үнэнээр нь хэлэхэд Билэгт тэр даруйдаа “Түнээ чи надад хэдийг зээлүүлчих” гэж гуйлаа. Би түүнд хорин мянган марк буюу төгрөгөөр бодоход тэр үеийн ханшаар жаран дөрвөн мянган төгрөгийг өгөв. Энэ бүгдийг амжуулахын зэрэгцээ хичээл сургуульдаа бол толгой цохидог хэвээр байв.

Би оюутан байхдаа 1988 онд нэг Лада машин худалдаж авлаа. Тэр үед ийм машинтай оюутан байтугай их сургуулийн багш ч байгаагүй тул машинаа нууж унана. Жолооны үнэмлэх байхгүй ч өглөө эртлэн босож, эзгүй газарт дасгал хийсээр машин жолоодож муугүй сурлаа. Лада машин авснаасаа хойш би хэдийгээр жолооны курст бүртгүүлсэн боловч үнэмлэх авахын тулд Германд хоёр жил хэртэй хүлээх ёстой байдаг тул яарсны хэрээр үнэмлэхтэй болох боломжгүй байв. Гэвч Ладагаа унаад явдаг байлаа. Замын цагдаа нар хааяа зогсооход нь би тэдэнд МХЗЭ-ийн батлахаа үзүүлэхэд явуулчихна. Германы Стази (КГБ)-гийнхэн мэдээж намайг машин авч унасан, үнэмлэхгүй явж байгааг мэдэж байсан бололтой. Намайг нэг өдөр сургууль дээр гадаадын оюутнуудыг хариуцдаг ажилтан дуудаж: - Гүндалай гуай та баруун Германы мөнгө төгрөг ихээр авч явж, наймаа арилжаа хийгээд байгаа талаар мэдээлэл байна. Та ингэж болж байгаа юм уу? гэж асуухад нь - Би тэднээс шаардлагатай зүйлээ л худалдаж авдаг. Өөр наймаа арилжаа нэг их хийгээд байсан зүйлгүй гэж хариуллаа. Гэтэл “Та хойшид их болгоомжтой байгаарай, ахин дахин ийм юманд өртөж болохгүй шүү” гэж хэлсэн юм. Тэгтэл удахгүй Монголын Элчин сайдын яамнаас намайг дуудаж, НАХЯамны ажилтан Чинбат гэдэг хүн “Та барууны юм хум их хэрэглэдэг, барууны хүмүүстэй арилжаа наймаа хийх нэрийдлээр холбоо тогтоосон” гэх зэргээр буруутгахыг оролдов. Тэгэхэд нь би ганц нэг зүйл худалдаж явах үедээ танилцсан хэдэн хүн байгаа, өөр холбоо сүлбээ байхгүй ээ гэхэд нутаг руу чинь буцааж явуулна шүү гэж сүрдүүлсэн маягтай байсан нь миний бизнесийг зогсоож, зорьсондоо хүрэх замд минь саад болж чадаагүй юм. Би ч нууцаар наймаа хийсээр байв. Сургуульдаа амжилттай сурч байсан тул тэд яаж ч чаддаггүй байлаа. Миний хэлэх дуртай “Амжилтаас илүү эротик зүйл байхгүй” гэдэг үг энэ удаа дахин нотлогдсон юм. Хэрвээ би амжилтгүй, хичээл номондоо муу оюутан байсан бол герман нь ч тэр, монгол нь ч тэр намайг нутагт минь

хөөж явуулахад бэлэн байсан юм. Харин амжилт маань намайг энэ бүхнээс авран хамгаалж үлдээсэн юм даа.

Би 1989 оны зун Улаанбаатарынхаа гудамжаар ганган ногоон машинтай хурдалж давхидаг болов. Тэр бол миний Германаас худалдаж авсан “Бенз-190” маркийн машин байсан юм. Монголоос авсан үнэмлэхгүй, харин Германы жолооны үнэмлэхтэй явлаа. Гэтэл нэг удаа замын цагдаа шүгэл тасхийлгэн зогсоогоод - Үнэмлэхээ үзүүл гэхэд нь Германы үнэмлэхээ гаргаж үзүүлтэл ийм үнэмлэхээр монголд явахгүй ээ гээд үнэмлэх, машиныг минь хураан авав.

Замын цагдаагийн газарт очиж дарга нартай нь уулзахаас өөр аргагүй боллоо. Яая даа байз, мөддөө ойлголцоно ч гэж байхгүй дээ гэж бодоод дотогш дурамжхан явж ортол Замын Цагдаагийн Газрын дарга Т.Занашир гуай сууж байв. Тэр намайг хүлээн авч уулзаад - Дүү хүү их сайхан машин унадаг юм байна. Манайхан үнэмлэхээс чинь болоод хураан авчээ. Одоо үнэмлэхийг чинь машины хамт буцаан өгье гээд эргүүлэн өгч билээ. Би тэгэхэд нь ганц ч болов юм мэддэг, ойлгодог хүн байсанд нь ихэд баярлан, Занашир даргад дахин дахин талархлаа илэрхийлсээр гарч одлоо. Би гоё ногоон бензээ унан хөөрхөн охидуудыг суулган нийслэлийнхээ төв гудамжаар баруунаас зүүн тийш, хойноос урагш чиглэн хурдлан давхидаг байлаа. “Бенз-190” Германд дөнгөж шинээр гарч байсан болохоор их сонин сайхан санагддаг байсан юм шиг байгаа юм. Тэр үед манайд “бенз -190” байтугай хөгшин бенз унадаг хүн байгаагүй, гол төлөв “лада”, “москвич” машинууд л хөлхөлддөг байсан цаг. Хүмүүс намайг машинаа унаад явахад сонирхон харцгааж, зарим нь машинаа худалдахыг гуйдаг байв. Ийнхүү би Улаанбаатарт тэр үедээ сор болсон машин хөлөглөн бас ч үгүй бужигнуулаад авсан юм. Хааяа жаахан онгирч, машиныхаа оройн цонхоор гараа цухуйлган яг л “антен” мэт гозойлгон өргөж давхидаг байв.

Миний хүүхдүүд хүн ер нь амьдралд хөтлөгдөн урсгал даган хөвөх бус өөрсдийнхөө амьдралыг өөрийнхөө гараар бүтээн босгож, удирдаж авч явах ёстой юм даа.

Юм юмыг амжуулан сурч, бас ажиллаж амжилтанд хүрэх нь чухал гэдгийг хэлж захидлаа түр завсарлая.



Аав нь мэргэжлээ хэрхэн сонгосон талаараа бичье.

Би багадаа их мөрөөдөмтгий хүүхэд байсан юм. Хөвсгөл далайнхаа эрэгт суух агшинд надад хүсэл мөрөөдөл хайрлах шиг болдог байлаа. Би далайн хөвөөнөө жаргалтай байхдаа далайчин болох хүсэлдээ автдаг байв. Жюль Вернийн зохиолуудыг амтархан уншдаг байсан нь ч нөлөөлсөн байх. Түүний “Капитан Грантын хүүхдүүд”, “Усан доогуур хорин мянган бээр аялсан нь” зэрэг зохиолын өрнөл, үйл явдлууд миний сэтгэлийг ихэд хөдөлгөн далайн хөвөөнд төрсөн хүсэл дээр минь цучил нэмэрлэн ерөөсөө л далайчин больё гэж шийдэхэд хүргэсэн юм.

Далай дор амьдрал байгаагаар тэгэхдээ тэнд байх юм бүхнийг цэв цэнхэр өнгөтэйгөөр төсөөлдөг сөн. Усан доторх болоод ч тэр үү цэвэрхэн гэдэг нь аргагүй, тоос шороо, бохир огтхон ч үгүй. Гүн цэнхэр доторх амьдрал өчүүхэн ч хир буртаггүй. Бас амгалан тайван. Алтан нарны цацрал тэнд тусах тул огт харанхуй болдоггүй. Мөнхийн гэрэлтэй цэнхэр. Тэндэх амьдрал тэнгэртэй холбоотой болохоор яг л эх газрынх шиг агаад нэг л зөөлөн дулаан уур амьсгалтай. Энэ бол Гүн цэнхэр мөрөөдөл минь байсан юм.

Далайчин гэсэн мэргэжил байдаг юм байна гэж ойлгосон тул өөртөө хатуу итгэлтэй байлаа. Гэтэл чухам хаана, ямар сургуульд суралцан уг мэргэжлийг эзэмших талаар ямар ч ойлголтгүй явсан бөгөөд аравдугаар ангиа төгссөн жилээ хий дэмий л далайчин болохоор суралцах хуваарь ирсэн эсэхийг сонирхон шүүж үзсэн хэдий ч ийм юм огт байсангүй. Тэр үед мэргэжлээ хэрхэн сонгох болон ямар мэргэжлийг яаж эзэмших талаар таниулдаг хүн, тодорхой мэдээлэл ч байсангүй. Тэгэхээр нь би герман хэлний бэлтгэл ангийг авч, тэнд очвол алсдаа далайчин болох боломж олдох байх гэсэн бодолтой байлаа. Германд бэлтгэл ангиа төгсөөд далайчин болох хүслээ гүйцэлдүүлэх гэж Их сургуулиудын хуваарь дотроос анги хайсан боловч бас л байсангүй. Хүүхдүүд голдуу эдийн засагч, эмчийн мэргэжлийг сонгож байсан тул цаг үеэ дагаад эмчийн мэргэжлийг сонгосон юм даа.

Миний хүүхдүүд мэргэжлээ зөв сонгодог юм шүү.



Мартин Лютер Кинг

“Амьдралын хамгийн
чухал асуулт бол
та бусдын төлөө

юу хийж байна вэ?” хэмээжээ. Энэ асуултыг хүн бүр
өөртөө тавьж, заавал хариулах ёстой юм шүү.

Монголчууд “Нөхрийн хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтдэг” гэгцээдэг. Хүн дандаа өөртөө ашигтайг хайж бусдаас авч явах бус, чадах чинээгээрээ хүнд тусалж, бас өгч чаддаг байх ёстой гэж аав нь үздэг юм. Аав нь 1990 онд Их сургуулиа амжилттай төгсгөөд сургуульдаа үлдэж, жил гаруй ажиллан, эрдмийн зэрэг цол хамгаалах бэлтгэл хийлээ. Гэтэл гэнэт ер нь бизнесээ хийх нь зүйтэй юм байна гэсэн бодол төрж билээ. Эмч хүн цаг завгүй ажиллаад дөнгөж цалингаараа амьдарна гэж бодоход сонин санагдаж байв. Бүх насаараа цалин харсан хүн болбол ямар байх вэ? Түүний оронд бизнесээ амжилттай хийх нь зүйтэй юм байна гэж бодсон тул Германд бүтэн зургаан жил бизнес эрхлэв. Амжилт ч сайн байлаа. Би оюутан байхаасаа л бизнес эрхэлсээр хамгийн баян оюутан болж чадсан. Энэ удаа ч оросын рублийг зүүн Германы мөнгөөр солих наймааг амжилттай хийж ихээхэн ашиг оллоо. Зүүн Германы мөнгөн дэвсгэртийг барууныхаар сольж байх үед урьд өмнө нь цуглуулан хадгалсан мөнгөө бүгдийг солиулж, хоёр Германы дундах цайз хэрэм нуран унасны дараа өөрийн компаниа албан ёсоор байгуулан бүртгүүлэв. 1989 онд баруун, зүүн хоёр Герман нэгдэхэд би “GMET импорт экспорт” ХХКомпаниа Герман улсын хууль тогтоомжийн дагуу албан ёсоор байгуулан татвар төлж эхэлсэн юм. Дараа нь гадаад, дотоод худалдаа эрхэлж, дэлгүүр ажиллуулан Турк хоолны “дөнөр кебаб” газрыг хүртэл ажиллуулан германчуудын мөнгийг “сааж” явлаа.

Би Германд өөрийн компаниа байгуулчихсан, гар утас, факс, автомашин зэрэг ажил төрөлд шаардлагатай зүйлүүдийг ер дутах юмгүйгээр бэлтгэн базаасан, хэнд ч болов туслахад бэлэн “шижигнэсэн залуу захирал” явав. Германд “GMET” ХХКомпаниа байгуулаад ид ажиллаж байх үеэр Монголоос таних танихгүй маш олон хүмүүс намайг сураглан очицгоодог байлаа. Тэд намайг Монголд нэг сайхан бенз машин унаад явж байсан, Германд хамгийн баян оюутан, сайн наймаачин Гүндалай гэгч залуу байдаг гэсэн сураг яриагаар наймаа хийхээр очихдоо янз бүрийн тусламж, зөвлөгөө авахаар надтай уулздаг байв. Сүүлдээ долоо хоногт нэгээс хоёр

монгол хүнийг тогтмол хүлээн авдаг болж тэдэнд ямар нэг байдлаар тус дэм болох л ажилтай болов. Би ингэхдээ “нөхрийн хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ” гэсэн эрхэм үгийг санаж, тэдэнд чин сэтгэлээсээ харамгүй туслах сан гэж хичээдэг байсан юм. Хүний газарт намайг гэсээр хэдэн төгрөгөө бариад зорьж ирэхэд нь аль болох тусалж, дэмжин арилжаа наймааг нь бүтэмжтэй болгон ашиг орлогыг нь нэмэгдүүлэх сэн гэж мэрийж байлаа. Германд эх орныхоо тухай сонин сайхан сонсонгоо тэдэнд ямар наймаа хийх талаар зөвлөгөө өгч ярилцан, хамтарч ажиллахад юу нь буруу байх билээ. Архи дарс, спирт, мебель, хуучин хувцас хунар үгүй ер бүхий л зүйлийг сонирхсон хүмүүс намайг зорин очдог сон. Тэр бүхнийг бүтээж, хичнээн олон зүйлийг Монгол руу контейнер дүүрэн ачиж явуулдаг байв даа. Жилдээ хүний өөрийн нийлсэн 200 гаруй контейнер барааг Монгол руу илгээдэг байсан юм. ..

Аавд нь яаралтай ажил гарсан тул гадагш гарах боллоо.

Түр баяртай



Герман орон сэтгэлд минь дэндүү ойр байдаг юм. Арга ч үгүй биз дээ. Аав нь энд оюутан цагаа өнгөрүүлж, айл гэрийн ноён нуруу болж, амьдралаа зохиож, үр хүүхэдтэй болсон болохоор тэр биз. Тэгээд ч аав нь хүн болж төлөвших хариуцлагатай он жилүүдээ энд өнгөрүүлсэн юм. Германд “Медхэн” гэж бага охидыг хэлдэг. Харин би энд, гэр орноосоо хол байхдаа Энэрхэн охиноо их санаж байна. Би охиноо Энэрхэн гэж нэрлэсэн нь энхрийллийг илэрхийлнэ. Бага жижиг, отгон гэсэн утга бий. Жижигхэн минь, цэцэгхэн минь, энхрийхэн минь, эрдэнэхэн минь, Энэрхэн минь гээд л эцэс төгсгөлгүй хайр энхрийлэл болоод явчихна. Энэрхэн минь дөнгөж дөрөвхөн настай. Гэхдээ хоёр эгчийнхээ хамт сургуульд явж хичээлдээ маш сайн сурч байгаа.

Буяны дээд өглөг, авснаасаа өгсөн нь өлзийтэй гэж манай монголчууд хэлдэг юм. Итгэж юу тарьснаа бүгдийг хураана гэдэг худлаа

Ирээд буцахдаа цэцэрлэг орон гэрээ аваад явах худлаа

Байгаагаа зарахдаа нөхдөдөө царай бүү алд

Баралгүй үлдээвэл дайсан чинь авна гэдгийг мэд гэсэн О. Хайямын нэгэн рубайг санаж яв.

Эхлээд хүний үүрэх ёстой ачааны талаар хэдэн зүйл бичье.

Аав нь бүр багаасаа амьдралын ачаанаас өөрийн тэнхээгээр үүрэлцэж ирсэн билээ. Эр хүнийхээ хувьд, иргэнийхээ хувьд үүрэх ачаагаа үүрч явъя гэж хичээдэг. Яагаад ч юм би хэзээнээсээ “түүгээр явсан гайг үүгээр дуудах”-ын адил өөртөө их ачаа цуглуулаад байдаг хүн юм.

Улс төрд орсноор зарим хүний ачаа хөнгөрснийг гайхаж явахад миний үүрэх ачааны хэмжээ маш их болж нэмэгдсэнийг хэлэх юун. Би ард түмнийхээ зовлон, зүдгүүрээс нимгэлэхийн тулд аргагүй их ачаа үүрэх шаардлагатайг ухамсарласаар ирсэн. Миний ижил ачаа үүрэх дуртай нэгэн хүний бичсэн шүлгийг толилуулж ачааны талаарх ойлголтыг тодруулъя.

...Монгол гэдэг айлынхаа ирээдүй хэтийн төлөө

Манайх гэдэг ам бүлийнхээ эрх жаргалын төлөө

Хүн бүхэн өөрийнхөө ачааг дааж явбал

Хүйлэн хөх тэнгэрийн дор манайх хэзээ ч алзахгүй.

Хүний дэм авалгүй ачаагаа дааж явбал

Халуун ам бүлийнхээ дунд би өөрөө алзахгүй

Өөрт оногдсон ачаагаа үүрч яваадаа тайвшралгүй

Өрөөлийн даалгүй унагасан ачааг үүрэлгүй болохгүй... гэжээ

Би эхнэр хүүхдүүдээ аливаа зүйлээр дутагдаж гачигдахын зовлон үзүүлэхгүйгээр авч явах үүрэгтэйгээс гадна өөрийн ах, дүү, анд найз нартаа ч мөн туслах ёстой, өргөн олон түмэндээ харамгүй халуун сэтгэлээр хандаж, гараа сунгах үүрэгтэйгээ умартахгүй явж ирлээ.

Германд амьдарч байх үедээ ааваас гадна ах, эгч нараа бүгдийг нь урьж аваачин “юм” үзүүлж байлаа. 1989 онд гурван ахдаа машин авч өгч хөл залгах унаатай болгосон юм. 1987 онд өөрийн жолооч ах Дорждоо москвич машин авч өгч байлаа. Хөвсгөл аймагт 1988 онд очсон анхны волга-24 машиныг Баяндалай ахдаа авч өгсөн юм. 1989 онд би том ахдаа бенз машиныг авч өгснөөр ах машинаа унан хурдлан давхидаг байсан үе бий. Ахыгаа өнгөрөхөөс нь өмнө би ийнхүү баярлуулж амжсан юм.

Ихэнх ах дүү нараа орон байртай болгосны дотор Баяндалай ахдаа 1996 онд дөчин мянгатад хоёр өрөө байр, 1998 онд Оюунчимэг эгчдээ мөн хоёр өрөө байр авч өгөөд, дараа нь эгч байраа шинэчлэн солиход Баяндалай ах тэдний хоёр өрөө байрыг авч нийлүүлээд нийтдээ дөрвөн өрөө байртай

болчихож байлаа. Оюунчимэг эгчийн шинэчлэн сольсон байрыг бас би авч өгсөн юм.

Дүү Дэгээдээ 1996 онд Х хороололд гурван өрөө байр, 1997 онд дүү Энхтуяадаа I хороололд дөрвөн өрөө байр авч өгөх гэх зэргээр гар татаж байсангүй. Дүү нар бүгдээрээ байраа шинэчлэн дахин байртай больё гэхэд нь би бас дараагийнх нь байруудыг худалдаж авч өгч байсан нь ах дүү нараа баярлуулсан хэрэг болсон юм.

Аав нь зөвхөн өөрийн ах дүү нартаа туслах төдийгөөр зогссонгүй ээ. Нутгийнхаа ах дүү нарт 500 орчим тугалтай үнээ бэлэглэсэн юм. Мөн нутгийнхаа сумдын эмч нарт “ЭХО” аппарат бэлэглэн, тэднийг дамжаанд суралцуулсан юм. Нутгийн иргэдээ жил бүр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулдаг нь хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх зорилготой юм.

Нэг удаа Германы телевизийн “Дойче Велле” сувгийг үзэж суутал тайландчууд Финлянд улсад очиж, жимс түүгээд нэг тайланд хүн сард дунджаар 2000 ам. долларын ашигтай ажиллаад ирлээ гэсэн мэдээг авсан юм. Би Берлинд байрладаг төв рүү нь утасдан энэ нэвтрүүлэгт оролцсон тайланд хүмүүсийг авч ажиллуулж байгаа компанийн хаяг, утсыг олж өгөхийг хүсэхэд миний хүсэлтийг тэд тун удахгүй ёсоор болгов. 2006 онд би Финляндад хоёр ч удаа очиж, тэр компанийхантай тохиролцоод зун нь анхны жимсчид Монголоос Финлянд орныг зорьсон юм. Анхны 26 хүн очсоноос ихэнх нь гайгүй амжилттай ажиллан нэг сард 1500 ам. долларын ашигтай буцаж ирж байлаа.

2000 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улс тунхагласны баярт зориулсан бөхийн барилдаанд аймгийн арслан Азжаргал гэдэг залуухан бөх хийморьтой сайхан барилдан тав давахыг нь хараад миний сэтгэл хөдлөн улсын цолд ойрхон бөх байна даа гэж бодсон юм. Тэгээд би “улсын цолонд ойрхон бөх” гэсэн шагналыг бий болгохоор шийдлээ. Манайд улсын цолтой бөх болох хүртлээ амаргүй давааг давж, олон бөхчүүд сайн барилддаг ч улсын цолонд хүрч чаддаггүй тул бөхчүүдийг шагнах, урам зоригийг нь сэргээх хэрэгтэй юм гэж бодов.

2001 оны Үндсэн хуулийн баярт зориулсан бөхийн барилдаанд нөгөө Азжаргал арслан маань аатай сайхан барилдав. Тэгэхээр нь би анхны шагналаа түүнд гардуулан өгсөн билээ. Хамгийн сайн барилдсан улсын цолгүй бөхөд өгч байгаа мөнгөн шагнал юм. Бөхчүүдээ дэмжиж буй хэрэг.

Уг шагналаа томоохон барилдаануудад өгсөөр 10 жилийн нүүрийг үзэж байна. Надаас шагнал авсан бөхчүүдийн тал илүү нь улсын начингийн болзлыг хангаж, улмаар улсын өндөр цолонд хүрсэн юм.

Өөрт оногдсон ачаагаа үүрч яваадаа тайвшралгүй өрөөлийн даалгүй унагасан ачааг үүрэлгүй яавч болохгүй. Буяны дээд өглөг тул би ард олныхоо тусын тулд бие сэтгэлийн болон бусад өглөг өгөх учиртайг ухаарч явдаг.

Миний хүүхдүүд амин хувиа хичээхгүй аавынхаа жишгээр бусдад тус дэм болж яваарай.

Аав нь та нартаа итгэж байгаа шүү.

Сайн хүн болоорой гэсэн ерөөлөөр захидлаа түр завсарлая.

ХБНГУ Галле хот



Азийн орнуудаас хамгийн өндөр хөгжилд хүрсэн улс орон бол яах аргагүй Япон улс юм. Япон улс байгалийн баялаггүй шахам атлаа яагаад ийнхүү өндөр хөгжилд хүрэв гэсэн асуулт улс орнуудын дунд явсаар байдаг. Энэ улс өдгөө манайхны шүтээд байгаа байгалийн баялгаас ангид хөгжиж болдгийг харуулж өгсөн юм. Хүний хүчин зүйл л үүнд үлэмж нөлөөлсөн нь дамжиггүй. Оюу толгой Таван толгой бус, оюунтай төрсөн монгол хүүхдүүдийн толгой л чухамдаа энэ мэт хөгжил дэвшилд хүргэх нь зайлшгүй. Япон хүмүүс өглөгийн гараа сунгадаг ард түмний тоонд зүй ёсоор орно. Манай Монголд хэдэн удаа ч хандив тусламж үзүүлж байв даа. Гал алдах шахсан үед гараа харамгүй тэнийлгэсэн хүмүүс бол япончууд мөн. Японы парламент олон удаагийн хуралдаанаараа Монголд хандивлах асуудал хэлэлцэж байсан. Энэ дашрамд Монголын парламент Японы парламент шиг ажилладаг бол гэж би шүүрс алдан бодов. Ийм болох ч өдий биз дээ. Манай улс төрчид сонгогчдынхоо эрх ашгийг ямагт урьтал болгох ёстой ч явцуухан эрх ашиг сонирхлоо түрүүнд нь тавьж, нэр хүндээ алдах явдал зөндөө байх юм. Сайн нэр хамгийн үнэт баялаг. Үүнийг бий болгож чадаагүй хүн мөн ч золгүй амьтан аа гэж нэгэн гүн ухаантан хэлжээ.

Энэхүү үгээ улстөрчдөд илүү зориулсан мэт санагддаг. Улстөрч хэн бүхэн сайн үйлс бүтээх ёстойг хэлж байх шиг. Сайн үйлс бүтээж л байж сайн нэр зүүж, тэр нь тэдний хувьд хамгийн үнэт баялаг нь болно.

Би 2000-2004 онуудад УИХ-д ардчиллынхныг төлөөлөн ганцаараа сууж, ардчилал нь увайгүй шударга бус хүмүүст тохирохгүй болохыг жинхэнээр нь мэдэрч, “Шинжлэх ухааны салбаруудаас улс төр шиг авъяас, чадваргүй хүмүүсээртэгтлээ эрэмдэглүүлсэн” нь үгүй, “Засаг, төр хүмүүсийг сүйтгэдэггүй. Харин тэнэгүүд засгийн эрхэнд гарчихаараа түүний нэрийг баллаж орхидог. Аливаа түшмэд юуг ч бодож сэтгэдэггүй. Юуг ч үүсгэн оролдоггүй. Тэд хэзээ ч шинэ юманд оройлохгүйгээр үл барам, харин ч ялихгүй жижиг шалтаг, шалтгаанаар хориглож суудаг” болохыг хангалттай харсан юм. Тийм ч учраас тэдэнд хандан “Аяа, Ард түмэн гэдэг үнэхээр эрх чөлөөтэй байгаа цагтаа хүлцэнгүй номхон байдаг боловч өөрсдийг нь басамжилж тохуурхсан засаг төрийг нулимаг гэж л цухалдаж хилэгнэдэг”.

“Хэрэв та олонхийн талд байгаагаа анзаарсан л бол, үзэл бодлоо өөрчлөх цаг болжээ. Цөөнхийн зөв байх тохиолдол бий. Олонхи бол ямагт алддаг” гэсэн мэргэн үгсийг мөн ч олон удаа чанга дуугаар хашгирч хэлмээр болдог байж билээ. Аугаа Цицероны “Дээд зэргийн эрх бол дээд зэргийн эрхгүйдэл” гэсэн үгийг эрх баригчид хэзээ ойлгох, хүлээн зөвшөөрөх бол гэж харамсан боддог байлаа. Ийм учраас л би тэдэнтэй өөрийн хар чинээгээр ганц дайчин ганцаардахгүй гэгчээр үзэлцсээр тэмцсээр нэгэн сонгуулийн ээлжит хугацааг өнгөрүүлсэн юм даа.

“Хэрэв бурхдын улс гэж байсан бол тэнд л ардчилсан төртэй байх сан. Ардчилал нь засаглалын тийм төгс хэлбэр учраас увайгүй шударга бус хүмүүст тохирохгүй байгаа юм” гэж Францын сэтгэгч Ж. Руссо хэлсэн байдаг.

“Хэтэрхий онцгой чанараасаа болоод үхэж мэдэх хүн цөөн ч гэсэн бий шүү дээ. Илүү юмыг бусдаас нуухад хэцүү байдаг. Өндөр модыг бусдаас түрүүнд хөрөөдөж, том бугыг сүргээс нь онцлон агнаж, аварга могойг хамгийн түрүүнд хөнөөдөг” хэмээсэн үг бий. Миний хувьд энэ үг амьдралд хэрхэн хэрэгждэгийг зах зухаас нь өөрийн биеэр үзсэн юм. Би 2003 оны 8 дугаар сарын 24-ний өдөр гэнэт баривчлагдан, хоригдсон юм. Урьд өмнө нь би ямагт бусдыг сайн сайханд уриалан дуудаж, өөрөө тэргүүнд нь манлайлан явдаг байснаас бус энэ мэтийг үзсэн биш, гэмгүй байтлаа гэмтэн болж, эрүүгийн хэрэгт ээрэгдэн, “ганц худагт” гацах юм гэж

хэн бодох билээ дээ. Би шоронгийн мухрын харанхуй өрөөнд шөнө өдрийг баран ядахдаа юу эс бодохов. Энэ коммунистууд ер нь хэнийг ч яаж ч мэдэх хүмүүс юм. Шударга бус нийгмийг өөрчлөхийн тулд тэмцэх учиртай, иймд УИХ-ын намрын чуулганы нээлт дээр эсэргүүцэл заавал үзүүлнэ гэж хатуу шийдсэн юм.

Ардчиллыг хамгаалах гэж ийнхүү зориод аварга могойн адил болж, арай л шоронд явчихалгүй ард түмнийхээ дэмжлэг, оролцоотойгоор аврагдан үлдсэн билээ. Ард олон маань намайг өмөөрөн жагссан юм. Миний мэдэхээр нэг дор 10000 хүн жагссан удаа тун ховор. Гэтэл аавыг нь дэмжиж шоронгоос суллахыг шаардаж 10000 хүн жагссан гэж бодоход сайхан байдаг юм. Тэр тусмаа зуны аагим халуунд шүү. Намайг баригдан “Ганц худаг”- т орсон үед суллахыг шаардан олон түмэн маань жагсаж, миний ард түмэн бол хүний ард түмэн биш, миний ард түмэн гэдгээ дахин нотлон харуулсан юм.

Япон , Токио хот



Япон улсын эрүүл мэндийн салбар үнэхээр сайн санагддаг. Энд ирсэн биш аав нь Эрүүл мэндийн сайдаар ажиллах болсон үеэ санан дурслаа. Тэгэхдээ сайд явсан шүү гэх төдийгөөр бус хэрхэн хичээн мэрийж ажиллаж байсан цаг хугацаатай уралдан ажил амжуулж хийхийн тулд ямархан саад бэрхшээлтэй тулж байсан мөн юу юу амжуулж хийсэн зэргээ бодлоо.

Хүний жинхэнэ баялаг бол эрүүл мэнд юм. Хамгийн үнэтэй зүйл бол эрүүл мэнд. Эрүүл байх нь чухамдаа жаргал билээ. Улс орон хэдийгээр хичнээн ядуу зүдүү байсан ч хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө юугаа ч хайрлахгүй байх ёстой. Засгийн газрыг нам намаас төлөөлөл оруулан холимог байдлаар байгуулахад тэр үеийн Ерөнхий сайд - Ард Түмний Нам аль аль яамдыг нэгдүгээрт, хоёрдугаарт гэж сонгох вэ гэж асуухад нь би Нэгдүгээрт: Эрүүл мэндийн яам

Хоёрдугаарт: Эрүүл мэндийн яам гэж хариулсан юм. Энэ нь Эрүүл мэндээс өөр салбарыг авахгүй гэсэн үг байв. Орлого ашиг гэж байдаггүй бөөн зарлага гарлага болсон ганц яам нь энэ гэж хүмүүс дургүйцэх нь байсан ч

тэгж харсангүй. Ард түмний эрүүл мэнд үнэхээр тулгамдсан асуудал тул аргагүй л ажил хийхийг хүссэн хүн бол авах ёстой яам байсан юм. Ингээд ажиллаж эхэллээ.

Эрүүл мэндийн салбарт он удаан жилээр бугшсан муу муухай бүхнийг яахин бүрэн арилгаж амжих билээ. Гэхдээ томилогдсоноосоо огцрох хүртэлх хугацаа буюу есөн сарын туршид дараахь ажлыг хийсэн юм. Үүнд:

- Бөөрний гемодиализийн төв байгуулан бөөрний дутагдалд орогсдыг эмчилж амь насыг нь аварсан

- Эрхтэн шилжүүлж суулгах мэс заслыг эх орондоо анх удаа хийлгэсэн

- Элэг шилжүүлэн суулгах мэс заслыг мөн эх орондоо хийлгэх үндэс суурийг тавихаар эмч нарыг бэлтгэж эхэлсэн

- Эмчилгээ – оношлогооны томхон төв байгуулах ажлыг эхлүүлсэн

- Нэгдүгээр эмнэлэгт “Яаралтай тусламжийн төв” байгуулах бэлтгэл ажиллагааг хийсэн

- Хаяггүй, ядуу хүмүүст зориулан эмнэлэг нээж ажиллуулах болсон

- ДОХ болон БЗӨ-тэй тэмцэх сурталчилгаа явуулж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан

- Зарим эмнэлгийн байгууллагуудад бугшсан бизнесийн сүлжээг ил гарган, удирдлагуудтай нь хариуцлага тооцсон

- - Эмнэлгийн хувьчлалын асуудлыг зогсоосон

- “ Эрүүл монгол хүн ” хөтөлбөрийг эхлүүлсэн

- Эрүүл мэндийн нээлттэй өдөр бий болгосон /сар бүрийн 2 дахь долоо хоногийн бямба гаригт хоёр, гуравдугаар зэрэглэлийн үйлчилгээ явуулдаг бүх эмнэлгүүд ирсэн бүх хүмүүст эмнэлгийн оношлогоо үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлдэг /

- Эрүүл мэндийн салбарт “Инээмсэглэл” арга хэмжээг хэрэгжүүлэх болсон

- Эрүүл мэндийн даатгалын хуульд хамгийн боломжтой хувилбараар өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалыг бие даалган хөгжүүлж даатгал шиг даатгал болгох хуулийн төсөл боловсруулсан зэрэг.. бүгдийг хэрхэн тоочин дурьдаж барах билээ.

Аливаа улс орны хөгжлийг бие засах газраар нь шинждэг тул бийнхүү нэгэн тэмцэл явуулсан билээ. Энэ зуурт урьд нь зарим нэг эмнэлгээр

явж байхад үйлчлүүлэгчдэд бие засах газар огт олдохгүй цөөн хэдхэн байгааг нь эмч, сувилагч, асрагч, үйлчлэгч нар нь “хувьчлан” авсан мэт өмчилж, халааснаасаа нэгэн жижигхэн түлхүүр гарган онгойлгож, түгжиж байхыг нь анзаарч ажиглаж байснаа санав. Өвчтэй хүмүүс эмнэлэгт бараг үүнээс болж очихоос татгалзмаар санагддаг болов уу гэлтэй. Тэндээс яаман дээрээ шууд ирээд би тушаал гаргаж, эмнэлгийн жорлонгийн стандартыг тодорхойлсон юм. Бүх эмнэлгүүд, эрүүл мэндийн газрууд давхар бүртээ эмч болон өвчтөнүүдэд зориулсан эр, эм гэж ялгасан хангалттай олон бие засах газруудыг бий болгох тушаал гаргасан юм. Тэр ч байтугай эрэгтэй хүний босоо шээлтүүрийг би “босоовор” гэж нэрлэе гэж тушаалдаа заалаа. Энэ нэрийг англи, германаар “писаавар” гэдгээс санаа авч өгөв. Сайд аа та арай “босоогуур” гэх гээд байгаа юм биш биз гэж тоглоом наргиа ч хийх хүн байв.

2006 оны дөрөвдүгээр сард ЭМ-ийн сайд болчихсон хүсэж авсан салбартаа чухамдаа хийж бүтээхийн их хүсэл тэмүүлээр дүүрэн явах үестээ Орос хэмээх 23 дугаар дунд сургууль дээр Нийслэлийн Эрүүл Мэндийн газраас зохиож буй арга хэмжээний нээлтэд ирж оролцоно уу гэсэн нийслэлийн захирагчийн урилгыг хүлээн аваад давхиад очив оо. Нийслэлийн захирагчийн орлогч Баатарзориг, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга Бат-Сэрээдэнэ, Нийслэлийн эрүүл мэндийн газрынхан, болон эмч нар, 23 дугаар сургуулийн удирдлага, хүүхдүүд цугларсан байлаа. Намайг үгээ хэлж дуусмагц бэлтгэсэн өрөө байгаа тэнд хүлээн авалт хийж сургуулиа танилцуулъя гэдэг юм байна. Хүлээн авалтанд орох зав алга, харин танай сургуулийн бие засах газруудыг үзье гэхэд намайг тэгнэ чинээ санаагүй байх, за яах нь вэ дээ гээд дургүйхэн л байцгаав. Би заавал үзнэ гээд зүтгэчихлээ. Тэгтэл тэр олон хүүхдүүд багш нарын дунд ердөө л дөрөв тавхан ариун цэврийн наад захын шаардлагад нийцэхгүй, ард түмний хүүхдүүдийг ялгадастай нь холилдуулахаар шахам заваан юмнууд байж билээ. Арай ч тийм гэж бодоогүй явсан би сандрахдаа тоог нь олшруул, давхар болгонд байрлуул, эр эм гэж тусгаарла, эрэгтэйнхэд нь босоо шээлтүүр хий. Энэ бүгдийгээ янзалсан хойноо хүлээн авалтаа хийвэл би оролцоно гэж хэлээд гараад явсан юм.

2007 оны 1 дүгээр сарын 1 гэхэд сайдын тушаалын дагуу энэ асуудал шийдэгдсэн байх ёстой үед би огцорсон доо. Миний энэ санаачилга Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны салбарт нэвтрэх ёстой байсан тул эрхэм

сайдад нь энэ талаар хамтарсан тушаал гаргая гэсэн саналаа хүргүүлэхэд харамсалтай нь хариу нь үгүй гэсэнтэй ижил ирсэн юм даа.

Миний ажлыг унагахыг тал талаас оролдож байсан юм. Их хурал, Засгийн газар, Байнгын хороодын аль нь ч намайг дэмждэггүй байлаа. Тэр ч байтугай яам болон эмнэлгийн ажилтнуудыг миний эсрэг турхирч байсан юм. Ийм нөхцөл байдалд ажиллахад надад үнэхээр хүнд хэцүү байсан. Тэртэй тэргүй унаж буй эрүүл мэндийнхээ салбартай хамт улам доош орог гэсэн байдлаар миний ажилд хандацгааж байв. Эрх баригчдад ард түмний эрүүл мэнд тийм ч чухал байгаагүй юм. Үүнийг ойлгоод би өөрийнхөөрөө л ажиллая. Хүмүүсийн төлөө бага ч болов юм амжиж хийх ёстой гэж зүтгэлээ. Ингэлээ гээд намайг огцруулвал чиг огцруулаг хэмээн зориглон шийдсэн байсан юм. Би ч багагүй зүйлийг амжуулан хийсэн, тэгтэл ч намайг огцрууллаа.

Сайдын суудлаас чангахан барьж, МАХН-ынханд долгинож, “далласан газар нь ил гарч, далайсан газар нь далд орж явсан” бол би огцрохгүй байсан. Түүн шиг амархан юм байхгүй байлаа. Би хэн нэг хүний гар хөл болж явж ёстой чадахгүй юм билээ. Сайдаас огцрохдоо би харамсаагүй. Харин миний түмэн олноо гэсэн сэтгэл, зүтгэлийг минь нухчин дарахыг оролдож байсанд нь гомдож, олны төлөөх бодлоо гүйцэлдүүлж, зорьсон ажлаа амжуулан хийж чадаагүйдээ л тэдний өмнөөс харамссан.

Озаке хот



Японд сэтгэл амар байж болдог сайхан улс. Хамаг асуудлаа шийдчихсэн мэт санагдах энэ орон надад ямар ч ачаалал өгдөггүй юм. Иймд аав нь огт өөр зүйлийн талаар бодож сууна. Бага насныхаа хөгтэй явдлуудыг дурсан санасаар. Аав нь бага насандаа нэг удаа их гэнэ алдсан юм. Бороо орсны дараахан юм даг. Уг нь дандаа л уулын цаана харагддаг байсан солонго тэр удаа манай гэрээс холгүй байдаг наадмын талбай дээр ирчихсэн харагдах юм. Яагаад ч юм би ингэж андуураад түүнийг барьж авахаар гудамж алгасан хурдлан гүйлээ. Би солонгыг барьчих гэж мэрийн гүйсээр байлаа. Ойртоод очиход солонго цаашлан зугатаж, уулын цаана

гараад явчихдаг юм байна. Уулс бүр далайн цаана байдаг тул түүнд хүрэх арга үнэхээр үгүй болов. Урам минь ихэд хугарч гэртээ эргэж ирэхэд солонго дахиад л наадмын талбай дээр ирчихсэн харагдав. Буцаад ирчихэж дээ гэж бодоод л би түүнтэй дахин уйгагүй хөөцөлдөв. Тэгэхэд түрүүчийн үйлдэл яг давтагдаад солонго бас л уулынхаа цаана орчихож билээ. Ийнхүү надад солонго баригдаагүйд би харамссаар л байв. Хожим гал командынхныг ус шүршихийг харжээ зогсохдоо ус нар хоёроос солонго үүсдэг бөгөөд тэр хэзээ ч баригдахгүй болохыг мэдэж дэмий л түүнтэй хөөцөлдсөнөө ухаарсан юм даа.

Нэгэн хөгтэй явдал бол Хатгалын төвд байдаг хүүхдийн цэцэрлэгт би дүү Дэлгэрдалайн хамт явдаг юм байна. Би нэг өдөр цэцэрлэгийнхээ цонхоор гадагш харжээ байтал хичээл номондоо явдаггүй, сахилгагүй, дураараа нэг хүүхэд гадаа гудамжинд зогсоод ганцаараа молоко сорон ууж байх нь харагдав. Би түүн дээр шууд гүйж очиход тэрээр: - Гүндалай чи молоко уух уу? гэв. Би дуртайяа зөвшөөрөн молоко сорж уугаад зогсож байтал миний дүү намайг олж хараад хэдэн хүүхдүүдийн хамт хүрээд ирдэг юм байна. Би дүүдээ болон дагаж ирсэн хүүхдүүдэд молоко уулгаж байтал цэцэрлэгийн багш Таня хүрч ирээд намайг аашлан - Чи яагаад хүүхдүүд уруу татаж, гудамжны хүүхдээс молоко уулгаад байгаа юм бэ? гэсээр дагуулан явж, дүү бид хоёрыг өрөөний нэг нэг буланд зогсоон шийтгэлээ. Дүүгийн маань хоёр гарыг өргүүлж, надад нэг сандал бариулаад зогсоодог юм байна. Миний гар өвдөхийн эрхэнд сандлаа толгой дээрээ унагачих гээд арай ядан байхад багш хэнэг ч үгүй, хараагүй дүр үзүүлж, их удаан зогсоосон юм. Би сандлаа толгой дээрээ хариугүй унагахын даваан дээр багш: - Чи дүүгээ ангид нь оруулж өг гэлээ. Би баярлан дүүгээ дагуулж гараад ангид нь дөнгөж оруулж орхиод хар хурдаараа жирийлгэн гэрийн зүг гүйлээ. Таня багш энэ үед намайг хараад миний араас элдэн гүйж бүр хариугүй барьж авахын даваан дээр, багшийн гар миний нурууг шүргэн шүргэм байх алдад би хурдаа нэмэн гүйсээр түүнээс холдон арайхийн амжиж гэртээ оров. Миний хувьд цэцэрлэгт хоёр сар гаруй л явсан юм. Энэ өдрөөс хойш би цэцэрлэгт дахин хэзээ ч яваагүй юм.

Бас нэгэн болсон явдлын талаар өгүүлье. Манайд нэгэн баадуутай цаг байдаг байлаа. Нэг өдөр би тэр цагныхаа ар талынх нь тагийг онгойлгож үзтэл ганц том араа огт эргэхгүй байх шиг санагдав. Уг нь маш удаандаа эргэж, өөрийн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байсан нь мэдээж л

дээ. Би жаахан харж байснаа хүүхдийн тэвчээргүй зангаар илүү дугуй араа байна гэж бодоод сугалж аваад ширээн дээр эргүүлж тогломоор санагдаад явчихлаа. Тэгээд тэр арааг салгахад пүрш нь падхийтэл дуугарч сунаад цаг ажиллахаа болин зогсов. Би ч сандран авсан зүйлээ буцаан хийх гэж оролдоод оролдоод нэмэр болоогүй тул бүр ядаад цагаа нэг юмны араар хийж орхилоо. Ингэж баадуутай цагаа эвдчихэж билээ.

Намайг дөрөвдүгээр ангид байхад орос хэлний хичээл заахаар Зөвлөлтийн мэргэжилтэн нэг багш ирэв. Би резинээр хийсэн жижигхэн чавхандаа цаас нугалан хавчуулаад тэр багшийг самбар дээр юм бичиж байхад нь араас нь харваж орхилоо. Тэгтэл цаасан сум түүний яг толгойд тусаж, үсэнд нь тогтоход багш гайхан ийш тийш харж байснаа хэн харавсныг мэдэж чадалгүй өнгөрлөө. Дараагийн удаад би дэвтрийн цаасаар пуужин хийж, хичээл зааж байгаа орос багшийн зүг хөөргөлөө. Пуужин хөөрч багшийн үсэнд буухад багш энэ удаа их хурдан эргэж харан намайг хөөргөснийг мэдээд ангийн багшид ховлолоо.

Ангийн багш Пүрэвжий маань орос багшийн өмнөөс намайг буруутган зэмлэж, аавыг ажлаас нь дуудаж ирүүлэн энэ тухай хэлэхэд аав маань хэсэг дуугүй сонсож байснаа багшийг - Чи намайг ажил ихтэй байхад ийм юмны төлөө дуудаж ирүүллээ гэж үү гэж багштай ам зөрөн хүүхэд хүмүүжүүлэх бол чиний ажил шүү дээ хэмээлээ. Удсан ч үгүй аав ангиас гарч явлаа. Багш тухайн үед нэг их юм хэлэхгүй үлдсэнээ шаралхсандаа тэгсэн үү хожим хувийн хэрэгт маань намайг их сахилгагүй хүүхэд, Зөвлөлтийн мэргэжилтэн багшийг чавх, пуужингаар харваж байхад эцэг нь өмөөрч дутагдлыг нь хаацайлж байсан хэмээн бичиж үлдээсэн байж билээ. Миний хөгтэй явдлууд үүгээр дуусахгүй ээ. Дараагийн захиандаа үргэлжлүүлэн бичье.

Түр баяртай

Токио хот



2003 оны зун надад тохиолдсон нэгэн хөгтэй явдал санаанд орлоо. Би хэсэг найз нартайгаа нэг удаа тарвагачлахаар явдаг юм байна. Амьдралдаа тарвага унагаж үзээгүй байлаа. Би тарвага сахиж суух зуурт мөддөө гарч ирэхээргүй санагдахад “надад намнуулахаар нүхнээсээ гүйж гарч ирэх тарвага хаанаас байх вэ” гэж бодохын зэрэгцээ “амьтны амь таслах хэрэг ер байна уу даа” хэмээн бодож, сонирхол тийм ч их төрөхгүй байлаа. Тэгтэл атгасан гар шиг юм үзэгдэхэд энэ чинь юу вэ, ийм чулуу байсан билүү гэж таньж ядан байх зуурт маш хашир тарвага байсан бололтой нүхэндээ буцаад орж явчихав. Миний тарвага бууддаг ч өнгөрлөө гэж бодоод босож цааш явтал гэнэт яах аргагүй нэг хөөрхөн тарвага нүхнийхээ дэргэд, дошин дээрээ булцайн сууж харагдав. Үүнийг чинь л ёстой үзээд алдая гэж бодоод сэмээрхэн мөлхөж ойртов. Гэтэл тарвага яг урьдын адил нөгөө байрандаа байсаар байхад нь гайхаж, “намайг харчихсан л баймаар юм, яагаад нүхэндээ ордоггүй юм бэ” гэж бодов. Би бүр таван метр хэртэй ойртож очиход тэр орох шинжгүй, дэмий л нүхээ сахин байсаар байх юм. Би “тарваган тахал туссан юм болов уу, яасан юм бол оо, яачихсан мангар тарвага байдаг юм бэ” гэж бодоод нэг метр хэртэй ойртоод харахад хөөрхий зайлуул урхинд орчихсон тарвага байж байдаг байгаа. Тэгэхэд би түүнийг хэсэг өрөвдсөнөө нэгэнт л тарвагачилж яваа хүн юм хойно өөр арга алга даа гэж өөрийгөө зоригжуулаад дэргэд нь хүрч очоод бараг тулгаж байгаад буудаж орхив. Тарвагаа урхинаас нь салгаж аваад, хүзүүнийх нь үсийг сэргээж янзлаад авч одлоо. Том гэгчийн тарвага байсан тул би ч яах вэ, тарвагаа бариад найз нар дээрээ маадгар очив. Ямар урхинд орсон тарвагыг би буудчихлаа гэж хэлэлтэй биш дээ. Намайг тарвага хэрхэн агнасныг харцгаа даа, хулхиар нь оруулж, хулхиар нь гаргасан байгаа биз дээ. Тарвагыг яг ингэж л агнах ёстой юм гэж өөрийгөө рекламдаж гайхууллаа даа. Миний нөхдүүд ямар том тарвага вэ, чи мөн ч мэргэн бууджээ. Ёстой хулхиар нь буудсан байна шүү гэгцгээн тэр оройжин л миний мэргэн буудсаныг шагшин магтацгааж билээ.

Үүнээс хойш хэдхэн хоногийн дараа долдугаар сарын сүүлчээр юм сан би сонгогдсон тойрогтоо ажиллахаар Улаанбаатараас Хөвсгөлийг зорин гарлаа. Нар зөв тойроод явахад хамгийн эхэнд байдаг сум нь Баянзүрх юм. Тэнд товлосон цагаасаа өмнө очиход - Гишүүн ээ та энэ хооронд юу хийх вэ гэгцгээж байна.

Тэгэхээр нь би хүрхрэн дээр очоод ирье гээд явлаа. Баянзүрх сумаас доош

таван км уруудаад “Ушир”-ийн хүрхрээ байдаг юм. Тэнд очлоо. Хүрхрээ зургаан метрийн өндрөөс доош буудаг юм. Тэнд очоод загас барихаар дэгээгээ гаргаж шидлээ. Сайхан сайхан загаснууд хорхой хүрэм нааш цааш шумбах нь хэдийгээр харагдах авч сумын төвд ойрхон байсаар бүр хашир суусан тул баригдах янз алга. Би загасны бүх хэрэглэлээ гаргаж ирэн янз бүрийн дэгээ сольж үзээд ч тус нэмэр болсонгүй. Нэг ч загас барьж чадаагүй тул дахиад гуравхан удаа дэгээ шидэж үзээд болихоор болж, эцсийнхийг нь шидтэл нэг загас баригддаг юм байна. Би ч уургаа татаж гарлаа. Дэгээ минь уурганыхаа үзүүрт хүрэх агшинд нөгөө загасаа алдагдчихав уу даа гэмээр болоход нь харамстал загас харин таван метрийн цаана булгиж харагдав. Урьд нь загасчилж явсан хэн нэгэн дэгээнд орсон загасаа утастай нь алдсан байсныг нь би утаснаас нь дэгээдчихсэн юм байж. Утасны үзүүрт нэг том зэвэг өлгөгдчихсөн булгиж байх нь тэр. Тэгэхээр нь уургаа тавиад уурганыхаа үзүүрт дэгээдүүлсэн тэр утаснаас татахад зэвэгч гарт баригдав. Түүнийг нь би татаж гаргаад “азны юм” гэж амандаа үглэн гол ус минь нэгэнт хишгээ хайрлаж байхад... гэж бодлоо. Урхинд орсон тарвага бууддаг шигээ утсанд дэгээдүүлсэн загас бариад баярласан гэдэг жигтэйхэн.

Энэ дашрамд цагдаагийн зарлан дуудах хуудсаар цагаан загас шарахаар галаа асаасан тухай өгүүлье.

Утсанд дэгээдүүлсэн загасаа шарахаар гал асаахыг завдав. Би загас барих бодолгүй явсан тул юухан хээхэн ч дутагдаж байлаа. Тэр өдрийн бороонд мод, гишүү бүгд норсон байсан тул гал асаахад бэрхшээл учрав. Гал асаах цаасны тасархай ч байхгүй нь загас барихаас ч илүүтэй намайг зовоох шинжтэй болж иртэл ашгүй УАЗ-469 машин дэргэд минь ирж тормозлон зогсов. Машинаас цагдаагийн дүрэмт хувцастай бүдүүн бор залуу, энгийн хувцастай нэгэн залуугийн хамт бууж ирсэн нь Улсын Мөрдөн Байцаах Газрын ажилтан, ахмад Буян-Өлзий гэгч байлаа. Чухам яах гэж алс холоос ийнхүү зорьж ирсэн юм бол доо гэж бодох зуурт надад хандан нэгэн хуудас сарвайдаг юм байна. Юу юм бэ? гэвэл “Зарлан дуудах хуудас” гэлээ. Ямар учиртай зарлан дуудах хуудас вэ? гэж асуухад таныг “Улаанбаатарт Улсын мөрдөн байцаах газарт очуулах дуудлага юм” гэлээ. Тэгээд бас нэг бичиг үзүүлсэн нь надад “эрүүгийн хэрэг үүсгэсэн” прокурорын тогтоол байв.

Цагдаагийн дүрэмт хувцастай бүдүүн залуу Мөрөнгөөс Хатгал хүртэл намайг дагасан ажээ. Би гал ноцоох гээд ядсан байсан болохоор нөгөө зарлан дуудах хуудсаар нь тэр хоёрыг харсаар байхад нь гал асаагаад

тавьчихлаа. Галаа дүрэлзтэл асаасны дараа загасныхаа гэдсийг цэвэрлээд уулнаас түүсэн мангираараа хачирлан амталж, сайхан шараад нөгөө хоёрыг дайлтал “идэхгүй” гэцгээдэг юм байна. Яагаад гэхэд “таныг одоо хот руу авч явна” гэж шамдуулав. Хариуд нь

- Би явахгүй ээ, надад хийсэн гэмт хэрэг, иймээ тиймээ юм байхгүй. Би та бүхнийг хэний зараалаар юу хийж явааг мэдэж байна гээд гүрийчихлээ. Би ч яах вэ загасаа тааваараа идэж аваад сонгогчидтойгоо уулзахаар хөдөлсөн билээ.

Улаан—Уул, Рэнчинлхүмбэ, Хатгалаар орж, тойргоо бүхэлд нь тойрон явсаар хамгийн сүүлд Мөрөнд очиж телевизийн ярилцлагад оролцоход нэг хүн надаас

- Гүндалай гуай төвийн сонин хэвлэлд таны талаар Цагдаагийн зарлан дуудах хуудсыг шатаасан гэж бичжээ. Та үнэхээр шатаачихсан юм уу гэж асуув. Намайг буруутан болгох гэж зориуд бэлтгэсэн асуулт мөн байв. Тэгэхээр нь би үнэнээ хэллээ. Тийм ээ, би авч уншаад гал ноцоох зүйл олдохгүй байсан тул аргагүй эрхэнд гал асаачихсан юм аа. Түүнийг ер нь яах ёстой байсан юм бэ? Жаазанд хийж тавин ханандаа өлгөх, хадгалах ёстой байсан юм уу. Хэрвээ тухайн үед миний гэдэс базлуулсан бол чиг би түүгээр лав арчих байсан шүү. Тэглээ гээд ямар хууль зөрчиж байгаа юм бэ, хүлээх хариуцлага байна уу? гэж телевизээр гарч байгаа гэлгүй сөргөж асуулаа.

Тэр жилийн зун миний хувьд ийнхүү их сонирхолтой өнгөрсөн юм.

Япон. Токио хот



Усанд сэлэх бус, нохой самардаад шоолуулсан тухайгаа бичье.

Би бүр багаасаа л юм бүрийг хийж чадахгүй ч, чадах бүхнээ хийх хэрэгтэй гэсэн зарчмаар явж ирсэн юм. Тийм учраас миний хүүхэд ахуй цагт сурч мэдэж болох бүхнийг л хичээнгүйлэн суралцаж байсан боловч мэдээж тэр бүрийг яахин бүгдийг гүйцэлдүүлж чадах билээ. Тухайлбал би “далай”-н хүүхэд атлаа жинхэнэ техникээр нь сэлэлт хийж сураагүй зөвхөн нохой мэт самарддаг байснаа усанд сэлж сурсан хэмээн эндүүрч

явсан ажээ. Үүнийгээ би Герман оронд очоод мэдэж авсан юм. Герман багш маань надад усанд сэлэхийг жинхэнээр нь зааж өгсөнд ихэд баярлаж явдаг.

1983 онд герман хэлний бэлтгэл ангид суралцаж байх үед бидэнд биеийн тамирын хичээл орж, усанд сэлэх арга техникийг зааж өгөхөөр багш биднийг нэг өдөр усан бассейнд аваачин

- Та нар сэлж чадах уу гэж асуухад нь бүгдээрээ л чадна аа гэж хариулцгаав. Багш тэгэхэд за тэгвэл одоо бүгдээрээ сэлцгээ гээд биднийг чөлөөт сэлэлт хийлгэхээр усанд орууллаа. Хамт байсан монгол оюутнууд бүгд л сэлэлт хийх бус, нохой самардаж гарлаа. Зарим нь бүр живэх шахсан шүү. Үүнийг харсан багш маань биднийг шоолон баахан инээж аваад ингэж сэлдэг юм гээд бүх сэлэлтийг өөрийн биеэр үзүүлэн зааж сургасан юм. Багш бидэнд үргэлжлүүлэн зааж өгөх гэтэл дараагийн долоо хоногт нь 40-өөд монгол оюутнаас дөнгөж хоёрхон нь л очсон байв. Гэсэн ч багш бид хоёртой хичээллэсэн юм. Түүний дараагийн долоо хоногт нь би бүр ганцаараа зогсож байсанд багш надтай хичээллэв. Бүтэн гурван сарын туршид явагдсан хичээлд би ганцаараа суралцаж, усанд сэлэх техникийг багшаараа заалган муугүй сэлдэг болсон билээ. Хэн боловч усанд сэлж сурах хэрэгтэй гэж би боддог. Усанд сэлж сураагүй хүн бүсэлхийгээ хүрсэн усанд орох төдийд л осолтой. Муугаар хэлэхэд бараг л усанд живчихлээ гэсэн үг. Гай дайрч усан дотор нэг л хазгай гишгэх буюу урсгалд хөл алдаж унах юм бол уушиг руугаа ус залгиж, сандарснаасаа болоод дахин залгиж амьсгал авч чадахгүйд хүрдэг. Улаанбаатар болон хот суурин газруудад задгай усан бассейнуудыг байгуулан хүүхдүүдийг усанд сэлж сургах хэрэгтэй гэж би боддог. Би хожим нь зурагтаар гарахад нь харж байгаад нуруугаараа сэлэх, дельфин сэлэлт зэргийг сурсан юм. Ийнхүү усанд сэлж сурснаа их чухал эрдэмд тооцож явдаг.



Lady first—Эмэгтэй хүн түрүүлэх ёстой гэсэн өөрийн бодлоор захиагаа эхлэе. Энэхүү захидлыг хүү минь эхлээд дараа нь охидууд маань уншвал зүгээр санагдана. Аав нь эмэгтэй хүнийг хүндэтгэхийг эрхэм болгодог. Миний хэлэх дуртай үгсийн нэг нь Lady first —эмэгтэй хүн түрүүлэх ёстой гэсэн үг юм.

Бүсгүй хүнийг магтан дуулахсан гэсэндээ би нэг хэсэгтээ хөөрхөн охидууд сэтгэлийг минь хөдөлгөх үест шүлэг, яруу найраг бичих гэж оролдож явсан юм. Би өөрийнхөө санасан зоргоор л биччихдэг байлаа. Уг нь би нэлээд хэдэн шүлэг бичсэнээ уншиж үзэхнээ давгүй болсон мэт санагдахад нь хэрдээ урамшиж, түүнийгээ ганц нэг охидуудад атгуулчихаад баяртай нь аргагүй, хувьдаа бол “яруу найрагч” явлаа шүү дээ. Зарим хүмүүс эмэгтэй хүнийг эрэгтэйгээс дор дутуу хөгжилтэй мэт үзэж ярьж явдаг.

Миний хувьд эмэгтэй хүн амьдралд ямагт түрүүлэх учиртай. Би надтай учирсан эмэгтэй бүхий л зүйл дээр Lady first – бүсгүй минь ямагт түрүүлж байгаасай гэж хүсэж, ийм байлгахыг хичээж ирсэн. Аав нь бүсгүй хүний гоо сайхан нь дотроосоо гэрэлтэж байдаг гэж боддог. Түүнийг нь эрчүүд мэдрэн хүлээн авч, хайр дурлал үүсдэг. Дурлалт хосуудын хоорондох харилцааг (sex) германаар “*liebe machen*, англиар бол *make love*” буюу монголоор “хайр хийх” гэж хэлдэг. Хосууд хоорондоо хайр хийх нь хамгийн нандин зүйл юм. Амьдрал хайр дээр тогтоход хайр хийх явдал чухал үүрэгтэй гэж боддог. Хайр хийнэ гэдэг “хайр”-аас л үүдэлтэй. Бурхнаас заяасан сайхан таашаалыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёр биедээ нэгэн зэрэг төрүүлэн мэдрүүлж, ингэснээрээ аз жаргал эдлэхийг хэлнэ. Эмэгтэй хүнд хаалга онгойлгон зам тавьж өгөх, тэднийг урдаа оруулах, гудамж замын хөдөлгөөн дунд чөлөөтэй талд нь авч гарах, хүнд ачаа барааг нь өргөж туслах зэрэг нь женгельмен хүний наад захын соёл гэж үздэг.

Бүх л эмэгтэйчүүд эрт орой хэзээ нэгэн цагт ээж болцгоодог. Иймд тэднийг ихэд хайрлан халамжлах учиртай. Хүн бүрийн хамгийн эрхэм хүн нь ээж юм. Ээждээ хайртай хүүхдүүд том болоод эхнэрээ хайрладаг. Монголын бүх эрчүүд эмэгтэй хүнийг үнэн сэтгэлээсээ хайрлаж, хамгаалж, хүндэтгэж яваасай гэж аав нь хүсдэг.

Амьдралын туршид хүмүүст хоёр зүйл маш чухал байдаг. Энэ нь хүнийг хайрлаж, хүнээр хайрлуулах, өөрийгөө бусдад хэрэгтэй гэдгийг мэдрэх, мэдрүүлэх явдал билээ.

Би Үлэмжийн чанар дууг дуулж клип хийлгэж ч амжлаа. Догшин хутагт Данзанравжаа маань энэ дуугаараа зөвхөн бүсгүй хүний өнгө зүс тэргүүтэн үзэмж төгсийг магтан дуулсан төдий биш ажээ. Гүн гүнзгий утга агуулга нь гэгээрч ухаажсан буюу дотроосоо гэрэлтэн гийсэн хүний нүүр царай өнгө тунамал толь лугаа болж, бие цогцос нь ч мөн ариусдаг

болохыг хэлжээ. Буян ихтийн царайнаас бурханы гэрэл гэрэлтдэг гэсэн манай ардын үг үнэн болохыг гэрчилнэ. Иймд үлэмж үзэмжтэй байхыг гэгээрч өөрийн доторх бурханы гэрэл гэгээгээ цацрааж байхыг өгүүлсэн нэгэн ёсны сургаал номлол мөн ажээ. Иймээс Үлэмжийн чанарыг дуулахад 1000 цагаан шүхэрт уншсантай тэнцэх хүчийг олно гэцгээдэг бөлгөө.

Аав нь “Гэртээ ирлээ”, “Дөрвөн настай халиун”, “Эхийн тухай дуу” зэрэг дуунуудыг дуулж заримд нь клип хийлгэсэн нь их сайхан болсон билээ. Анама гэдэг казак ардын дуу ч дууллаа.

Аав нь найзынхаа үерхдэг охиноос болж булдруу болтлоо зодуулсан тухайгаа бичье. Нэг л мэдэхэд бид сурагч ахуй цагийнхаа хамгийн сүүлчийн жилтэй золгосон байлаа. Аравдугаар ангид орсон жилдээ манай ангийн хөвгүүдийн ихэнх нь үерхдэг охинтой болсон байв. Надад таалагддаг хөөрхөн охидууд зөндөө байсан ч би ер нь охидуудаас их ичдэг байсан болохоор хэнтэй ч үерхсэнгүй. Ихэнхдээ л өөрийн найз Даваабаярыгаа үерхдэг охинтойгоо уулзахад нь хамтдаа явдаг, очоод хүлээж зогсдог болов.

...Эх орон ч дууддаг юм байна. Хөвгүүдийг нь цэрэг татлагад хамруулан үзлэгт орууллаа. Ингэж жинхэнэ эрчүүд болцгоосноо мэдэрцгээсэн юм. Цэрэг татлага, конкурс ид явагдаж, аймгийн төв Мөрөнд бид ирцгээлээ. Тиймээс түүгээр л нэг эр цэргийн албанд тэнцсэн аавын хүүхдүүд хөлхөлдөн хөл хөдөлгөөн ихтэй байсан үе.

Би тэр үед Эх орноо хамгаалах эр цэргийн албанд эрүүл мэнд, эрдэм чадал, эрэлхэг зоригоороо бүрэн тэнцсэн байсан хэдий ч ариун номын мөр хөөн алсын замд дөрөөгөө жийх болсон тул ээжтэйгээ хамт хүргэн ах Төмөрийндөө хүрэлцэн ирсэн байлаа. Ээж маань баахан борц аваад оччихсон, надад хоол хийж өгөх ажилтай, намайг нэг ёсондоо “дасгалжуулж” явсан билээ. Даваабаяр болон түүний найз охин Эрдэнэчимэгтэй гурвуулаа Мөрөнгийн төвөөр явцгааж байгаад орой Эрдэнэчимэгийг ахынд нь хүргэж өгөхөөр боллоо. Тэдний ахынх Мөрөнгийн төвөөс их хол зайтай гэр хороололд байдаг байв.

Тэр орой бид хэд сонин сайхан зүйл ярилцан зугаатай явцгааж байтал гэнэт урдаас дөрөв таван залуучууд гарч ирэх нь тэр. Биднийг хөдөөгийн хүүхдүүд болохыг мэдсэн үү, маргааш цэрэгт явах болохоор биднийг ямар таньж мэдэх биш гэсэндээ тэр үү, ширүүхэн явцгаасан тэд биднийг зогсоогоод “та нар юу юм бэ ” гээд хатуухан хандах шинжтэй болоод явчихлаа. Даваабаяр маань бидний дунд хамгийн өндөр нь байсан тул

шууд л түүн рүү эхлэн дайрч, “чи юу юм бэ” гээд цохиод авлаа. Даваабаяр ч өөдөөс нь цохисонд тэд бүр гаарч, дахин дайрахад нь Даваабаяр эргэн зугатлаа. Түүний араас бид зэрэг шахам гүйцгээлээ.

Аав, ээж хоёрын минь бусдад тусламтгай зан чанар надад илүүтэй “өвлөгдсөн” юм байлгүй, гүйж яваад нэг эргэж харахад миний хойно Эрдэнэчимэг хоцорчихсон байхад нь би түүнийг хөтөлж, гүйхэд тэр бариу юбкатай тул гүйж чадалгүй унахыг шахав. Би энэ зуурт түүнийг дээш татан босголоо. Цааш хамтдаа гүйхэд тэр дахиад л бүдэрч газарт унах гэхэд нь би мөн босгохдоо “түүнийг ганцааранг нь үлдээж болохгүй” гэж бодов. Ийнхүү баарцаглаж явтал залуучууд бид хоёрыг гүйцэж ирээд над руу дайрдаг юм байна. Би эхлээд тэдэнтэй чадлынхаа хэрээр зодолдсон боловч харанхуй шөнөөр дөрөв таван залуучууд бүлэглэсэнд аргагүй хүчин мөхөстөв. Тэд намайг унаган “пид пад, тас түс” дуугаргаад л цохиж өшиглөж, энд тэндгүй булдруу болголоо. Би ч яах вэ нэгэнт дийлэхгүйгээ мэдсэн тул толгой, төмсгөө л хамгааллаа даа. Гэтэл чимээ шуугиан гарч хэсэг хүмүүстэй хамт Даваабаяр хүрээд ирлээ. Би гэдэг нэг их зодуулж, нүдүүлсэн нөхөр газраас шороо тоосоо гэвсөөр босохдоо уур минь хүрч, дотроо “хүний найз охиноос болж ингэж булдруу болтлоо зодуулах гэж” хэмээгээд Даваабаяр энэ охиндоо хайргүй юм байна даа, найз охин нь энэ явдлаас болж Даваабаярт гомдсон байх, би байсан бол найз охиноо орхиод хэзээ ч ингэж ганцаар зугатан гүйхгүй гэж бодлоо. Сүүлд тэр хоёр үерхэхээ болиход нь би арга ч үгүй биз дээ гэж түүний найз охиныг өмөөрөв. Гэтэл хожим Эрдэнэтэд ажлаар явж байхдаа тэд айл гэр болон олон хүүхэдтэй, эвтэй сайхан амьдарч байгааг нь хараад дотроо ихэд олзуурхан баярлаж билээ.

Япон Токио хот



Би багын их авъяастай төдийгүй онцгой тэвчээр хатуужилтай, зорьсондоо заавал хүрдэг сэтгэлийн их тэнхээтэй хүүхэд байсан юм. Гэхдээ би бүхий л талаараа ямар ч өө сэвгүй, алдаа дутагдалгүй хүүхэд байсан гэвэл худлаа. Тавдугаар ангид байхдаа би анх удаа тамхи татаж үзсэн юм.

Тамхиа татаад сууж байтал Дорж ахдаа баригддаг юм байна. Ах маань надад насны сургамж өгснөөс хойш би одоо хүртэл тамхи огт татаагүй. Би ахдаа “дахин тамхи татахгүй” гэж амалсан тул тамхинд ойртоогүй. Амлалт өгөх, амалсандаа хүрэх нь хөвч тайгын хүүхдийн хувьд зайлшгүй зүйлийн нэг, тэгээд ч жинхэнэ эр хүний зан чанар байх ёстой гэсэн байр суурь дээр би хатуу зогсдог байв. Нөгөө талаар хүүхэд ах захаа мэддэг ахмад хүний үг сургаалыг сонсож, дагадаг байх учиртай гэж боддог байлаа. Үүнийг бичсэн нь хүүхдүүд эрэгтэй эмэгтэй ялгалгүй тамхи татах болсон өдгөө цагт болохгүй гэсэн сургамж өгөх зорилготой юм.

Би хүүхэд залуустаа хандан архи ууж, тамхи татахыг эрс цээрлэж явахыг захия. Архи уух, тамхи татах нь чамирхал биш, мода ч биш, гоё ганган зүйл бүр огтоос биш, харин эрүүл залуу оюун ухаан, бие организмаа хордуулж, хохироож буй явдал болохыг эртхэн ойлгож авбал сайн. Иймд анх удаа архи ууж баларсан талаараа бичиж та нар ингэж болохгүй шүү гэдгийг сануулья.

Бид сурагч ахуй цагтаа төмс хураах ажилд явдаг юм байна. Ажил дуусаад буцах болоход бидэнд ажлын хөлс өгөв. Бид нэгэн ачааны машинаар гэрийн зүг хөдөлцгөөлөө. Гэтэл Даваабаяр, Лхагвацогт хоёр л голлон санаачилсан байх, манай ангийн хөвгүүд “бүгдээрээ архи ууж үзье, цагаан архи авч ууцгаая” гэгцгээдэг юм байна. Гэнэтийн ийм үгэнд гайхаж, миний нүд орой дээрээ гарах дөхсөн боловч найз нөхдийнхээ саналаас татгалзаж чадсангүй, бас сониуч зандаа хөтлөгдөн. хоёр хүүхэд дундаа нэг шил цагаан архи авъя гэхэд нь зөвшөөрлөө. Ярилцсан ёсоор хүүхэд бүр 14 төгрөг гарган сумын төвийн дэлгүүрээс цагаан архи худалдан авцгаалаа. Би ангийнхаа чухам хэнтэй нь ч билээ дээ мөнгөө нийлүүлэн нэг шил архи дундаа авлаа. Зам нэлээд хороосны дараа авсан шил архиа хоёр хоёроороо хувааж ууцгаав. Багш ч яах вэ машины кабинд суусан тул бидний энэ явдлыг мэдсэнгүй. Яг бүгдийг ууж дуусгасан эсэхийг сайн санахгүй байна, согтоцгоолоо. Заримынх нь ааш авир хувирч, агсан тавих аятай юм боллоо. Зарим нэг нь учиргүй уйлдаг юм байна. Энэ мэтээр бүгдэд нь ямар нэг байдлаар өөрчлөлт орлоо доо.

Бидний машинд замаас гар өргөн суусан нэг хүн буухдаа багшид “кузов дүүрэн согтуу хүүхдүүд” гэж хэлсэн ажээ. Удахгүй машин зогсон багш гарч ирээд ихэд хилэгнэн уурлаж, “Та нар бүгдээрээ буугаад ирцгээ” гэсэн команд өгсөн хэдий ч тэр үед бууж очих тэнхэлтэй хүүхэд нэг ч

байсангүй. Багш энэ бүхнийг намайг толгойлсон биз гэж бодов бололтой над руу их сүрхий харлаа. Харц нь “чи бас толгойлсон уу” гэж асуух шиг болоход би өөрийгөө бодоод “Багш аа би энэ удаад ямар ч буруугүй шүү” гэж хэлж болох байсан ч найз нараа хайрлан таг дуугүй л байлаа. Багш уурлан бухимдсаар л байв. Байсхийгээд л “хэн архи уух санаачилга анх гаргасан юм бэ, хэн архи авч өгсөн бэ” гэж асуусаар байсан билээ. Арга ч үгүй биз дээ есдүгээр ангийн хүүхдүүд архи ууцгаасан юм хойно. Дараа нь багш биднийг яагаад архи уух болсон талаараа бичээд өг гэв. Миний хувьд “Намайг хүүхдүүд “харамч” гэж хэлэх байх гэж бодоод архи уусан” гэж бичээд өгчихлөө. Зарим хүүхэд “би мөнгөтэй болсон тул архи уусан” ч гэх шиг, бусад нь юу юу гэсэн байлаа даа, ямар ч байсан толгой дараалан нэг нэг учир шалтгаан бичсэн байсан юм даг. Энэ цагаас хойш би архи уугаагүй ээ. Аав минь архи уухаараа шартаж бөөлждөг тул огт уудаггүй байв. Би аавыгаа дууриасан бололтой. Архи гэгч ундаа надад ерөөсөө зохидоггүй тул би түүнийг уугаад шингээдэггүйгээс одоо ч аргагүй нөхцөл тулгарвал гурван хундагыг л ууна. Найз нөхөдтэйгээ дарвиад ганц, хоёр литр пиво уухаас хэтэрдэггүй. Ямар ч тохиолдолд ухаан санаагаа алдтал унан тустлаа уухгүй гэсэн зарчмыг баримталдаг. Энэ бүхнийг би яагаад бичиж байгааг хүүхдүүд минь ойлгож байгаа байх. Тамхи архи гэгч хортой зүйлсээс хүмүүс тэр тутмаа залуучууд холуур явах учиртай. Тамхи таван нас, архи арван нас хороодог болох нь амьдралд батлагдсан аюултай хортой эд, идээ... Их эзэн хаан маань савнаасаа бусдыг дийлдэг сархдын тухай 40 нас хүрээд дөнгөж амс, 50 нас хүрээд тавьж хүрт... гэх мэтчилэн нас заан амс, хүрт гэснээс бус түүнийг айраг мэт тааваараа уугаарай гэсэн юм огтоос байхгүйг анзаарч болгоох учиртай.

Япон Токио хот



Миний буюу эзэн Чингисийн Монгол агуу эх орон. Эх орноосоо алс тэртээд Англид амьдарч, сурч буй хүү, охин хоёртоо аав нь төрөлх нутгаасаа захидал бичиж сууна. Мөн гадаадын улс оронд амьдарч, сурч, ажиллаж байгаа эрхэмсэг монгол залуустаа бас хандаж байгаа юм шүү. Би тасралтгүй арван гурван жилийн туршид харийн оронд амьдарсан билээ. Тэнд би ихийг үзэж, сурч, мэдэхийн зэрэгцээ мөн эх орон, ард түмэнтэй байхын сайн сайхныг илүү ойлгосон юм. Эх орноосоо хол удсан болохоор би эх оронтой хүний аз жаргалыг бусдаас эрт илүү мэдэрсэн билээ.

Монгол эх орон гэдэг зөвхөн өргөн уудам газар нутаг төдий бус энэ сайхан орондоо эзэн болсон ард түмэн юм гэдгийг Монголдоо суурьшин амьдрах болсон үе, Их Хурлын гишүүнээр сонгогдсон цагаас илүүтэй мэдэх болсон юм. Эх орон минь элэг зүрхнээс минь байнга уяатай байдаг.

Би хүүхэд байхаасаа л Монголынхоо түүх болон эзэн Чингис хааныхаа тухай ихэд сонирхон уншдаг байлаа. Монголын түүх, Чингис хааны тухай эрхэм чухал үнэнийг Энэтхэгийн нийгэм, төрийн нэрт зүтгэлтэн Ж.Неру “ЕРТӨНЦИЙН ТҮҮХИЙГ СӨХӨН ҮЗВЭЛ” гэж нэрлэсэн номондоо ингэж бичсэн байдаг юм. Үүнийг хүүхэд залуус та нартаа зориуд сонирхуулж байна.

Монголын эзэн хааны үед Европ тив удтал Азийн колони мэт байсан бөгөөд одоогийн Европын олон ард түмэн тэрхүү Азийн булаан эзлэгчдээс гаралтай юм. Ази тив тэр чигтээ монголчуудын эрхшээлд орсон мэт байв. Нийт Ази төдийгүй Европын хагас ч тийм байдалд байлаа. Гэнэт гарч ирэн дэлхий дахиныг яах ийхийн зуургүй ийнхүү эрхшээлдээ оруулсан тэд хэн гэгч гайхалтай хүмүүс байв аа, тэд бол монголчууд. Монголчуудыг өөрийн гэсэн өвөрмөц амьдралтай, өвөрмөц маш нарийн зохион байгуулалттай улс байлаа. Монголчууд тооны олноор биш харин сахилга, зохион байгуулалт сайтай, эр зоригтой, моринд гарамгай байсныхаа хүчинд тулалдааны талбарт их ялалт байгуулж байв. Бас Чингисийн цэргийн жанжны гайхамшигт урлагийн хүчээр тэд ийнхүү ялалтанд хүрч чадсан байна.

Чингис бол түүхэнд гарсан суут ухаантан, жолоодогч эргэлзээгүй мөн. Түүний дэргэд Александр Македонский, Цезарь хоёр юу ч биш.

Чингисийн удмын Сүбээдэй тулалдааны талбарт цэрэг дайны асуудлыг гарамгай сайн мэддэг нь харагдаж, түүний дэргэд Европын цэргийн жанжнууд шушимаар хүүхэд адил байв.

Монголчуудыг хэн ч зогсоож чадахгүй байлаа. Монголчуудын арми

нэг ч удаа ялагдаж байгаагүй ч 1242 онд монголчууд дорно зүг эх нутгаа чиглэн буцжээ. Тэднийг буцах үед л Европ дахин амьсгаа аван уужирч тайвшрав гэж Ж.Неру бичжээ. Ийнхүү дэлхийг донсолгож явсан ард түмэн бол монголчууд. Дэлхийг эзэлж байсан түүх бол биднийх юм. Хөмөн гутлаараа дэлхийг тамгалахдаа монголчууд хүн төрөлхтөний түүхийг сэлмээр сийлж явсан байдгийм.

Амсхийж аав нь энэ зуур хөгжилтэй түүх өгүүлье. “Ам цуурдаг гэж буруутгагдан арай л үлдчихэлгүй Герман явсан” талаараа бичье.

Би бодсон санаснаа чөлөөтэй илэрхийлдэг хүүхэд байлаа. Оросын зохиолч Б.Яний “Бат Хаан” гэдэг номыг уншиж манай эзэн Чингисийн цэргүүд Москваг эзлэн авч, галдан шатааж явсан тухай олж мэдсэн юм. Москва тэр үед ач холбогдол багатайхан жижигхэн тосгон байсан юм билээ. Би түүхийн хичээл дээр эзэн Чингисийн аян дайны тухай ярилцах үеэр багшдаа Москваг Бат хааны цэргүүд галдан шатааж байсан юм билээ гэхэд багш Цэрэндорж маань битгий худлаа яриад байгаарай, тийм юм байхгүй гэхэд нь Б.Яний “Бат Хаан” зохиолд тэгж бичсэн байна лээ гэж хэлэв. Багш “Чи ер нь дандаа л янз бүрийн юм ярьж явдаг, амаа тат, олон долоон юм ярихын хэрэггүй” гэж намайг загнав. Би тэгэхэд нь гайхаад өнгөрсөн боловч социалист нийгэмд иймэрхүү юмс ярих нь хориотой байсныг хожим нь мэдсэн юм.

Дээр дурьдсан зүйлүүд нөлөөлсөн юм болов уу даа, герман хэлний бэлтгэл ангид орсон жил Г.Лувсан гэдэг шиг санаж байна, багш намайг өрөөндөө дууддаг юм байна. Тэр надад хандан Гүндалай би чиний хувийн хэрэгтэй танилцлаа. Чамайг “арван жил”-д байхдаа элдэв цуу яриа ярьдаг, сурагчдыг зохион байгуулж, багшийнхаа эсрэг үйл ажиллагаа явуулдаг... бас их зөрүүд гэж бичсэн байх юм. Гадаадад явсан хойноо юу гэж цуурч, ямар үйл ажиллагаа зохион байгуулах вэ, чи ер нь Германд явах хэрэг байна уу даа? гэж надад хэлэхийн сацуу бас асуулаа. Тэгснээ чамайг гадаадад явуулах боломжгүй хүн байна даа гээд айхтар сүрхий харж билээ. Би тэгэхэд нь багш аа, та миний зөвхөн дутагдалтай талыг л олж харахыг хичээжээ. Би нэг удаа ногооны талбайд ажиллаж байхдаа багштайгаа ялихгүй зүйлээс болж маргалдан ам зөрсөн юм. Тэр үед миний зөв байсан л даа. Багш маань түүнээс болоод миний тухай тааруу зүйл биччихсэн байх. Надад олон сайн, сайхан чанарууд бий. Би арван жилийн турш тасралтгүй онц дүнтэй суралцсан, бүх хичээл болон спортын бүхий л уралдаан, тэмцээний аварга

болж шагнал хүртдэг байлаа гээд л амжилт ололт бүхнээ нэг нэгэнгүй ярьж өглөө. Тэгэхэд Г. Лувсан багш хэсэг зуур бодолхийлэн хариу юу ч хэлэлгүй, таг дуугүй сууж билээ. Харин Чой.Лувсанжав багш маань намайг өмөөрч, хүүхэд ер нь ямар л хортой зүйл хийж шалиа аж дээ, энэ хүүхдийг ингэж зовоох хэрэг байна уу гэж хэлэхэд нь би үнэхээр их баярласан юм. Түүнээс хойш багш нар хүүхдийн зан чанарыг сэтгэлийн хөдөлгөөнөөрөө тодорхойлон хувийн хэрэгт нь тэмдэглэж үлдээх нь хожмоо ч хар мөр дагуулсаар байдаг юм байна гэж би харамсан бодсон сон.

Эх орондоо байхдаа аав нь монгол хүн болж төрснөөрөө илүү их бахархдаг юм. Монгол орны хойморт цэлийх их далайн хөвөөнд аав нь төрсөн билээ. Хөвсгөл аймгийн Хатгал миний унасан газар, Хөвсгөл нуур угаасан ус минь юм. Аав нь бага насаа Хатгал хотхондоо өнгөрүүлсэн. “Хамгийн бяцхан эх орон ч хамгийн их хайранд хангалттай уудам. Жижигхэн байх тусмаа тэр зүрхэнд ойр” хэмээсэн эх нутагтаа хайртай хүний эрхэм үгийг германчууд хэлэх дуртай байдаг. Хатгал миний багад ажил хөдөлмөр ид өрнөн, их амьдралын нүргээн аагилан байдаг жинхэнэ “хөөрхөн” хот байсан билээ.

Миний амьдрал Хөвсгөл хэмээх гүн, цэнгэг нууртай салшгүй холбоотой. Тийм ч учраас аав, ээж минь надад ГҮНДАЛАЙ гэдэг нэр өгсөн юм. Аав нь хүүхэд ахуйдаа зун цагт “Далай ээж”-ийнхээ усанд өдөржин шумбаж өнждөг байлаа. Бас загас барина. Харин өвөлдөө нуурын мөсөн дээр тэшүүрээр, ууланд гарч цана, чаргаар гулгана. Нутгийн минь агаар цэвэр ариун тул би хүүхэд байхдаа хамрын ханиад ч хүрэлгүй өссөн юм. Хөвсгөл нутаг өвөлдөө ихээхэн хүйтэрдэг ч хүүхдүүд нь өлчир чийргээрээ гайхуулдаг.

Миний бага нас “Далай ээж”-ийнхээ эрэг дээр дэндүү зугаатай бас жаргалтай өнгөрсөн дөө. Хамар нэвт сэнгэнэм эрүүл тунгалаг агаараар амьсгалан их усан тэнгэртэй хаяа нийлүүлэн цэлийх хязгааргүйг харах агшинд хэний ч сэтгэл аяндаа уужирдаг. “Ямархан хувь заяагаар ийм нутагт төрдөг бол оо” гэж Хөвсгөлд анх хөл тавьсан миний нэгэн нөхөр дуу алдсан юм.

Хүн угаас төрөлх нутаг ус, эцэг эхээ сонгодоггүй, харин хувь заяагаа л дагадаг ажээ. Аав нь нутгийнхаа тухай дуутай болох сон гэж хүссээр явж, ГҮН ЦЭНХЭРХЭН ДАЛАЙ ИЖИЙ гэдэг дууны үгийг бичсэн юм. Хөгжмийн зохиолч С.Гантөр аяыг нь хийсэн нь сонсголонтойяа сайхан

болсон тул нутгийнхны минь сэтгэлийг бүр хөдөлгөж орхисон. Харанга хамтлагийн дуучин Х.Лхагвасүрэн дуулж үнэхээр амьдруулж чадсан. Үлэмжийн чанар дууг нэг удаа дуулахад 1000 цагаан дарь эх уншсантай тэнцэнэ гэдгийн адил ГҮНЦЭНХЭРХЭН ДАЛАЙ ИЖИЙ дууг минь дуулсан хүний хийморь лавтайяа сэргэнэ гэж би боддог юм. Аав нь продюссараар ажиллан Ертөнц продакшнаар энэ дуундаа клип хийлгэж амжсан. Далай дэлгэц дүүргэн цэлэлзээд дэргэд минь л байгаа мэт санагдах сайхан клип болсон. Сэтгэл зүрхнийхээ угаас хийсэн болоод л тэр байх, их сайхан дуу, клип болжээ гэж хүмүүс шагшин магтсан. Унасан газар, угаасан ус юугаа аав нь ийнхүү дуунд мөнхжүүлж байгаа юм.

Дуу маань ийм үгтэй.

ГҮН ЦЭНХЭРХЭН ДАЛАЙ ИЖИЙ

Хөвсгөл далайн хөвөөнд хувь заяагаар төрж дээ

Хөл нүцгэн гүйлдсээр хүүхэд насаа өнгөрүүлж дээ

“Эх болсон зургаан зүйл хамаг амьтан”- ыг ундаалсан

Эзэн Монголын рашаан минь - Далай ээж минь

Ижийн минь ээж далайдаа даатгаж дээ

Аавын минь аав тэнгэртээ залбирч дээ

Эр биеийг минь гүйцээж, энх тунхтай золгуулж дээ

Ижий цэнхэр Далай минь - эзэн Монголын амин сүнс минь

Уул уулсын эзэн Хорьдол сарьдаг минь

Ус усны хатан гоо эх далай ээж минь

Энэ Монголдоо ганц, эх дэлхийдээ ганцхан

Гүн цэнхэрхэн далай ижий минь

Мөнх хөх тэнгэрээ тольдсон мөнхийн тэнгистээ мөргөө

Мөнхөд орших нутгийн минь мөнхийн амьдрал минь

Мөнх тэнгэрийн хүчин дор мөнхөд цэлэлзээрэй

Ижий цэнхэр Далай минь- эзэн Монголын амин сүнс минь

Уул уулсын эзэн Хорьдол сарьдаг минь

Ус усны хатан гоо эх далай ээж минь

Энэ Монголдоо ганц, эх дэлхийдээ ганцхан

Гүн цэнхэрхэн далай ижий минь

Гүн цэнхэрхэн

Гүн цэнхэрхэн

Гүн цэнхэрхэн далай ижий минь

Аав нь Монголынхоо бахархам түүх, монголчуудынхаа бахархал дүүрэнхувь заяагмагтан дуулахыг хүсдэг туляруу найрагч З.Түмэнжаргалын үг, хөгжмийн зохиолч Б.Шаравын ая “Монголын тал нутаг” дууг дуулахдаа зохиогчдынх нь зөвшөөрлийг авч

Мөнх л тэнгэрийн хүчин дор

Эзэн Чингис минь ивээсэн

Энх л саруул голомтондоон

Эгэл олноороон жаргасан

Ямар агуу юм бэ миний Монголын заяа

Яасан гэгээн юм бэ Монгол түмний минь ирээдүй

гэсэн бадгийг нэмж би өөрөө дуулсан юм. Хүмүүс энэ бадгийг дагаж дуулцгаасан нь бодвол тэдэнд таалагдсанаас тэр биз ээ.

Монголын төлөө цохилох зүрх бидний цээжинд булгилаастай тул Монгол хэмээх нэгэн нэрийг ертөнцийн чихнээ дуурсгах сан гэж би байнга бодож явдаг. Бидний ирээдүй бол та нар. Монголын маань гэрэлт ирээдүй та нарын гарт. Та нарын оюун ухаан, эрч хүч, ажилсаг гараар Монголд их бүтээн байгуулалт, шинэчлэлт өөрчлөлт хийгдэнэ гэдэгт би огтоос эргэлздэггүй. Монгол хүн явсан газар бүртээ нэр алдраа дуурсгадаг. Эрүүл саруул, эрдэм боловсролтой монгол хүн улс эх орны чимэг төдийгүй хөгжлийн гол тулгуур мөн. Иймд би монгол хүн бүрийн хүчин зүтгэл нийт иргэдийнхээ хөдөлмөрлөх бүтээлч эрч хүчийг Монгол орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхан амьдралын төлөө нэгтгэх нь зүйтэй хэмээн үздэг. Эрхэм монгол залуус аа

Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас

Хүний хүү та нар эрдэм номыг ихээр өвөрлөн

Эргээд заавал ирдэг юм шүү

Эх орон, ижий аав чинь хүлээж байна гэж хэлье

Монгол залуус аа та нартаа итгэж хүлээж байгаа шүү. Та нарын оюун ухаанаар Монгол улс дэлхийг тэргүүлэх болно.

Монгол Эх орноо магтан дуулсаар хэдэн ч захидал бичиж болох боловч үүгээр түр завсарлая.

Улаанбаатар хот - Хөвсгөл аймаг



Аав нь Монгол Арабын Нэгдсэн Эмират улсын Парламентын бүлгийн дарга юм. Бүлгийн даргын хувиар 2007 онд Персийн булангийн орнуудаар явлаа. Аав нь Арабын Нэгдсэн Эмират, Кувейт, Катар зэрэг улсуудаар явсан талаараа сонирхуулъя. Арабын ертөнц надад гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн. Баян тансагаараа гайхагддаг ч эмх цэгц сайтай, архи дарс мансууруулах бодис огтоос хэрэглэдэггүй энэ ард түмний аж амьдрал дууриалал болохуйц санагдсан. Арабуудын хийж бүтээсэн, барьж байгуулсан нь үнэндээ гайхамшигтай. Тус орны газар нутаг үндсэндээ өвс ургамалгүй, чулуурхаг хөрстэй, гол мөрөн байхгүй ч элсэн цөлд шахам битүү цэцэг ургуулсан ард түмэн гэхэд болно. Арабын Эмир аргагүй хаан мэт санагддаг. Ямар утгаараа вэ гэвэл ард олноо амар амгалан амьдралд хүргэснээрээ. Хааны аз жаргал нь иргэдийнх нь амар амгалан амьдрал мөн ажээ. Энэ зуурт манай нэгэн яруу найрагчийн шүлгийн мөр санаанд орж ирэв.

Саудын араб арабчуудын араб...

Саудын араб хаадын араб гэсэн байдгийм.

Бараг л бүгд хаан мэт амьдардаг учраас ингэж бичсэн биз ээ.

Арабын Нэгдсэн Эмират улсын эрхэм дээд Эмирийн хүү Шейх 2007 онд манай Монголд тэр тутмаа миний төрсөн нутаг Хөвсгөлд ирсэн юм. АНЭУ-ын Шейх нутаг усны сайхныг шилэн байж амрахаар ирэхдээ Хатгалд

бууж миний бяцхан амралтын газрыг сонгосон билээ. Хааны хүү хаан тэрбээр Хөвсгөл далайн цэнгэг ариун уснаас шуудхан хутган уусан юм. Уг

нь Шейхын хоол хүнс Монголоос юу ч худалдаж авахааргүй Эмиратаасаа бэлтгэгдэн хангагдсан байсан ч тэр миний нутгийн рашаан болсон уснаас ууж, монгол хонины мах амтархан зооглож, агаар, байгалийн сайханд нь сэтгэл тэнийн амарсан юм. Газрын диваажин Хөвсгөл нутаг түүний сэтгэлд мөнхрөн үлдсэн гэдэгт би эргэлздэггүй. Аав нь Шейхтэй хамт авахуулсан зургаа та нартаа илгээж байна.

Булангийн орнуудаас Катар улсыг сонгон сонирхуулья. Персийн булангийн сувд гэгддэг Катар. Нийслэл Доха. Ажиллах хүчин дутмаг, байгалийн баялгаар ядуу катарчүүд сувд олборлон амьдралаа залгуулдаг байсан бөгөөд 1940-өөд он хүртэл Персийн булангийн хамгийн ядуу оронд тооцогдож байжээ. Гэвч байгалийн хий, газрын тосны их хэмжээний нөөц илэрснээр бүс нутагтаа дээгүүрт орох эрчимтэй хөгжиж буй орон болон хувирчээ. Катар улс ердөө л 570 мянган хүнтэй. Монголын ганц сумын дайтай газар нутаг бүхий боловч бүс нутагтаа тэргүүлэгч орны тоонд ордог байна. Хэдийгээр хүн ам цөөн, хөрс нь үржил шим муутай ч газар доорх байгалийн баялгаа зөв ашиглаж чадвал хөгжиж болдгийн жишээг Катараас харж болно. Кувейт ч мөн адил. Тэнд очсон хүмүүс Катарыг хэдэн жилийн өмнөх Дубайтай зүйрлэн ярьдаг. Катарт бүх шатны боловсролыг үнэгүй олгодог, эмнэлгийн үйлчилгээ үнэ төлбөргүй. Амьдралын түвшин дээгүүр учраас хүн амын тоо хурдацтай өсч байгаа.

Төрөөс чөлөөт зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, иргэдээ хөрөнгөжихийг хөхиүлэн дэмждэг гэх мэт энэ улсаас авах сайн сайхан жишиг зөндөө ажээ.

Зах зээлээ хамгаалах бодлого баримталж, үл хөдлөх хөрөнгө, банк, худалдаа, үйлчилгээний салбарууд, даатгалын бизнес зэргээ хуулиар хамгаалсан байдаг нь ард олноо бодсон бодлого ажээ.

Гадаадын иргэд Катарт үйл ажиллагаа явуулья гэвэл дээрх шаардлагыг харгалзан үзэж, хуульд нь хатуу захирагдах ёстой. Гадныхан хөрөнгө оруулалт хийсэн байсан ч тухайн компани, аж ахуйн нэгжид ажиллагсдын 51 хувь нь катар хүн байх хуультай. Энэ бүхэн Монголд бас хэрэгтэй байгаа юм.

Хайртай шүү, Та нартаа.



Аавын сургаалалт гэж ард олны минь хэлсэн үг аргагүй л үнэн болохыг би биеэрээ үзэж мэдсэн юм. Бага насандаа учрыг нь тунгаан ойлгох чадвар дутаж, сонсох төдийгөөр өнгөрүүлж байсан үгс амьдралд үнэн болохоо нотлох цаг ирдэг юм билээ. Би янз бүрийн юм сонирхдог сониуч гэхүү саваагүй зангаараа манайд унадаг дугуй унаж ирсэн хэн нэгний дугуйг эзэнд нь хэлж нэг, бас хэлэхгүйгээр гэрт хэн нэгэнтэй ярилцаж суух зуурт нь унаж давхидаг байв. Тэгэхдээ том хүний дугуйн дөрөөн дээр нь бүтэн сууж унах гэхээр хөл, гар хүрэхгүйн зовлонтойд хоёр дугуйг нь холбосон төмрийнх нь завсраар хөлөө хийж, дээр нь сууж унах бус дэргэд нь зүүгдэж, морины ганзага мэт явахдаа ичих бус, харин ч нэн бахархалтайгаар жийж, ахиухан газрыг туулж амжих сан гэж мэрийдэг сэн. Гэтэл Ханхад мал тууварлаж явах зун нэг өдөр аавтай ирж уулзсан хүний морийг унах хүсэл яг л дугуй унахтай адил ихээр төрөхөд нь би тэсэлгүй морийг нь гуйж уналаа. Тэр үед би бороо шороотойд мал тууварлаж явахдаа өмсдөг нейлон куртикээ өмссөн байсан нь гай болж, түүний шажигнаж дуугарах чимээгээр морь үргэн намайг авч давхилаа. Хичнээн ч хол газар давхисан юм бүү мэд. Амьтай тэр тутмаа хийморьтой амьтан чинь яаж унадаг дугуйтай адил байх вэ дээ. Би ч түүнийг зогсоох гээд чадсангүй, давхисаар л байв. Сүүлдээ жолоо цулбуурыг нь ч дийлэхээ больж зөнд нь баахан давхиуллаа. Замд таарах зүйлүүд нүдний өмнүүр жирэлзэн өнгөрч, ингэсээр намайг хаана аваачиж хаях бол, энэ ер нь яаж дуусах бол гэсэн бодол толгойд эргэлдэх зуурт ихээ овоолсон төмрийн хажуугаар морь маш хурдтай өнгөрөхөд нь би амжиж хажуу тийш хазайгаагүй бол лав хөл гараа төмөрт хэрчүүлэх байсан биз, ийнхүү би мориныхоо эрхшээлд бүрэн оров. Үргэсэн морь хаашаа ч хамаагүй авч давхисаар нэг их ганга руу дөхөж очих агшинд аавын захиас гэнэт санаанд минь орж ирлээ. Аав минь морь үргэн давхиад дийлдэхгүй үед амыг нь салгаж татах хэрэгтэй. Тэгвэл амархан зогсоож чадна гэж захиж байсан юм. Азаар энэ тухай санаанд минь зурсхийгээд орж ирэхэд нь салгаж татах гэдэг нь яг яахыг хэлдэг юм бол доо гэж бодохын сацуу баруун гар дахь цулбуураа арагш сайн гэгч татаж, харин зүүнийг нь тэр чигт нь сул орхилоо. Морины толгой өөрийн эрхгүй миний баруун гарыг даган арагш харж, урдах замаа харахаа больсон тул тэр арга буюу зогслоо. Ингэж би аймшигт ганганы ирмэгт тулж ирэх үед морио зогсоож чадсандаа баярлахаас өөр аргагүйд хүрэв. Энэ агшинд өөртөө бус алт шиг сургаал айлдсан аавдаа л баярлаж байлаа. Аав минь ямар хэрэгтэй сургаал хайрлаа

вэ. Аавын сургаал алт гэдэг энэ дээ хэмээн залбирсан юм.

ХҮҮХДҮҮДДЭЭ БИЧСЭН ЗАХИДАЛ гэж нэрлэсэн энэхүү номыг уншсан хэн бүхэн зөвхөн өөрийнхөө хэдэн хүүхдэд бичсэн хувийн захиа төдий зүйл биш, Монголынхоо нийт хүүхэд, залуучуудад ханджээ гэдгийг төвөггүй ойлгох биз ээ. Өөрийнхөө амьдралын жишээ, болсон үнэн үйл явдал дээр тулгуурлан бичсэн энэхүү захидлууд Францад залуу хүнийг хэрхэн үнэлдэгийн адилаар Монгол залуу хүн хэрхэн үнэлэгдэх ёстой талаар сургамж болоосой гэсэн эрхэм зорилгыг агуулсан бөлгөө.

Захидлуудаа “Аавын сургаал алт” гэсэн ардынхаа мэргэн үгийн үнэ цэнийг тодотгож, хүүхэд залуус минь аав, ээжийнхээ сургамжит үгсийг сайтар сонсож, амьдралдаа алдаа багатай, амжилт дүүрэн яваарай хэмээн захия.

